

---

# Дэлхий дахинд айлдсан сургаалуудын ЭМХЭТГЭЛ

Боть I

Ли Хонжи

---

## АГУУЛГА

Сингапурын Фалунь Дафа холбоог үүсгэн байгуулах  
ёслол дээр айлдсан Фа сургаал

1996 оны 7-р сарын 28, Сингапур

АНУ-д анх удаа айлдсан Фа сургаал

1996 оны 10-р сарын 5, Сан Францискогийн хойг

Бээжин хотноо болсон Олон улсын туршлага  
солилцох чуулганы үед айлдсан Фа сургаал

1996 оны 11-р сарын 2, Бээжин

## **Сингапурын Фалунь Дафа холбоог үүсгэн байгуулах ёслол дээр айлдсан Фа сургаал**

Ли Хонжи

1996 оны 7-р сарын 28 ~ Сингапур

За, би та бүгдэд сайн харагдахын тулд энд зогсьё. Фалунь Дафа холбоог тал бүрээр дэмжиж ирсэн Сингапурын янз бүрийн салбарын хүмүүст талархал илэрхийлье, мөн Сингапурын янз бүрийн салбарын хүмүүст Фалунь Буддын холбоог байгуулахад дэмжлэг үзүүлсэнд та бүхний нэрийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье. Тэдэнд алга ташицгаая. (Алга ташилт) Буддын холбоог үүсгэн байгуулснаар илүү олон хүн Фа-г олж авах, мөн хувь тавилангийн холбоотой бүр олон хүнд энэхүү Фа-г сурах боломж олгоно, энэ нь улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалагдаж, та бүхний цаашдын бясалгалд болоод нийт хүн амд тустай зүйл хийх таатай нөхцлийг бүрдүүлэх юм.

Би ярих зүйл нэг их бэлдээгүй. Одоо, би энэ чуулганы боломжийг ашиглаад санаанд орж ирсэн зүйлээ л ярья. Би эхлээд Фалунь Гон-ыг танилцуулъя, энэ нь маш урт удаан түүхтэй. Хүн төрөлхтний ертөнцөд соёл иргэншил нэг бус удаа үүссэн гэдгийг бясалгалын хүрээний хүмүүс мэддэг. Хүн төрөлхтний ертөнцөд соёл иргэншил олон удаа бий болж байсан, мөн түүхийн урт хугацааны туршид хүн төрөлхтний ёс суртахуун аажмаар буурч, доройтох үед хүн төрөлхтөн мөхөл рүү ордог. Ер нь бүгд ийм байдаг. Мөн эцсийнхээ шат хүртлээ хөгжихийн хэрээр, материаллаг мутац, оюун санааны доройтол дээд цэгтээ хүрэхэд, хүн төрөлхтний ёс суртахууны үзэл баримталд энэ нь томоохон уналт авчирдаг. Ийм нөхцөл байдал дор, хүн төрөлхтөн мөхөх болдог. Хүн төрөлхтөнд ийм байдал олон удаа гарч байсан, ийм учраас хүн төрөлхтний соёл иргэншил нэг бус удаа оршиж байсан—олон соёл иргэншил гарч байсан. Хүмүүсийн ярьдаг чулуун зэвсгийн үе нэг бус удаа байсан. Хүн төрөлхтөн олон чулуун зэвсгийн үеийг туулсан. Учир нь хүн төрөлхтөн ийм асуудалтай тулгарах үед, хүн төрөлхтний бүх хөдөлмөрийн багаж хэрэгсэл, бүх мэдлэг нь бүгд устдаг.

Та бүгд мэднэ, өнөөгийн хүн төрөлхтний соёл иргэншлийн эхэн үед буюу дөрөв, таван мянган жилийн өмнө, манай дэлхийд их үер болж, Европ дахь

цагаан арьстнуудын соёл иргэншил бүхэлдээ утсан. Мэдээж, үлдсэн эд өлгийн зүйлс нь маш бага үлддэг байсан ч зарим үлдсэн соёлын олдворуудаас түүхийн өмнөх үеийн зарим зүйлсийг харах боломжтой байдаг. Жишээлбэл, эртний Грекийн соёл иргэншилтэй холбоотой археологийн олдворуудаас бас зарим түүхийн өмнөх үеийн соёл иргэншлийн оршиж байсан ул мөрийг харж болно. Дорнодод, их үерээс харьцангуй олон зүйл үлдсэн. Үерийг Да Юү хэрхэн тогтоон барьж байсан тухай домгийг хүн бүр мэднэ. Тухайн үед үер их ширүүн байсан бөгөөд ус татрах үед Да Юү хүмүүсийг удирдан дагуулж үерт автсан газрын усыг зайлуулсан. Энэ нь түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Хүн төрөлхтний тэр үеийн эртний соёл иргэншил, өөрөөр хэлбэл өмнөх үеийн сүүлчийн соёл иргэншил их үерийн улмаас сүйрсэн ч, Хятадуудын өвөг дээдсийн олонх нь их үерээс амьд гарсан ба харьцангуй олон олдворууд үлдсэн. Барууныхнаас харьцангуй цөөхөн хүн амьд үлдсэн. Тиймээс өнөөгийн барууны соёл бол бүрэн шинэ соёл—ямар ч эртний түүхийн ул мөргүй цоо шинэ соёл юм. Ийнхүү Хятадын эртний соёл иргэншил гүн гүнзгий түүхтэй байсан бөгөөд орчин үеийн шинжлэх ухааныг бодвол, өөр замаар замнаж байсан.

Иймээс тэдгээр эртний соёл иргэншилд өнөөгийн хүмүүсийн ойлгох боломжгүй олон зүйл байдаг, мөн түүнчлэн орчин үеийн соёлоос салангид юм. Тийм болохоор олон хүн, тэр дундаа барууныхан, Хятадад өнөөгийн хүмүүсийн ойлгохгүй маш олон ер бусын нууцлаг зүйлс байдгийг мэддэг. Үүнийг Хятадууд өөрсдөө ч мэддэг. Хятадын газар нутагт орчин үеийн хүмүүсийн ойлгохооргүй эртний соёлын маш олон зүйлс байдаг. Зарим хүн тэдгээрийн тухай сонсож харсан ч тайлбарлаж чаддаггүй, мөн тэдгээр эртний зүйлсийг хэн ч өнөөг хүртэл олон нийтэд дэлгэж, хүмүүст танилцуулаагүй. Яагаад гэвэл Хятад хүмүүсийн өвөг дээдэс [үерийн үеэр] нэлээдгүй нь амьд үлдсэн болохоор эртний соёлын нэг хэсэг нь үлдсэн юм.

Урьд өмнө, эртний Хятад үндэстний төв газар одоогийн Шар мөрний хөндийд төвлөрч байгаагүй; харин Шинжаан бүс нутгаар байрлаж байсан. Тухайн үеийн энэ үндэстний соёл иргэншлийн хамгийн цэцэглэн хөгжсөн үе энэ бүс нутагт тохиосон. Кунлун уул ойрхон байсан учир зэргэлдээх газруудын газар нутаг нэлээд өндөр байсан. Тэр жил болсон их үерийн усны түвшин хоёр мянган метрт хүрч, дэлхийг бүхэлд нь живүүлсэн. Гэвч их үер болоход олон хүн Кунлун уул руу зугтан амьд үлдсэн бөгөөд эртний соёлын зарим зүйлсийг хадгалан авч үлдсэн. Тухайлбал, Хятадад одоогийн зарим хүмүүс ойлгохгүй байгаа Хэтү, Луошү диаграммууд, Тайжи, анхны найман триграм (багуа) гэх мэт, түүнчлэн өнөөгийн хүмүүсийн мэддэг зарим эртний чийгон бясалгалууд үүнд багтана.

Энгийнээр хэлбэл, чийгон бол өнөөгийн хүмүүсийн зохион бүтээсэн зүйл биш юм. Энэ нь түүхийн өмнөх үеийн соёлын нэг хэсэг бөгөөд Хятадад харьцангуй олон байдаг. Гэхдээ урьд нь чийгон гэж нэрлэдэггүй байсан.

Тэгвэл юу гэж нэрлэдэг байсан бэ? Үүнийг "бясалгал" (шиүлиань) гэж нэрлэдэг байсан. Мэдээж, бясалгал түвшин түвшинд хуваагддаг бөгөөд энгийн хүний нийгмийн түвшинд гагцхүү хүмүүст хэрхэн өвчнийг арилгаж биеэ сайжруулах, бие махбодыг хэрхэн эрүүлжүүлэхийг л заадаг. Тиймээс зарим чийгон багш нар үүнийг хүмүүст сайн зүйл хийж өгөхөд ашигладаг. Өөрөөр хэлбэл, нийгэмд бясалгал тарааж буй тэдгээр чийгон багш нар, тэр дундаа өөр улс орон руу явсан чийгон багш нар зөвхөн өвчнийг арилгах, бие сайжруулах түвшний зүйлсийг л заадаг. Бусдын заадаг чийгон бясалгалуудыг би муу гэж байгаа юм биш. Би тэднийг дээд түвшний зүйлсийг заагаагүй гэж хэлж байгаа юм; харин тэд зүгээр л өвчин эдгээх, бие сайжруулах зүйлсийг л заадаг бөгөөд түүнийгээ зарим ер бусын чадваруудыг харуулахтай хослуулсан. Тэд өвчнийг эдгээхдээ, зарим өвчнийг зөвхөн ер бусын аргаар арилгах шаардлагатай байдаг тул зарим нэг ер бусын чадваруудыг гаргадаг нь тийм юм.

"Ер бусын чадвар" гэдэг нь орчин үеийн хэллэг, үнэндээ бол энэ нь амь бодийн төрөлхийн чадвар. Одоогийн материаллаг зүйлсийн элбэг дэлбэг байдал нэмэгдэхийн хэрээр, шинжлэх ухаан хөгжихийн хэрээр, хүмүүс бодит зүйлст илүү их ач холбогдол өгч, төрөлхийн чадвар болон хамгийн эртний үеийн зүйлсээ улам бүр алдаж байна. Хэрэв энэ хандлага үргэлжилбэл ирээдүйд шинжлэх ухаан, технологи улам бүр хөгжиж, хүн аажмаар доройтож, хүний мөсгүй болно. Одоо галт тэрэг, машин, онгоц байгаа болохоор та нар явган явах шаардлагагүй байдаг. Ирээдүйд материаллаг зүйлсийн дэвшил нэмэгдэхийн хэрээр, хүн төрөлхтөн эрс ухарч магадгүй. "Хувьслын онол" гэгч зүйлд итгээд цааш явбал, хүний биеийн гадаргуу ирээдүйд бүрэн доройтож, эцэст нь хүний дөрвөн мөч хатингаржиж, эрс ухарч, зөвхөн нэг том гавлын яс л үлдэх болно. Мэдээж, би энд зүгээр нэг зүйрлэл л авч байна. Өөрөөр хэлбэл, хүний зөн совин, төрөлхийн зүйлс улам бүр гээгдэж байна.

Хятадын энэ газар нутаг дахь эртний нийгэм ингэж хөгжөөгүй. Тиймээс зарим хүн "Хэрвээ Хятадын эртний нийгмийн байдлаар бүх зүйл хөгжсөн бол технологийн дэвшил гарч чадах байсан болов уу?" гэж бодож магад. Одоо байгаа шинжлэх ухаан, технологийн онолын хүрээнд өөр төрлийн шинжлэх ухааныг танин мэдэхийг оролдвол хэзээ ч танин мэдэж чадахгүй нь ойлгомжтой. Хэрэв та нар өөр шинжлэх ухааны хандлагыг ойлгохыг хүсвэл өнөөгийн шинжлэх ухааны хүрээнээс гарах хэрэгтэй. Ийм янзын соёлын хүрээнд байгаа хүн адилхан ийм л нийгмийн байдал байх учиртай гэж үздэг. Зарим хүн "Хэрвээ, дээр үеийн дорно дахины нийгмийн байдлаар хөгжсөн бол машин, онгоц байх байсан болов уу? Би өчигдөр Хонконгоос Сингапур луу нисэхдээ гурван цаг зарцуулсан. Энэ бол нэлээд хурдан юм! Хүн төрөлхтөн нэлээд ахиц дэвшилд хүрсэн. Хятадын эртний нийгмийн байдлаар явсан бол, ийм байж чадах байсан уу?" гэдэг.

Үнэндээ та бүгд мэднэ, шинжлэх ухааны өөр өөр аргууд нь шинжлэх ухааны хөгжлийн өөр өөр замыг авчирдаг. Жишээлбэл, Хятадын эртний нийгэм дагуу хөгжсөн бол, чийгон-оор хичээллэхэд хүний биеийн далдын чадварыг хөгжүүлдэг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өөрөөр хэлбэл, чийгон-оор бясалгаснаар биет бус зүйлийг биет зүйл болгон хувиргаж, үл үзэгдэх зүйлийг эцэст нь харагддаг болгож, энэ бүхнийг багаж хэрэгсэл, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хэрэгсэл ашиглахгүйгээр хийж болно. Чийгон-оор бясалган суугаад гүн амгалан байдалд орсны дараа, эхэн үедээ тийм их мэдрэмж төрдөггүй. Харин чи бүрэн гүн амгаланд орж чадах үед, биеийн гадна тал хөдлөөгүй ч биеийн дотор тал хөдөлж байгааг олж мэднэ; хүн доторх хөдөлгөөнийг мэдрэх болно, мөн энэ хөдөлгөөн нь бараг мэдрэгддэггүй байснаас маш тодорхой мэдрэгддэг болно, эцэстээ чиний бодол үүнийг удирдаж чадахуйц болдог, хэлбэргүйгээс хэлбэртэй болгодог. Эцэст нь, энэ бодол ба мэдрэмж нь аажмаар бясалгагчийг үргэлжлүүлэн дээшлэх тусам, хэлбэртэй зүйл гардаг. Орчлон ертөнцөд өнөөгийн шинжлэх ухаан, технологийн түвшинд танигдаагүй маш олон төрлийн энергийн материаллаг бие бодь оршдог, тэгвэл эдгээр энерги нь тасралтгүйгээр бясалгагчийг байнга хүчирхэгжүүлдэг тул эдгээр үл үзэгдэх, хэлбэргүй бодисууд аажмаар хэлбэртэй болж, улмаар хүмүүс тэдгээрийг харж, бүр хэрэглэж болдог. Энэ хөгжлийн замаар явбал, хүний чанар дээшлэх байдал гарах нь дамжиггүй. Эрт дээр үед сургуулийн сурагчдыг Күнзийн сурагчид гэж нэрлэдэг байсан, хичээл эхлэхээс өмнө бүгд завилан сууж, амьсгалаа зохицуулж, сэтгэлээ амгалан байлгадаг байсан, тэгээд номоо уншина. Өмнө нь үнэхээр ийм байсан, эртний Хятадад нийгмийн бүх давхаргын хүмүүс бараг бүгд амьсгалаа зохицуулах, сэтгэлээ амгалан байлгахад анхаардаг байсан. Ийм байдал дор, хүмүүс ердийн үед хийж чаддаггүй байсан олон зүйлийг хийж чаддаг байсан, энэ нь чийгон бясалгалд маш ойртож байсан юм. Ийм соёл нь эртний Хятадуудын үзэл бодол, үзэл баримтлалд ямагт шингэж ирсэн.

Мэдээж саяны ярьсанчлан, “Хөгжлийн ийм замаар явсан бол нисэх онгоц, галт тэрэг байх байсан болов уу” гэж зарим хүн боддог. Шинжлэх ухааны хөгжлийн өөр өөр чиглэлүүд нь шинжлэх ухааныг өөр өөр төлөв байдалд аваачиж болно. Тэгвэл та бүгд бодоод үз дээ: хэрвээ хүн нисч, хөөрч чаддаг байсан бол нисэх онгоц, галт тэрэгний хэрэг байх уу? Ийм чадвартай хүмүүс Хятад, Энэтхэг, АНУ-д байдаг, Фалунь Гон-оор бясалгадаг хүмүүсийн дунд бас олон байдаг. Яагаад тэр вэ? Хүний бие дэх энергийн бүх сувгууд нээгдсэний дараа, нэг ч газар бөглөрөөгүй байхад, тэр хүн дээш хөөрч чаддаг. Мэдээж, өнөөгийн шинжлэх ухааны судалгаа яагаад гэдгийг тайлбарлаж чадахгүй. Яг үнэндээ, хэн ч үүнийг судалж зүрхэлдэггүй, үүнд итгэдэггүй "эрдэмтэд" гэгдэх хүмүүс шоолуулж, улмаар нэр хүндээ алдах вий гэж айдгаас болдог. Саяхан нэг америк хүн Сингапурт тоглолт хийхээр ирснийг та бүхэн мэдэж байгаа, олон хүн түүний нисч байхыг харсан байх. Эдгээр нь бүгд бодит үзэгдэл юм, хүн үнэндээ хөөрч чаддаг. Тэгэхээр та бүгд бодоод үз

дээ: Урьд нь Хятадууд хаа нэгтээ гэнэт гарч ирээд дараа нь ор мөргүй алга болдог хүмүүсийн тухай ярьдаг байсан. Олон чийгон багш нар хэдхэн секундын дотор хэдэн мянган бээрийн зайд нэг газраас нөгөөд аялж чаддаг. Тэд яагаад үүнийг хийж чаддаг вэ? Мэдээж, үүнийг ойлгохын тулд маш их тайлбарлах шаардлагатай олон үл мэдэгдэх зүйлс байдаг, би өнөөдөр тэдгээрийг дэлгэрэнгүй ярихгүй. Би зүгээр л ерөнхийд нь шинжлэх ухааны хөгжлийн өөр өөр хэлбэрүүд нь өөр өөр төлөв байдалд хүргэдэг гэдгийг л ярьж байна. Жишээлбэл, онгоцоор та нар Хонг Конгоос Сингапур луу гурван цагийн дотор нисэх боломжтой, гэхдээ зарим хүн суугаад хөөрч, арав гаруй минутын дотор энд нисэж ирж чадна; Тэдэнд ийм нүсэр том, болхи машин бүтээх шаардлага байхгүй. Ийм зүйлсийн талаар ярих нь ямар нэг уран зөгнөлт үлгэр биш юм. Хүмүүсийн тайлбарлаж чадахгүй байгаа олон зүйлсийг шинжлэх ухаан аажмаар баталж байгаа. Ийм байдалд үнэхээр хүрэх боломжтой, гэхдээ та нар өнөөгийн шинжлэх ухаанд тулгуурлан бусад шинжлэх ухааны замыг ойлгох ямар ч боломжгүй юм.

Мэдээж, чийгон ч гэсэн орчин үеийн хэллэгээр бас шинжлэх ухааны нэг салбар юм, түүгээр ч барахгүй энэ нь бүр эртний болоод бүр өндөр түвшний шинжлэх ухаан. Хүний биеийн шинжлэх ухаан, эртний шинжлэх ухааныг нотлохоор зориглосон эрдэмтэд олон байдаг, яагаад гэвэл тэд энэхүү чийгон үзэгдлийн бодит оршихуйг олж харсан.

Мэдээж чийгоныг эсэргүүцдэг хүмүүс бас байдаг. Энд сууж байгаа Фалунь Гон-ы сурагчид болох та бүхэнд би ярьж өгч болно, та нар бусдад Фалунь Гон-ыг ирж сур гэж хэлэхэд зарим нь итгэхгүй, зарим нь бүр эсэргүүцэж магадгүй юм. Энэ бүхэн хэвийн зүйл. Яагаад вэ? Яагаад гэвэл хүн төрөлхтний нийгэм ийм л зөрчилдөөн дунд оршдог. Хэрвээ хүн бүр чийгонд итгэвэл, хүн бүр Буддын Фа-д итгэвэл, хүн бүр бясалгаж чадвал хүний нийгэм оршин тогтнохоо больж, хүн бүр тэнгэрийн хүн, бурхан болох болно. Эсэргүүцдэг нь ч, дэмжигчид нь ч, итгэдэг болон итгэдэггүй нь ч байдаг учраас л ийм нэг зөрчилдөөнтэй, харилцан үйлчилж, харилцан харшилддаг энэ нийгэм бүрэлддэг. Бүх ажил амьдрал, түүний дотор энгийн хүний нийгэмд байдаг бүх зүйлд эерэг болон сөрөг хоёр талын хүчин зүйлс нэгэн зэрэг оршдог. Та нар ямар нэг сайн зүйл хийхийг хүсэхэд, муу зүйл та нарыг хүлээж байх нь дамжиггүй, та нар тэр сайн зүйлийг гүйцэлдүүлэхийн тулд тухайн бэрхшээлийг даван туулах ёстой байдаг; мэдээж муу зүйл хийх нь тийм ч амархан бас биш, улсын хууль тогтоомж гэж зүйл бий, бас сайн хүмүүс харж байдаг, тэгэхээр ингэж л оршдог, энэ бүхэн хэвийн үзэгдэл юм. Яагаад гэвэл энэ орчлон ертөнцөд өөр өөр шинж чанартай, эсрэг тэсрэг хоёр бие бодь байдаг бөгөөд тэдгээр нь доошоо тэлэхдээ арга, билэг хэмээх Тайжи-гийн онолыг бий болгодог. Доошоо өргөжин тэлэхийн хэрээр харилцан үүсэх, харилцан харшлах зарчим гарч ирдэг. Харилцан үүсэх, харилцан харшлах энэхүү зарчим нь энгийн хүний нийгэмд хамгийн ил тодоор илэрдэг, тийм ч учраас сая миний ярьсан эртний шинжлэх ухаанд итгэдэг ч, мөн итгэдэггүй ч

хүмүүс байдаг. Өнөөдөр миний заан тарааж буй Буддын Фа бясалгал ч мөн үүнд орно: үүнийг дэмждэг хүмүүс болон эсэргүүцдэг хүмүүс байдаг бөгөөд энэ нь бас хэвийн үзэгдэл юм. Ирээдүйд та бүгд мөн ийм асуудалтай тулгарах болно, би үүнийг сандрах зүйл биш гэж бодож байна.

Сая би Фалунь Гоны түүхийн талаар ярихаасаа өмнө жаахан өргөн хүрээнд ярилаа. Өнөөдөр хүмүүсийн мэддэг чийгон бол нэг төрлийн эртний шинжлэх ухаан юм. Үүнд түүхийн өмнөх үеийн соёлоос гаралтай Фалунь Гон ч багтдаг. Энэ нь Ли Хонжи зүгээр л сэтгэлийн хөөрлөөр гарч ирээд ямар нэг зүйл зохиогоод, та бүхэнд дамжуулж байгаа хэрэг биш. Ийм байсан бол хүмүүст хор хөнөөл учруулсан болно. Одоо хүмүүсийг хууран мэхэлж, өөртөө болон бусдад ч хор хөнөөл учруулдаг хуурамч чийгон багш нар олон болсон. Яагаад гэвэл, ер нь гон гарахад энэ орон зайд явдаггүй, мөн хүний махан нүдээр үүнийг харах боломжгүй байдаг тул хүмүүсийг хууран мэхэлдэг хуурамч чийгон багш олон байдаг, энэ нь загасны нүдийг сувдтай холихтой адил юм—үнэн худал нь мэдэгдэхээ больчихсон. Угаасаа чийгонд итгэдэггүй хүмүүс маш олон байдаг, тэгээд чийгон-ыг бүр ч эсэргүүцдэг. Ялангуяа өнөөгийн хүмүүсийн ёс суртахуун маш ихээр доройтсон, бүх зүйлийн жинхэнэ болон хуурамч хувилбарууд байдаг—чийгон битгий хэл арилжааны бараанууд ч бас жинхэнэ, хуурамч гэж байдаг болсон. Мэдээж чийгон бол хэн нэгний зүгээр л дураараа зохиогоод хүмүүсийг хууран мэхэлдэг зүйл биш, ингэвэл бусдад болон өөртөө хор хөнөөл учруулна, яагаад гэвэл хууран мэхлэгчид, үүгээр бясалгахад юу гардгийг мэддэггүйгээс тэр юм. Мэдээж хэрэв тэд бясалгаад юу ч гаргаж чадахгүй бол ч яахав. Гэхдээ хэрэв тэд үнэхээр ямар нэгэн зүйл бясалгаад гаргавал энэ нь хүмүүсийг маш аюултай байдалд оруулж болзошгүй юм, энэ бол хуурамч чийгоны хүмүүст хүргэдэг аюул.

Тэгвэл Фалунь Гон хэрхэн үүссэн бэ? Мөн хэзээ үүссэн бэ? Үүний ул мөрийг хайна гэвэл, түүх нь үнэхээр маш урт юм, энгийн хүн сонсвол маш нууцлаг санагдана, би энэ талаар одоохондоо ярихгүй, гэхдээ аажмаар та нар үүнийг мэдэх болно. Гэхдээ би та нарт хэлье, түүхийн өмнөх үед Фалунь Гон нэгэн цагт голлох Буддын Фа болж дэлхийд хүмүүсийг аварч байсан, яг л хоёр мянга таван зуун жилийн өмнө Шагжамүни хүмүүсийг хэрхэн аварч байсантай адил, дэлхийн бүх амь бодид авралыг үзүүлж байсан. Түүнээс хойш, түүхийн маш урт хугацааны турш хүнд илэрч гараагүй. Түүх хэтэрхий урт удаан явцтай байдаг, тэр тусмаа одоогийн дэлхийн хүмүүс энэ талаар бүр ч мэдэхгүй болсон. Фалунь Гоны түүх маш урт бөгөөд маш эртний улбаатай.

Яагаад үүнийг өнөөдөр олон нийтэд тараах болсон бэ? Мэдээж, би үүнийг зөвхөн хамгийн энгийнээр болоод хамгийн өнгөцхөн байдлаас л тайлбарлаж болно. Би нэг нөхцөл байдлыг харсан. Ямар нөхцөл байдал вэ? Энэ нь хүн төрөлхтний нийгмийн материаллаг зүйлс элбэгшиж, шинжлэх ухаан эрчимтэй хөгжихийн хэрээр хүн төрөлхтний ёс суртахуун эрс доройтсоор ирсэн. Яагаад

гэвэл өнөө үед хүмүүс бүгд шинжлэх ухаанд итгэдэг болсон, орчин үеийн шинжлэх ухааныг үнэн гэж үздэг. Гэвч хүмүүс нэг асуудлыг бодож байгаагүй, орчин үеийн шинжлэх ухаан бүрэн бус юм, шинжлэх ухааны танин мэдээгүй маш олон зүйлс байсаар байна, мөн шинжлэх ухаанаар няцаагдсан маш олон зүйлс бас байдаг. Явцуу үзэл бодолтой маш олон хүн энэхүү төгс бус шинжлэх ухааныг ашиглан, хүмүүсийн итгэдэг шинжлэх ухаанаар тайлбарлаж чаддаггүй үзэгдлүүд рүү дайрдаг. Гэсэн хэдий ч тэдгээр тайлбарлагдашгүй үл мэдэгдэх үзэгдлүүд нь хүн төрөлхтний нийгмийн энэхүү материаллаг орон зайд бодитоор илэрдэг. Орчин үеийн шинжлэх ухаан тэднийг хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй. Шинжлэх ухаан тэдгээрийг хүлээн зөвшөөрдөггүй учраас шинжлэх ухаанд итгэдэг олон хүн ижил үзэл баримтлалаар үүнийг эсэргүүцдэг. Гэхдээ энэ шинжлэх ухаан үнэхээр төгс бус юм. Жишээлбэл, хэдэн мянган жилийн турш хүмүүс Дэ-г/буяныг чухалчилж ирсэн. Өнөө үед олон хүн "буян" гэдэг нь зүгээр л хүний бодол санаа, оюун санааны сайхан сэтгэлийн ухамсар, хүмүүст тавих оюун санааны шаардлага гэж ойлгодог, тэд үүнээс цааш нэг их бодож байгаагүй. Гэхдээ би та нарт хэлье, орчлон ертөнцийн бүх зүйл бие бодиос (матери-аас) бүрддэг тул түүнд өөрийн гэсэн хүчин зүйлс оршдог. Буян бол бодит материаллаг оршихуй болоод жинхэнэ бие бодийн оршихуйн илрэл юм. Эрт дээр үед дорно дахины хүмүүс, ялангуяа Хятадын хөгшчүүл буян хураахыг чухалд үздэг байсан. Залуучууд үүнийг ойлгодоггүй. "Яагаад буян хураах ёстой гэж? Юун буян 'хураах'?" "Хэлбэр дүрсгүй зүйлийг яаж хураах юм?" Үнэндээ би та бүгдэд хэлье, энэ нь хэлбэр дүрсгүй, өөр орон зайд оршдог учраас хүний нүд үүнийг харж чадахгүй. Гэхдээ энэ нь үргэлж тэнд байдаг. Чи сайн зүйл хийвэл буян хураана; зовлон эдлэхэд бас буян хураадаг. Энэ нь хүнийг төрөл төрөлд нь дагаж явдаг ба чиний ирээдүйн буян заяаг шийддэг. Зарим хүн үүгээрээ маш өндөр албан тушаалтан болж, зарим нь үүнийхээ хүчинд баяжиж, зарим нь бизнесдээ маш их амжилт гаргадаг. Яагаад гэвэл та нар урьд болон өмнөх амьдралууддаа буян хураасан болохоор энэ насандаа буян хишгээ хүртэж байгаа нь энэ юм. Тэгвэл яагаад бусдын адил баян чинээлэг амьдардаггүй хүмүүс олон байдаг вэ? Яагаад гэвэл тэдэнд бусдын адил буян байхгүй, тийм ч их буян хураагаагүй учраас тэр юм. Ийм л учиртай. Тиймээс буян бол туйлын чухал. Сая би шинжлэх ухааны төгс бус байдлын талаар ярьсан, шинжлэх ухаан нь хүн төрөлхтний оршдог энэ материаллаг орон зайг нэвтэлж чадахгүй, бусад орон зайнуудыг таньж чадахгүй. Гэхдээ одоо олон онцгой, сайн эрдэмтэд бусад цаг хугацааны орон зайнууд оршдог юм байна гэдгийг ойлгодог болсон. Хэдийгээр тэд энэ нээлтийг хийж чадахгүй байгаа ч, онолын үүднээс аль хэдийн гүехэн тайлбар хийсэн ба энэ талын асуудлуудыг хөндөж тавьсан, тэд бусад цаг хугацааны орон зай байдаг гэдэгт итгэдэг. Тэгвэл тэдгээр цаг хугацааны орон зайд амь бодиуд байдаг уу? Тэдгээр амь бодиуд ямар янзтай байдаг вэ? Тэдний оршин тогтнох хэлбэрүүд ямар байдаг вэ? Түүний доторх цаг хугацаа болон бидний энэ орон зайн цаг хугацааны хооронд ямар ялгаа байдаг вэ? Тэр орон зайн ухагдахуун, тэнд орших амийн хэлбэр, бие бодийн хэлбэр нь ямар янзтай байдаг вэ? Энэ бүхэн нь өнөөгийн



хүн төрөлхтний шинжлэх ухаанд танигдаагүй. Орчин үеийн шинжлэх ухаан бусад орон зайнууд оршдогыг хүлээн зөвшөөрдөггүй, орчин үеийн шинжлэх ухаан буян байдаг гэдгийг ч хүлээн зөвшөөрдөггүй. Тэгвэл та бүгд бодоод үз дээ: хүн төрөлхтөн шинжлэх ухаанд хэт их итгэдэг, шинжлэх ухааны үгүйсгэсэн аливаа зүйлд итгэдэггүй, энэ нь тэгвэл хүн төрөлхтнийг ёс суртахууны асар их уналтад хүргэж буй хүчин зүйл болж байгаа хэрэг биш гэж үү? Яагаад гэвэл, хүн буян дурдахад, буян хураах, түүнийгээ нандигнах хэрэгтэй гэж ярихад орчин үеийн сэтгэлгээтэй олон хүн “чи мухар сүсэг яриад байна. Энэ бүхэн бол мухар сүсэг, бид мухар сүсэгт биш харин шинжлэх ухаанд итгэдэг” гэдэг. Та бүхэн харж байна уу, энэ шинжлэх ухааныг хүний хамгийн үндсэн мөн чанарыг цохих бороохой болгон ашиглаж ирсэн. Тэгэхээр шинжлэх ухааныг төгс гэж хэлж болох уу? Би дөнгөж сая ярьсан, хүний материаллаг амьдрал одоо маш баялаг болсон. Тэгвэл яагаад ёс суртахууны үзэл баримтлал гулсан унаж байна вэ? Чухамдаа одоогийн шинжлэх ухаан бусад орон зай ба дээд аминуудын оршин тогтнолыг нотолж чадахгүй учраас, хүн төрөлхтөнд хойд төрөл, гэсгээлт байдгийг нотолж чадахгүй учраас, буян байдгийг нотолж чадахгүйн учраас л хүмүүс муу зүйл хийж зүрхэлдэг. Орчин үеийн олон хүн “Энэ бүгд шинжлэх ухаан биш, харин мухар сүсэг” гэж үздэг. Хүмүүс бурхад байдаг гэдэгт итгэдэггүй учраас муу зүйл хийж зүрхэлдэг. Тэд шийтгэл гэсгээлт байдагт итгэдэггүй, тиймээс энэ бүгдийг мухар сүсэг гэж үздэг. Энэ бол орчин үеийн шинжлэх ухааны сул талаас үүдэн гарсан хамгийн том асуудал юм.

Би санаанд орж ирсэн зүйлийнхээ талаар ярьж байгаа болохоор, сая Фалунь Гон-ы гарал үүслийн талаар ярьж байхдаа, энэ асуудлыг дэлгэрүүлэн авч ярилаа.

Бясалгалын хүрээнд яригддаг олон, олон зүйлийг энгийн хүний нийгэмд ярьж болохгүй. Гэхдээ энгийн хүний нийгэмд сонссон, үзсэн харсан зарим зүйлийнхээ талаар мэддэг; хааяа тайлагдашгүй үзэгдлүүдийг харж, мэдэрдэг, хааяа ер бусын зүйлтэй тааралддаг хүмүүс бас олон байдаг. Гэвч хэн ч эдгээр зүйлийг бодитоор баталж, системтэйгээр судлаагүй.

Хэсэг хугацааны өмнө нэг сурагч энэ индэр дээрээс энэ Фа ямар нарийн нандин болохыг хэлсэн. Өнөөдөр би та нарт ийм их зүйл ярьж өглөө. Жуань Фалунь-ийг уншиж үзээгүй хүмүүс уншаад үзээрэй, магадгүй та нар [миний юу яриад байгааг] ойлгох болно. Жуань Фалунь бол Фа зарчим юм, Фа мэдээж бясалгадаг хүнд уламжлагддаг. Бясалгалын тухайд, олон хүн үүнийг хэцүү гэж боддог. Үнэндээ бясалгал өөрөө хэцүү биш; харин энгийн хүний сэтгэл, хүний зууралдлаас салах нь хамгийн хэцүү юм. Энгийн хүний сэтгэл гэж юу вэ? Тухайлбал, бясалгагч хүний хувьд юуны өмнө, цохиулсан ч эргээд цохихгүй, загнуулсан ч эргээд хэрэлддэггүй байх ёстой. Энгийн хүмүүс бол тэгж чадахгүй, яагаад гэвэл тэд энгийн хүмүүс. Гэхдээ бясалгадаг хүний хувьд заавал хийж чаддаг байх ёстой, түүнчлэн бусад хүмүүс чамайг

дээрэлхэж байхад, чи гомдол, үзэн ядалт санахгүй байх, хөнгөнөөр хүлээж авдаг, бүр инээмсэглээд л өнгөрөөдөг байх ёстой, тэр битгий хэл чи зодуулсан ч, чамайг зодсон тэр хүнд сэтгэлдээ талархдаг байх ёстой. Энгийн хүмүүс үүнийг ёстой төсөөлшгүй зүйл гэж боддог, “Хүн яаж ийм байж болох юм? Тэгвэл хэтэрхий хулчгар болчих юм биш үү.” Гэвч бодит байдал дээр, бусад хүн чамайг дээрэлхэхэд, тэр чамд буянаасаа өгч байдаг, бодитоор чамд буянаа өгч байдаг. Энэ орчлон ертөнцөд бас хүний нүдээр харж чадахгүй маш олон тооны асар том бие бодиуд байдаг бөгөөд өнөөгийн шинжлэх ухаан бас л тэдгээрийг нээж чадахгүй байгаа. Тэдгээр олон тооны, бүр бичил сансар огторгуйн бие бодиуд бүгд сүнслэг болоод амьтай байдаг, тэд өөрөөсөө дооших бүх амь бодиудыг хянаж, үүний зэрэгцээ энэ орчлон ертөнц дэхь бүх зүйлийг бүхэлд нь тэнцвэржүүлж байдаг. Түүнээс гадна энэ орчлон ертөнцөд алдахгүй бол олохгүй, олвол алдана гэдэг зарчим байдаг. Тэгвэл хүн ямар нэг зүйлийг авахыг хүсвэл солилцоо хийх ёстой байдаг, үүнийг “олох ба алдах” гэж нэрлэдэг. Яаж алддаг вэ? Энэ орон зайд энгийн хүмүүс үүнийг харж чадахгүй ч заримдаа мэдэрдэг. Ер нь хvн, хүнд хэцүү байдалд хvчин чармайлт гаргаж байж хүссэн зүйлээ олж авдаг. Гаргахыг хүсэхгүй атлаа хүссэн зүйлээ хүчээр авна гэвэл, тэгвэл Бурхад гаргуулах болно. Жишээлбэл, хэн нэгэн бусдын зүйлийг булаан авсан эсвэл хэн нэгнийг зодсон гэж бодъё. Энэ бол хүн ашиг сонирхол, оюун санааны хувьд хүчээр олж авахыг хүсэж байгаа хэрэг юм, тэр хохирсон талд нөхөн төлөхийг бодох ч үгүй, гэвч энэ орчлон ертөнц олсон талыг хүчээр нөхөн төлүүлнэ; тэр алдахыг хүсэхгүй ч алдах болно. Яаж алдах вэ? Чи энэ талд бусдыг цохисон, бусдыг дээрэлхсэн, эсвэл бусдын ямар нэг зүйлийг авсан, тэгвэл чи хичнээн ихийг олж авсан ч, өөр орон зай дахь чиний биеийн хүрээнээс нөгөө тал руу тэр хэмжээний буян нисч очих болно; мөн энэ буяныг ашгаар эсвэл мөнгөөр сольж болдог. Өөрөөр хэлбэл, хүн ямар нэг зүйлээ хүчээр алдсан бол, нөгөө талд үүгээр нөхөн төлдөг гэсэн үг. Энгийн хүн үүнийг харж чадахгүй болохоор муу юм хийж зүрхэлдэг. Олон хүн бизнес хийхдээ бусдад хууртагддаг, эсвэл ямар нэг зүйлээ аргагүй байдалд орж алддаг. Хэрэв хүн өөрөө муу зүйл хийгээгүй бол, буянаа алдах зүйл хийгээгүй бол, тэгвэл тэд цаг хугацааны явцад түүнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр авах болно. Энэ бол бусдад хохирол учруулсан хүмүүст хүчээр оногдуулсан нөхөн төлбөр юм, гэвч хүмүүс үүнийг тохиолдлоор эсвэл өөрсдийн хүчин чармайлтын үр дүнд олж авсан гэж боддог, хүн жинхэнэ шалтгааныг нь олж харж чадахгүй. Буян гэдэг туйлын нандин, юунд ч хувирч болдог зүйл гэдгийг би энд та бүгдэд хэлж байна. Орчин үеийн хүмүүс үүнд итгэдэггүй, яагаад гэвэл шинжлэх ухаан үүнийг олж харж чадахгүй, энэ нь бас хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ огцом доройтож байгаагийн нэг шалтгаан юм. Гэвч энэ орчлон ертөнц дэхь асар том бие бодиуд, дээд түвшний амь бодиуд үнэхээр энэ орчлон ертөнцийн харилцааг тэнцвэржүүлж байдаг. Чи алдах ёсгүй зүйлээ алдсан бол, нөхөн олговор авна, эсвэл буцаан авах болно. Хүн алдахыг хүсэхгүй байсан ч алддаг, яагаад гэвэл нөгөө талд шууд нөлөөлж байдаг, энэ бол зүгээр нэг энгийн жишээ юм. Үнэн хэрэгтээ хохирогч илүү их ашиг хүртдэг. Тиймээс би

заримдаа бага зэрэг зовлон зүдгүүрийг амсах нь муу зүйл биш гэж хэлдэг. Эрт дээр үед хөгшчүүл, ялангуяа Хятадын хөгшчүүл “Одоо чамд бага зэрэг зовлон тохиолдож байгаа ч ирээдүйд зүгээр болчихно” гэж бүгд хэлдэг байсан. Ийм л зарчимтай юм. Хүн чиний зүүн хацар луу алгавал, баруун хацраа бас өг гэж Есүс хэлсэн байдаг. Зарим хүн үүнийг ойлгодоггүй. Яг үнэндээ үүнийг олон католик шашинтнууд, Христэд итгэгчид бүгд ойлгодоггүй, зарчмын талаас яривал яагаад ингэж байгаа вэ? Есүс зөвхөн өнгөц ярьсан болохоос гүн гүнзгий утгыг нь тайлбарлаагүй. Өөрөөр хэлбэл, тэр энэ талд чамайг цохиход, тэр чамд буян өгч, нүглийн үйлийн үрийг чинь бас арилгахад тусалж байдаг. Тэгвэл, дайрсан хүний уур бүрэн гараагүй байвал, нөгөө хацраа өгч алгадуулбал, тэр чиний үйлийн үрийг арилгахад тусалж мөн буян өгч байгаа биш гэж үү? Зовлон эдлэх үед чиний өөрийн үйлийн үр ч бас арилдаг. Хүн бүр нүгэл үйлддэг. Зарим хүн амь бүрэлгэсэн, бусдыг дээрэлхсэн, бусдыг харааж зүхсэн, хэн нэгнийг үзэн ядсан, эсвэл муу зүйл хийсэн гэх мэт - энэ бүхэн нүглийг бий болгодог. Энэ нь нэг төрлийн хар бие бодь бөгөөд хүний биеийн эргэн тойронд оршдог. Энэ нь тухайн хүний зовж шаналах, өвдөх, эсвэл ямар нэг асуудалтай тулгарах, бизнес нь бүтэлгүйтэх, бусдаар зодуулж нүдүүлэх, хараалгаж загнуулах, эсвэл бусад олон төрлийн зовлон зүдгүүрт орохыг шийдвэрлэдэг. Энэ бүхэн муу үйлийн үрээс үүдэлтэй. Чамайг хэн нэгэн цохих юм уу, дээрэлхэх үед, цохисон хүн чамд буян өгөхөөс гадна, чи өвдөж шаналах зуураа хар үйлийн үрээ буян болгон хувиргана. Тиймээс нэг нүүдлээр хоёр олз олно, энгийн хүний хувьд ч бас нэг нүүдлээр хоёр олз олно. Гэхдээ бясалгадаг хүний хувьд энэ бол түүний давах ёстой даваа юм. Зовлон эдэлж байх явцдаа, сайн давж чадвал шиньшин дээшлэх болно. Харин шиньшин дээшилсэн бол түвшин бас дээшилнэ гэсэн үг, тэгвэл гон ч бас өснө, буян нь гон болон хувирна. Би энэ зарчмыг нэвт шувт тайлбарлаж өглөө, гэхдээ бодит бясалгалын тухайд та нараас өөрсдөөс чинь шалтгаална.

Үнэндээ би Фа-г заан тарааж байгаагаас гадна, урьд өмнө хэн ч хийж байгаагүй зүйлийг хийж байгаа. Би үнэхээр хүнд тэнгэрт гарах шат үлдээсэн. Чи гагцхүү энэхүү Агуу хууль дагуу бясалгаж л байвал Төгс төгөлдөрт хүрэх нь гарцаагүй. Өмнө нь хэн ч энэ Фа-г зааж байгаагүй, тэр тусмаа хүн төрөлхтөнд. Хэрэв та нар үүнд үнэмшихгүй байгаа бол эрт дээр үеэс өнөөг хүртэлх Хятад болон хилийн чанадад байгаа бүх номноос хайж үзэж болно. Дао Дэ Жин, Ариун Библи, Буддын судар гээд аль нь ч тэнгэрийн бүх нууцыг илчлэх замаар Фа-г заагаагүй.

Шагжамүни бол Будда, хүмүүс Будда Шагжамүни-ийг Буддын Фа-г үлдээсэн гэж үздэг. Гэвч Будда Шагжамүни өөрөө: "Би амьдралдаа ямар ч Фа үлдээгээгүй" гэж хэлсэн. Хүмүүс үүнийг юу гэсэн үг болохыг ойлгоогүй, тиймээс Зэн Буддизм Фа гэж байдаггүй гэж үздэг: "Будда Шагжамүни ямар ч Фа үлдээгээгүй, хэн юу ярьсан ч Буддын Фа биш, ярьж болохгүй, яривал Буддын Фа биш болно." Бүрэн буруугаар ойлгосон. Тэгвэл Будда Шагжамүни

ингэж хэлсэн нь юу гэсэн утгатай байсан бэ? Будда Шагжамүни бол бурхан, тэрээр хүмүүсийг аврахын тулд энгийн хүний нийгэмд төрөл олсон. Тэр гэгээрсэнийхээ дараа Будда болсон, түүний үгст Буддын мөн чанар агуулагдах болсон. Хэдийгээр түүний заасан зүйл нь бясалгалыг системтэйгээр удирдан чиглүүлдэг Буддын Фа биш байсан ч, Буддын мөн чанар агуулагддаг үгс нь тухайн түвшний Фа зарчим байдаг. Гэвч энэ нь орчлон ертөнцийн системчлэгдсэн үндсэн Фа биш байсан. Үнэндээ, хойч үеийнхний эмхэтгэсэн судар үнэндээ тасалдсан, системгүй байсан. Үнэхээр ийм байсан. Шагжамүни хоёр мянга таван зуу гаруй жилийн тэртээ тухайн үеийн хүмүүс рүү чиглэж заасан, түүнчлэн Будда Шагжамүни өнөөгийн хүн төрөлхтний нөхцөл байдлыг харсан. Тиймээс Будда Шагжамүни тэр үед түүний Дарма Фа-төгсгөлийн үед үйлчлэхгүй гэж хэлсэн. Үнэндээ өнөөгийн хүмүүс Будда Шагжамүнигийн хэлснийг ойлгох ч үгүй.

Барууны шашны Библийн хувьд ч мөн адил: орчин үеийн хүмүүсийн бодол санаа маш төвөгтэй болсон учраас хүмүүс үүнийг жинхэнэ утгаар нь ойлгож чадахгүй. Хүмүүс үүнийг янз бүрийн байдлаар ойлгож, унших явцдаа бодит сэтгэл хөдлөл, ашиг сонирхолдоо тулгуурлан ойлгодог, орчин үеийн хүмүүс жинхэнэ дотоод утгыг нь ойлгодоггүй.

Би та бүгдэд хэлье, Жуань Фалунь энэ ном бол үнэхээр нандин. Хүн төрөлхтний өөр ямар ч номыг үүнтэй харьцуулшгүй. Яагаад гэвэл энэ бол бясалгалын ном, хүмүүсийг Төгс төгөлдөрт хүргэж чадах маш чанд Агуу Хууль юм. Сая нэг хүн Жуань Фалунь энэ номыг аваад уншихад үг бүр нь алтан туяагаар гэрэлтэж байлаа гэж хэлсэн. Хэрэв та бүгд Төгс төгөлдөрт хүртлээ тууштай бясалгаж, хичээнгүй байж чадвал шаргуу хичээл зүтгэл гаргах явцад, бясалгах явцдаа энгийн хүмүүсийн харж чадахгүй, мэдрэхгүй олон, олон мэдрэмж, үзэгдлүүдийг харж, мэдрэх болно гэж би бодож байна. Тэр үед та нар энэ ном юу болохыг олж мэдэх болно. Миний энд яаж ярьсан ч, би л ярьж байна. Хэрэв би энэ талаар хэт их яривал учир битүүлэг болоод явчихна. Иймд та бүхэн өөрсдөө ухамсарлан ойлгож, үүнийг өөрсдөө баталгаажуулбал илүү дээр гэж бодож байна. Энэ Фа туйлын нандин гэдгийг л би та нарт хэлэх гэсэн юм.

Намайг тэр үед энэ Фа-г заан түгээж эхлэхэд, маш олон дээд түвшний амь бодиуд, агуу гэгээрэгчид намайг битгий түгээ гэсэн, “Хүн төрөлхтний ёс суртахуун аль хэдийн ийм хэмжээнд хүртлээ доройтсон байхад та ийм сайхан зүйлийг тэдэнд гаргаж ирж яах юм. Та үүнийг хүн төрөлхтний хамгийн сайхан цаг үед гаргаж ирээгүй, харин одоо гаргаж ирнэ гэж үү” гэж байсан. Бурхад бүгд ингэж бодож байсан.

Та бүгд бод доо. Би сая нүгэл, буяны асуудлын талаар ярьсан. Хүн хойд төрөл олоход нүгэл, буян нь дагадаг. Хүн энэ дэлхийн юуг ч авч явж чадахгүй, гагцхүү эдгээр нь л хүний хойд төрлийг дагадаг. Хойд төрлийг ярихын

тухайд, би та бүгдэд хэлье, шашинд хүн үхсэний дараа өөр орон зай руу очдог гэж ярьдаг; ялангуяа дорно дахины шашинд хойд дүрийн зургаан зам байдаг гэж ярьдаг. Хүн үнэхээр дахин төрөл олох боломжтой. Энэ бол үнэн. Бясалгалын хүрээнд энэ талаар эргэлзэх зүйл байхгүй, та бүхэн маш тодорхой харж байгаа. Яагаад хойд төрөл олдог вэ? Зарим хүн “Хүн үхвэл үхсэн л гэсэн үг биз дээ” гэдэг. Үхсэн нь бол хүний хоол идэж өссөн хэсэг нь л юм; харин хүний амь өөрөө үхдэггүй.

Үүнийг орчин үеийн хүн төрөлхтөнд ойлгогдох байдлаар яривал, та бүгд бодоод үз дээ, хүний бие нь молекулын ширхгүүдээс нэгтгэгдсэн гадаргуйн бие бодиос бүрддэг. Үүнийг хүн бүр мэддэг. Дэлхийн эргэн тойрон дахь агаар, мод, үүний дотор барилгын цемент, ган төмөр зэрэг нь бүгд янз бүрийн молекулын ширхгүүдээс нэгтгэгдсэн гадаргуйн бие бодь юм. Тэгвэл молекулууд нь атомуудаас бүрддэг, атомууд нь нейтрон, электрон, атомын цөмүүдээс бүрддэг; мөн атомын цөмөөс доошлоход кваркууд атомын цөмүүдийг бүрдүүлдэг ба атомын цөмүүд нь нейтриногоос бүрддэг. Дахиад цааш нь хөөвөл хүн тэнд юу байгааг мэдэхгүй. Үнэндээ хүн үхэх үед зөвхөн гадаргуйн материаллаг орон зай дахь молекулын ширхгүүдээс бүрдсэн махан бие салдаг; энэ нь хувцас тайлахтай адил юм. Харин атомаас бүрдсэн, атомын цөмөөс бүрдсэн, кваркаас, бүр бичил бие бодиос бүрдсэн биеийн хэсгүүд огт үхдэггүй, бас хүний гадаргуйн биеийг дагаад үхэх боломжгүй юм. Та бүхэн бодоод үз дээ: атомын цөм задрахад, энэ нь цөмийн дэлбэрэлт юм. Хүн үхэхэд атомын цөмийг задлах тийм их хүч яаж байх юм? Өнөөгийн шинжлэх ухаанд цөмийг задлахыг хүсвэл, задрах урвалд оруулахын тулд өндөр халалт, хүчтэй цохилт байх шаардлагатай. Энгийн хүний биед задрах урвалыг үүсгэх тийм их хүчтэй энерги яаж байх юм? Чандарлах зуухны температур атомын цөмийг задлах туйлын боломжгүй. Өөрөөр хэлбэл, хүний биеийг бүрдүүлдэг бүр бичил бие бодиуд чандарлах зуухны галд устгагдахгүй. Хэрэв энэ нь хүний биеийн атомын цөмийг үнэхээр задалж чадвал цөмийн дэлбэрэлт болно. Нэг хүний биед байдаг цөмийн бие бодь дэлбэрвэл томоохон хот сүйрэх болно. Энэ бол атом бөгөөд түүний энерги нь асар их юм. Тэгвэл яагаад ийм зүйл тохиолдоогүй вэ? Энэ нь хүний биед байдаг атомын элементүүд устаж үгүй болдоггүй гэдгийг харуулж байна.

Хүний хувьд, атомын цөм болон атомууд нь хүчтэй цацраг идэвхтэй байдаг гэдгийг та бүхэн мэднэ. Өөрөөр хэлбэл тэд нэг төрлийн энерги юм. Үнэндээ, бүр бичил бие бодиуд болох кваркын энергийн цацраг идэвхт байдал нь атомын цөмөөс бүр илүү байдаг; тэгвэл нейтриногийн цацраг идэвхт чанар нь кваркаас хэд дахин их хүчтэй байдаг нь мэдэгдэшгүй. Бие бодь бичил байх тусам түүний ширхэгийн энерги улам хүчтэй болдог. Би та бүгдэд хэлье, та бүхний бясалгаж буй гон-д маш хүчтэй атом, нейтрон, бүр бичил бие бодиуд байдаг. Бясалгаж гаргасан гон яагаад өвчнийг эдгээж чаддаг вэ? Яагаад хүний биеийг өөрчилж чаддаг вэ? Бясалгагчид яагаад ийм олон гайхамшигийг үйлдэж чаддаг вэ? Яагаад гэвэл гон болон ер бусын чадварууд эдгээр дээд

энергийн бие бодиудаас бүрддэг. Түүгээр ч зогсохгүй, ариун Фа бясалгалын эдгээр бие бодиуд нь амьтай байдаг ба нинжин шинж чанартай байдаг, бясалгагчийн эзэн биений бодлоор удирдагддаг, хүний бодлоор удирдагддаг. Шинжлэх ухааны аргаар атомыг хорон муугаар задлахад сүйтгэх нөлөөтэй байдагтай адилгүй юм. Шинжлэх ухааны арга хэрэгслээр, одоогийн энэ атомын бөмбөг дэлбэрснээс ялгарах энерги нь хор хөнөөлтэй байдаг. Энэ нь тодорхой чиглэл рүү явдаггүй, хүнд болон бусад амь бодиудад хөнөөлтэй, хүний амьдрах орчинд маш их хор уршигтай. Гэхдээ бясалгагчаас цацарч гардаг энерги нь ухамсартай байдаг бөгөөд эерэг нөлөө үзүүлдэг. Хятадын Шинжлэх Ухааны Академийн судлаачид над дээр туршилт хийж дүгнэлт гаргасан, намайг Фа зааж байх үед цацарч гарсан энергийн бие бодийг хэмжсэн. Хятадын ШУА-ийн Дээд энергийн физик судалгааны хүрээлэн нь дээд энергийн физик судалгааны чиглэлээр мэргэшсэн. Тэд хурлын танхимын дөрвөн өнцөгт, мөн танхимын голд янз бүрийн байрлалд туршилтын төхөөрөмж байрлуулсан. Миний Фа заах ширээн дээр бас туршилтын төхөөрөмж тавьсан байсан. Туршилтын явцад тэд надаас гарч буй энергид атомын бүрэлдэхүүнээс гадна хүчтэй нейтроны бүрэлдэхүүн агуулагдаж байгааг олж мэдсэн. Мэдээж, тэд зөвхөн энэ хэмжээнд л туршилт хийсэн, цааш нь бүр бичил бие бодийг судлах төхөөрөмж тэдэнд байгаагүй. Тэдний үнэхээр гайхсан зүйл нь миний цацруулж буй энергийн орон жигд тархаж байсан ба энерги тодорхой чиглэлтэй байсан. Одоогийн шинжлэх ухааны судалгаагаар цөмийн бодис цацрахдаа тодорхой чиглэл байдаггүй, хаашаа цацарч байгаа нь мэдэгдэхгүй, түүгээр ч барахгүй ойртох тусам хүчтэй, холдох тусам сул байдаг, цацраг нь түүний хүрээн дэх бүх зүйлд хор хөнөөлтэй байдаг. Мэдээж, орчин үеийн шинжлэх ухаан төгс биш бөгөөд түүнд хэт сохроор итгэх нь хүн төрөлхтөнд асар их хор хөнөөлтэй.

Би сая хүний амь махан биетэйгээ хамт үхдэггүй гэж ярьсан, тиймээс энэ орон зай дахь махан бие үхэхэд хүний сүнс чөлөөлөгддөг. Энэ нь анхнаасаа өөр орон зайд байдаг, төрөх үед л энэ орон зайд хүний биетэй нийлдэг. Энэ орон зайд бие үхэхэд сүнс нь чөлөөлөгдөж гардаг. Тэгвэл шашинд ярьдаг хойд дүрийн зургаан замын тойрог нь бодит юм. Амь зургаан замын тойрогт дахин төрөх боломжтой. Хүн ахин дахин хүн болж төрж болдог, бас бие бодь болж, амьтан болж төрж болдог, тэр ч байтугай дээд оршихуй, эсвэл өөр зүйл болж дахин төрж болно.

Буддын шашинд таван хүчийг нээх гэж ярьдаг, үүнд Тэнгэрийн нүд нээгдэх, Билгийн нүд нээгдэх, Фа нүд нээгдэх, Буддын нүд нээгдэх багтдаг. Хэрэв Фа нүд нээгдвэл, чамд харагдаж буй дэлхий ийм байдалтай байдаггүй. Тэгвэл ямар янзтай байдаг вэ? Чиний нүд чиний түвшний хүрээн дэх ямар ч биет зүйлийг нэвт харж чаддаг болохыг олж мэднэ, бүр бичил түвшний бие бодиудыг харж чадна, мөн түүнчлэн бүх биетүүд амьтай байдгийг олж мэднэ. Аливаа биет, чамайг тэднийг харж чадаж байгааг олж мэдэхэд, тэд чамтай харилцана, хэл яриагаар харилцана, бодлоор харилцана. Зарим энгийн хүн

үүнийг хийсвэр, утгагүй зүйл гэж боддог. Мэдээж, эдгээр нь бясалгалын явцын зүйл бөгөөд Фалуны Дафа-гийн сурагчдад ярьж өгч байна. Та бүгд бол бясалгагчид, би энгийн хүнд ярьж өгөөгүй; би энгийн хүмүүст эдгээрийг хамаагүй ярьж болохгүй, олон энгийн хүн үүнд итгэх ч үгүй.

Тэгвэл, тэр үед та нар аливаа биетийн амь өмнө нь хүн байсан байж болох ч дараа нь тэр үхэж, өөр биетэд дахин төрдгийг олж мэдэх болно. Энэ хүртэл ярьсан болохоор, би нэг зүйл хэлмээр байна. Хойд төрөлд хүн нүглийг ч тээж явдаг, буяныг ч тээж явдаг. Өнөөгийн хүн төрөлхтний ёс суртахуун доройтох тусам хүмүүсийн Дэ гэх энэ төрлийн бие бодь улам бүр багасаж, нүгэл нь улам бүр ихэссээр байна. Амь бодиуд харилцан төрөл олдог учраас, одоо харвал зөвхөн хүний биед хар нүгэл байгаа юм биш, биет зүйлст ч бас хар нүгэл байгааг харах болно. Яагаад гэвэл амь бодь зургаан замын тойрогт дахин төрөл олохдоо эдгээр нүглийг тээж явдаг, иймээс нүгэл ямар ч биет дээр оршдог, энэ нь мөн өвчин үүсгэхэд хүргэдэг. Нүгэл хүн төрөлхтний энэ орон зайд илрэхдээ, бичил вирус хэлбэрээр илэрдэг. Өнөө үед нүгэл маш их болсон тул бүх зүйл түүнийг тээж явах боломжтой. Урьд өмнө Хятадын тариачид талбай дээр ажиллаж байгаад гараа зүсчихвэл жоохон шороо шүүрч аваад шархан дээрээ тавиад нэг их тоодоггүй байсан, тэгээд удалгүй шарх нь эдгэрдэг байсныг та бүхэн мэдэж байгаа байх. Харин өнөөдрийн шороонд чи хүрэхгүй байсан нь дээр. Энгийн хүн өчүүхэн төдий хүрэхэд халдвар авч, шарх нь идээлж, татран өвчнөөр ч үхэх аюултай. Яагаад вэ? Энэ нь өнөө үед хөрсөнд нүгэл тээгдэж байгааг харуулж байна. Тиймээс, дэлхийг дээд түвшний орон зайнаас харахад нүгэл хаа сайгүй байдаг, хар давалгаанууд давалгайлж байгаа мэт харагддаг. Хүний нүд үүнийг хардаггүй учраас, хүмүүс яахав зүгээр, болж байна гэж боддог.

Хүн бүр ханиад томуугийн талаар мэддэг, тийм үү? Ханиад томуу нь нэг ёсондоо өндөр нягтралтай маш том нүглийн бөөгнөрөл ирснээс болж үүсдэг. Харин тэдгээр хорт хавдар, ДОХ гэх мэт нь тодорхой чиглэсэн зорилготой хорт үйлийн үрийн өвчин юм, жишээлбэл, ДОХ нь садар самуун, ижил хүйстнүүдийн зан үйл рүү чиглэдэг бөгөөд тэдгээр нь бүр илүү нягтралтай нүгэл юм. Ерөнхийдөө нүгэл ихтэй газар хүмүүс өвддөг. Өндөр нягтаршилтай нүгэл аль газарт гарна, тэнд тахал халдварт өвчин дэгддэг, энэ нь тухайн газрын хүмүүсийн хэт их нүглээс үүдэлтэй байдаг.

Би яагаад энэ тухай ярьж байна вэ? Би хүн төрөлхтний ёс суртахуун маш ихээр доройтсоныг харсан, хэрэв энэ байдал үргэлжилбэл хүмүүст бүр том аюул нүүрлэх болно. Хэрэв тэнгэрийн бурхад хүнийг хүн гэж үзэхгүй болбол тэр бол жинхэнэ аюул. Хүнд хүний зан төлөв байх ёстой—хүний гадаад төрхтэй байснаар хүн гэж тооцогдох албагүй. Тэгвэл сармагчингууд ч гэсэн хүний дүр төрхтэй төстэй хэлбэртэй. Хэрэв хүнд хүний ёс суртахууны хэм хэмжээ байхгүй бол, ёс суртахууны шалгуур байхгүй бол, Бурхад хүнийг хүн гэж үзэхгүй, ийм тохиолдолд хүн хамгийн том аюулд орно. Яагаад гэвэл

хүнийг Бурхан бүтээсэн, Бурхан хүнийг харж ханддаг учраас тэр юм. Хүн төрөлхтний уламжлалт соёл Бурхадын зөвшөөрлийн дагуу бий болсон. Хүн хүмүүний хэм хэмжээнээс хазайхад Бурхад чамайг тоохгүй хаяна. Хүн өөрийн мэдэлгүй урсгал дагуу урсахад, бүх зүйлийг дордуулдгийг, өөрийгөө ч дордуулдгийг, нийгмийг ч доройтуулдгийг, ялангуяа хүн төрөлхтний ёс суртахууныг доройтуулдгийг би олж мэдсэн. Өнөөгийн хамгийн тод илрэл бол соёл хэрхэн чөтгөрийнх болж, хүний мөн чанарыг ёс бус болгосон явдал юм. Иймээс нийгэмд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүд, хар тамхины хэрэглээ, хар тамхины наймаа, садар самуун, ижил хүйстнүүд гарч ирсэн. Хүн төрөлхтөнд ноцтой худал хуурмаг явдал гэх мэтчилэн маш олон, маш олон зүйлс нэвчсэн, тэр битгий хэл гэмт хэргийн толгойлогчдыг хүртэл шүтэн биширдэг болсон. Энэ мэт маш олон зүйл байдаг, та бүгд бодоод үз дээ, энэ нь хэвийн байдал гэж үү? Хүн төрөлхтний үзэл баримтлалд ийм том өөрчлөлт гарсан байна! Зөвхөн эдгээр асуудлуудаар хязгаарлагдахгүй, бүх талаараа янз бүрийн хүрээнд хүний үзэл бодолд маш хүчтэй чөтгөрийн мөн чанар оршиж байна. Миний энэхүү Фа-г зааж буй зорилго бол хүнийг энэ аюулаас зайлуулж, хүнийг жинхэнэ утгаар нь бясалгалаар аврагдах боломжийг олгох юм. Хэрэв чи үнэхээр цааш нь бясалгаж чадвал, би үнэхээр чамайг Төгс төгөлдөрт хүргэж чадна.

Сая би энэ нийгмийн зарим үзэгдлийн талаар ярилаа. Одоогийн байдлаар би нийгмийн төлөө ямар нэгэн зүйл хийхийг хүсч байгаа юм биш; хийхийг ч бодоогүй. Гэвч, энэ Фа хүмүүсийг аварч чадна, хүмүүст сайн байхыг заадаг, энэ нь хүний шиньшинийг болон үндсэн мөн чанараас нь үнэхээр өөрчилж чадна. Тэгвэл бясалгадаггүй олон хүн байдаг ч хүмүүс энэ Фа сургаалыг ойлгочихвол, сайн хүн болж чадна. Хүн муу хүн байх нь өөртөө ямар их хор хөнөөл учруулдгийг мэдвэл (алга ташилт) тэд сайн хүн болно. Тэгвэл өөрөөр хэлбэл, ариун Фа олон нийтэд дэлгэрэхэд нийгэмд ашиг тусаа өгөх нь гарцаагүй гэсэн үг юм.

Би энэ хэдэн жилийн турш Фа-г заах явцдаа, ийм нэг зарчмыг баримталж ирсэн: Би хүмүүст хариуцлагатай байх, нийгэмд хариуцлагатай байх арга барилаар үүнийг хийж байгаа. Би үүнд хэзээ ч хайхрамжгүй хандаж байгаагүй. Та бүхэн мэдэж байгаа, би их холоос Сингапурт ирж, Фа-г түгээж байна, би та нараас нэг ч мөнгө авахгүй. Тэгээд л би явчихна, би гагцхүү энэ Фа-г та нарт үлдээж байна. Олон суралцагсад надаас асууж байсан “Багш аа, энэ орчлон ерөтнцөд “Алдахгүй бол олохгүй” гэдэг зарчим байдаг, олвол алдана, алдвал олно. Харин та биднийг ямар ч үнэ өртөггүйгээр аварч байна, бидэнд ийм их сайн сайхан зүйлийг өгч, Фа-г бидэнд зааж өгч, бясалгахад биднийг харж хамгаалж, бидний үйлийн үрийг арилгаж, бидний бие махбодод олон, олон зүйлийг суулгаж, өөр өөр түвшинд бидний олон асуудлыг шийдэж байна. Бясалгал өөрөөс шалтгаалдаг, гон Багшаас шалтгаалдаг - та тэгвэл биднээс юу хүсч байна вэ?" гэж асуудаг. Би юу ч хүсдэггүй гэж хэлсэн. Би энэ зүйлийг хийх гэж ирсэн болохоор би та нартай



адилгүй. Миний юу хүсч байгааг асуувал, би зөвхөн чиний тэр зүрх сэтгэлийг, бясалгах зүрх сэтгэлийг, сайн сайхан руу тэмүүлсэн зүрх сэтгэлийг чинь л харахыг хүсч байна. (Алга ташилт)

Би хэт их цаг авсан байна уу? (Инээв) Хэрэв өшөө цаг байвал би цааш нь ярьж болно. Буддын бясалгалын маш олон, олон арга байдаг. Та бүхний хичээллэж буй Фалунь Гон нь Буддын зарчмууд дээр суурилдаг гэдгийг та бүгд мэдэж байгаа—би зөвхөн Шагжамүнигийн урд өмнө заахдаа хэрэглэж байсан хэлийг ашиглаагүй, ашиглах ч боломжгүй, яагаад гэвэл өнөөдрийн хэл өөрчлөгдсөн хэл. Тиймээс би Фа заахдаа орчин үеийн хэлээр л заах боломжтой, өнөөгийн хүн төрөлхтний хэлийг л ашиглах боломжтой юм. Өнөөдөр миний зааж буй Фа нь нэгэн цагт Шагжамүнигийн заасан Буддын Фа-гаас ялгаатай. Яагаад вэ? Яагаад гэвэл миний бясалгагчдад өгсөн бясалгалын арга барил, бясалгалын зүйлс нь өнгөрсөн үеийн арга барил шиг биш. Бясалгагчдын шиньшинд болон түвшинд илүү өндөр шаардлага тавьдаг. Миний заадаг зүйл бол орчлон ертөнцийн хамгийн үндсэн Хууль учраас Бүтээлийн орон нь илүү өндөр байдаг. Будда Шагжамүнигийн тэр үед ярьсан үгс нь Буддын мөн чанартай байсан, тэр түвшний Буддын Фа гэж хэлж болно, гэхдээ орчлон ертөнцийг бүтээсэн үндсэн Фа болоод хамгийн дээд үнэн биш юм. Орчлон ертөнцийн хамгийн дээд үнэн бол Жэнь, Шань, Рэнь. Аливаа бие бодь, ган, төмөр, мод, чулуу, агаар, ус, хөрс, бүх бичил бие бодиуд, түүний эх сурвалжийн бүтцээс эхлээд гадаргуйн бие бодь хүртэл бүгдэд нь Жэнь, Шань, Рэнь мөн чанар оршдог. Бүхэл орчлон ертөнцийн бүх амь, бүх бие бодид Жэнь, Шань, Рэнь оршдог, энэ бол орчлон ертөнцийн хамгийн үндсэн мөн чанар юм. Би орчин үеийн хамгийн энгийн хэлээр зарчмуудыг маш энгийнээр тайлбарлаж өгч байгаа. Дафа бол пирамидтай адил, дээшлэх тусам улам энгийн болдог, доошлох тусам маш төвөгтэй болдог. Тиймээс хүн төрөлхтөн болоод орчлон ертөнцийн доод түвшнүүд их төвөгтэй байдаг. Хамгийн дээд цэгт буюу Буддын Фа-гийн хамгийн оргил нь Жэнь, Шань, Рэнь гэсэн гурван үгэнд л хураангуйлагддаг. Орчлон ертөнцийн бүхий л хамгийн дээд бие бодь болон хүчин зүйлс бүгд Жэнь, Шань, Рэнь-ээс бүрддэг. Энэ нь орчлон ертөнцийн сүнс, орчлон ертөнцийн мөн чанар, жинхэнэ Буддын Фа-гийн үндэс юм. Урьд нь энэ нь хамгийн дээд тэнгэрийн нууц байсан. Маш олон дээд түвшний амь бодиуд үүнийг бүгд мэддэггүй байсан. Гэвч би номондоо олон тэнгэрийн нууцыг дэлгэснийг та бүхэн харсан, гэхдээ би тэнгэрийн нууцыг дураараа илчилсэн юм биш. Хэрэв Ли Хонжи өнөөдөр тэнгэрийн нууцыг дураараа задалж, ямар ч зорилгогүйгээр ярьж бүгдийг баярлуулсан бол, эсвэл та нар үүнийг сонсоод зүгээр л мэдлэг болгон хүлээн авсан бол би энд тэнгэрийн зарчмуудыг эвдэж байгаа хэрэг болно. Хэрэв тийм байсан бол Ли Хонжи өнөөдөр энд зогсож байхгүй, аль эрт шийтгэгдэж ор сураггүй алга болох байсан. Би Фа-г заан тараахдаа хүн бүрийн өмнө хариуцлага хүлээдэг, ингэснээр л та нар дээш бясалгаж чадна. Бодит байдал дээр би хүмүүсийн өмнө байнга хариуцлага хүлээсээр ирсэн, үнэндээ маш олон хүн бясалгаад дээшилсэн. Тэгэхээр би үүнийг хий дэмий хийгээгүй гэсэн үг юм, зүгээр

сэтгэлийн хөөрлөөр гарч ирээд дураараа хийж байгаа юм биш. Үнэн хэрэгтээ энэ хэрэг түүхэнд аль эртнээс зохицуулагдсан байсан, аль эрт энэ хэргийн бүх бэлтгэл хангагдсан байсан. Өнөөдөр та нар энд суугаад Фа-г сонсох боломжтой байгаа нь чамд энэ хувь тавилан байна гэсэн үг юм, чиний хувь тавилангийн цаг ирсэн. Чи хүний ертөнцөд хичнээн удаа төрсөн нь хамаагүй, өнөөдөр чиний хувь тавилан ирсэн, ийм учраас чи Фа-г олж авч чадлаа.

Хэдийгээр Будда Шагжамүни энэ орчлон ертөнцийг үндсэндээ хэр том болохыг харж чадаагүй, мөн хэр их бичил болохыг нь харж чадаагүй ч түүний харсан зүйл хэдийнээ нэлээдгүй бичил хэмжээнд хүрсэн. Нэг ширхэг элсэнд гурван мянган хорвоо ертөнц байдгийг тэр харсан. "Гурван мянган хорвоо ертөнц" гэж юу гэсэн үг вэ? Жишээлбэл, манай Сүүн зам галактикт, хүн төрөлхтөнтэй адил, Тэнгэр газрын систем, мөн Бурхад, Будда нар оршдог, мөн хүн төрөлхтөнтэй адил нийгэм оршдог гурван мянган систем байдгийг Будда харсан. Энэ нь аливаа хорвоо ертөнц бүрт тоо томшгүй олон амь бодиуд байдаг, тэнгэрт Бурхад оршдог, дэлхийд хүн төрөлхтөн оршдог системтэй адил юм. Будда элсний нэг ширхэгт үүнтэй адил гурван мянган хорвоо ертөнц байдаг гэж хэлсэн. Та бүгд бод доо: Шагжамүнигийн харсан нь ямар их бичил түвшинд, ямар гайхалтай ч, энэ нь тийм ч итгэхэд бэрх зүйл биш юм. Жишээлбэл, дэлхий нарыг тойрон эргэдэг, одоогийн эрдэмтэд электрон атомын цөмийг мөн адил тойрон эргэдэг болохыг олж мэдсэн. Энэ нь дэлхий нарыг тойрон эргэдгээс ямар ялгаа байгаа юм? Адилхан. Тэгвэл, хэрвээ электроныг манай дэлхий шиг томруулбал чи түүн дээр амь бодиуд байгаа эсэх, хичнээн олон амь бодиуд байгааг, тэдгээр амь бодиуд ямар дүр төрхтэй болохыг харах болно. Бүр илүү бичил түвшинд бүр ч илүү бичил түвшний амь бодиуд байдаг. Шагжамүни нэг ширхэг элсэнд гурван мянган хорвоо ертөнц байдаг гэж хэлсэн. Хэрэв бид ингээд цааш нь хөөвөл, Шагжамүнигийн ярьсан энэ онолын дагуу, нэг ширхэг элсэнд гурван мянган хорвоо ертөнц байдаг гэж үзвэл, элсний ширхэг дэх гурван мянган хорвоо ертөнцөд хүн төрөлхтний ертөнцтэй адил бас гол мөрөн, нуур, тэнгис далай байдаггүй гэж үү? Тэгвэл гол мөрөн, нуур, далай тэнгист ч бас элс байна биз дээ? Тэгвэл, тэр элсний ширхэгт бас гурван мянган хорвоо ертөнц байгаа биш гэж үү? Тэгвэл энэ төсөөллийг баримталбал элсний доторх элсэнд мөн гурван мянган хорвоо ертөнц байгаа биш гэж үү? Тэдгээр нь тоолшгүй олон байдгийг би олж мэдсэн, бүр дээд түвшний агуу гэгээрэгсэд бүгд 'амь бодиуд тоо томшгүй олон, бие бодийн бичил нь хязгааргүй' гэж үздэг. Тэгвэл бие бодь хэр бичил байж болох вэ? Бүр дээд түвшний Бурхад, Будда нар ч түүний эх сурвалжийг харж чадахгүй, энэ эх сурвалжийг бүрдүүлдэг бие бодийг харж чадахгүй. Энэ тал дээр хүн төрөлхтний шинжлэх ухаан цэцэрлэгийн ангийн ч түвшинд хүрээгүй байна! Энэ нь үүрд харанхуйгаараа үлдэх бөгөөд үүнийг Буддын Фа-тай зүйрлэх ч арга байхгүй. Орчин үеийн шинжлэх ухаан зөвхөн нейтрино, кварк хүртэл л мэднэ, үнэндээ орчин үеийн шинжлэх ухаан ердөө л нейтрино болон кварк байдаг гэдгийг л илрүүлсэн, гэхдээ харж чаддаггүй, тэгээд ч тийм томоор томруулдаг микроскоп байдаггүй. Тийм ч учраас би

хормын өмнө Будда Шагжамүни бие бодийн анхны эх сурвалж юу байдгийг, орчлон ертөнцийн хамгийн том бие бодь гэж юу байдгийг харж чадаагүй гэж хэлсэн. Тиймээс тэрээр: “Гадаргуу нь хязгаар үгүй уудам, доторх нь хязгаар үгүй бичил” гэж хэлсэн. Том нь энэ орчлон ертөнцөд хил хязгаар үгүй, жижиг нь бие бодийн төгсгөл нь харагдашгүй. Рулай Будда (Татагата) хэдийнээ маш гайхалтай, тэр энэ хүртэл харж чадсан ч хамгийн эцэс хүртэл нь харж чадаагүй.

Өөрөөр хэлбэл, орчлон ертөнц маш өргөн уудам, бие бодиуд асар олон бөгөөд нарийн төвөгтэй. Бие бодь (матери) -ийн эх сурвалжийг ярихын тухайд, үүнийг хэдийнээ "бие бодь" матери гэж нэрлэх боломжгүй. Энэ нь Жэнь, Шань, Рэнь-ий Фа хүч ба мөн чанар нь үндсэн эх элементүүдээс анхдагч бие бодийг үүсгэсэн, улмаар Жэнь, Шань, Рэнь -ээр өөр өөр түвшний давхарга давхаргын бие бодиудыг үүсгэсэн, цаашилбал хүн төрөлхтний одоо танин мэдэж байгаа нейтрино, кварк, атомын цөм, атом, молекул болон гадаргуйн бие бодийн бүр том давхаргад хүрдэг. Энэ бүгд Жэнь, Шань, Рэнь-ий мөн чанараас бий болдог. Иймээс энэ орчлон ертөнцийн туйлын үнэн бол “Жэнь, Шань, Рэнь” бөгөөд энэ нь Буддын Фа-гийн үндэс юм.

Энэ гурван үгийг хэлэхэд амархан, хэрэв энэ Фа-г дэлгэвэл энэ нь үнэхээр том юм. Жэнь нь маш олон янз бүрийн түвшний зарчмуудыг агуулдаг, Шань ба Рэнь бас маш олон өөр өөр түвшний зарчмуудыг агуулдаг. Энгийн хүний түвшинд Жэнь нь хүнлэг байдал, зөв шударга, ёс зүй, цэцэн ухаан, итгэлцэл гэх мэт хүний маш олон зарчмуудыг агуулдаг; Шань энгийн хүний энэ түвшинд илрэхэд сэтгэл хөдлөлийг (*чин*) агуулдаг бөгөөд энэ бүгд орчлон ертөнцийн жинхэнэ болоод үндсэн Агуу хууль болох Жэнь, Шань, Рэнь-ээс үүдэлтэй Фа-зарчмууд юм.

Сэтгэл хөдлөлийн тухайд, хүн төрөлхтөнд хэрэв ямар ч сэтгэл хөдлөл байхгүй байсан бол, хүнд хоёр төлөв байдал байх байсан: нэг нь харь гаригийнхан шиг хүйтэн цэвдэг, эсвэл бурхад шиг нигүүлсэнгүй байх юм. Хүнд сэтгэл хөдлөл байдаг учраас л хүн болж байгаа юм. Хүний баярлах эсвэл гуниглах нь сэтгэл хөдлөл юм. Хүн ямар нэгэн зүйлд дуртай эсвэл дургүй байх; чи хэн нэгэнд сэтгэл дундуур байх эсвэл өөр хэн нэгэнтэй нөхөрсөг байх; чи ямар нэг зүйл хийхдээ баяртай байх, эсвэл тодорхой хэмжээний мөнгө олохыг хүсэх; эсвэл чи төрийн албанд сайн ажилд орохыг хүсэх - чи хийхийг хүсэж буй бүх зүйлээ илүүд үздэг ... чи энийг, тэрийг хийхийг хүсэх... хүний ертөнцөд бүх зүйл сэтгэл хөдлөлийн хүрээнд байдаг. Мөн хүн аливаа зүйлийн хойноос улайран зүтгэдэг, учир нь тэд сэтгэл хөдлөлдөө хөтлөгддөг. Фа хүн төрөлхтний нийгмийн энэ түвшинд хүрэхэд, хүнийг бүтээж хүний орон зайг бий болгосон, түүнчлэн хүний төлөв байдлыг тогтоосон. Бясалгах бол үндсэндээ хүний төлөв байдлаас гарч, сэтгэл хөдлөлд хөтлөгдсөн зүрх сэтгэлээсээ ангижрах юм, бясалгалын явцад аажмаар тэднийг хөнгөн харж, улмаар өөрийгөө аажмаар дээшлүүлэх юм.

Зарим хүн сэтгэл хөдлөл байхгүй бол амьдрал утгагүй шүү дээ, кино үзэхгүй, сэтгэл булаам ханьсах хүнээ олох сонирхолгүй, амттай хоол идэх хүсэлгүй бол ямар ч утгагүй гэж боддог. Би чамд хэлье, чи үүнийг энгийн хүний өнцгөөс харж байгаа юм! Хэрэв чи дээд түвшинд гарах юм бол тэдгээр түвшний үзэсгэлэнт байдлыг олж мэднэ, бүх зүйл хүний ертөнцөөс илүү сайхан гэдгийг олж мэдэх болно. Тэнд ямар үзэсгэлэнтэй байдгийг үгээр илэрхийлэхийн аргагүй. Харин чи тэрхүү үзэсгэлэнт сайхныг олж авахыг хүсвэл энгийн хүний сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй хүний ашиг сонирхолд автсан зууралдсан сэтгэлээсээ өөрийгөө ангижруулах ёстой. Чи энгийн хүний зууралдсан сэтгэлээсээ салж байж л илүү сайн сайхныг олж авах болно.

Та нар бүгдээрээ сурагчид учраас бясалгалын чинь явцад, миний та нарт тавих шалгуур өндөр байж магадгүй. Та нар бясалгах явцдаа энгийн хүний маш олон зууралдлаасаа салж чадахгүй байж магадгүй, гэхдээ зүгээр. Хэрвээ би өнөөдөр Фа-г зааж дуусгаад та нар бүгд тэр шаардлагад хүрчихвэл, шууд Будда болчихно. (Алга ташилт) Гэхдээ эхлэн суралцагсдад үүнийг хийхэд хэцүү. Хүн бүх зүйлээ нэг дор бүгдийг нь хаяна гэвэл, энэ нь боломжгүй. Энд суугаад Фа-г сонсоход хүн бүрт тав тухтай сайхан мэдрэмж төрдөг, миний ярихыг сонсох дуртай байдаг, учир нь энэ бол ариун Фа-гийн агуу буяны нөлөө юм. Ариун Фа бясалгалын энерги нь нигүүлсэнгүй, амар амгалан, бүх сөрөг хүчин зүйлсийг цэвэрлэж, өөрчлөх чадвартай байдаг. Тийм ч учраас энд суухад хүн бүрт тав тухтай сайхан санагддаг. Ирээдүйд та нар бясалгалын тодорхой түвшинд хүрэх үед мөн адил ийм байх болно. Та нарт орхиогүй олон зууралдсан сэтгэл байсаар байгаа, зөвт бодол чинь хүчтэй болоогүй байгаа учраас та нар эхэн үед үүнийг хийж чадахгүй. Энгийн хүний нийгэмд чамд тааралдсан хүн хүний хоорондын сэтгэл хөдлөл, мөн хувийн ашиг сонирхолын мөргөлдөөн тодорхой хэмжээгээр үймүүлэл үүсгэдэг. Мөн түүнчлэн нүглийг арилгахад чиний бие таагүй болно. Хэцүү байдлын дунд өөрийгөө хэрхэн барих вэ? Хэрэв чи өөрийгөө дээшлүүлж чадаж байвал, аливаа зөрчилдөөнийг энгийн хүн шиг авч үздэггүй бол, чи дээшилж байна гэсэн үг, зөв бодол чинь хүчирхэгжиж байна гэсэн үг. Хүн чамайг цохиход "Би бясалгадаг хүн, та нар бол энгийн хүн, би чамтай адилгүй" гэж бодвол, чи дээшилж байна гэсэн үг. Хэрэв чи үнэхээр цохиулсан ч хариу цохилт өгөхгүй, загнуулсан ч эргэж хэрэлдэхгүй, бусад хүмүүс ашгин дээр чамтай тэмцэлдэж булаацалдахад, чи үүнийг хөнгөн хүлээж авч чадаж байвал энэ нь зөвхөн нэг бодлоор л зөрөөтэй байсан ч чи энгийн хүмүүсээс аль хэдийн мянган бээрээр холдсон юм. Гэсэн хэдий ч, хэрэв чи энэ хэмжээнд хүрэхийг хүсэж байвал энгийн хүмүүсийн дунд аажмаар бясалгаж дээшлэх хэрэгтэй, тэгээд аяндаа энэ байдалд хүрнэ. Чи "би шууд үүнд хүрчихнэ" гэвэл, энэ нь хийхэд маш хэцүү. Заавал амьдрал дээр, мөн сорилтуудын дунд зууралдсан сэтгэлээ орхих ёстой, ингэснээр л бясалгаж дээшлэх нь бат бөх байх болно.

Хүн төрөлхтний шинжлэх ухаан хэзээд ч үүрд Буддын түвшинд хүрч чадахгүй. Яагаад? Яагаад гэвэл хүн төрөлхтний оюун ухааныг дээд

оршихуйнууд хязгаарлаж, удирддаг. Яагаад? Учир нь хүнийг бурхад бүтээсэн бөгөөд хүний зарчим урвуу байдаг. Будда гэж юу вэ? Тэр бол өөрийн түвшний бүх амь бодийг батлан даагч, бүх амь бодийг хамгаалагч, орчлон ертөнцийн үнэнийг хамгаалагч юм. Та бүгд бодоод үз дээ, хүнд янз бүрийн зууралдсан сэтгэл байдаг, алдар нэр, ашиг, эд баялаг, сэтгэл хөдлөл, хүсэл тэмүүлэл, атаа жөтөө гэх мэт, ийм байдалтай Буддын хүрээнд оччихвол Буддатай тэмцэлдэж магадгүй юм. Яаж ингэж болох юм! Тиймээс чи энгийн хүмүүсийн дунд эдгээр хүний сэтгэлээ орхих ёстой, тэгвэл л чи тэр хүрээнд, тэр зэрэгт хүрч чадна. Одоо зарим лам хувраг нар энгийн хүмүүст “Чи бол Будда! Чи Буддын нэрийг сүсэглэн уншаад байвал, хүссэн хүсээгүй амьдрал чинь дуусмагц Будда болно” гэж хэлдэг. Энэ бол Буддаг гүтгэж, Фа-г гуйвуулж байгаатай адил юм. Лам хувраг бол хүн, жинхэнэ бясалгаж чадсан хүмүүс ч гэсэн зүгээр л бясалгагчид байдаг. Сайн бясалгаагүй бол энгийн хүнтэй адил, юу ч биш юм. Бясалгалын явцад алдаа гаргавал түүний үйлдсэн нүгэл нь энгийн хүнийхээс ч их байх бөгөөд үүнийг “Буддын орхимж өмссөн Буддын Фа-г эвдэгч” гэж хэлдэг. Тиймээс жинхэнэ бясалгадаггүй лам хувраг нарт сохроор бүү итгэ. Жинхэнэ бясалгалын тухайд хүн зүрх сэтгэлээ бясалгах юм, хүн өөрийн зууралдсан сэтгэлээ арилгахгүй бол хэзээд ч тэр түвшинд хүрч чадахгүй. Хэрэв хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн тусламжтайгаар тэнд хүрвэл үнэхээр оддын дайн, ертөнцийн том дайн дэгдэнэ. Тиймээс Будда нар үүнийг хэзээ ч зөвшөөрөхгүй. Энэ бол зүгээр л шинжлэх ухааны зөгнөл. Хэзээ ч биелэхгүй. Хэрэв хүн илүү өндөр түвшинд хүрч, дээд амь бодиудыг мэдэхийг хүсэж байвал - хэрэв чи дээд амь бодь болохыг хүсэж байвал эсвэл ертөнцийн үнэнийг жинхэнэ утгаар нь мэдэхийг хүсэж байвал, цорын ганц арга зам бол бясалгах юм, гагцхүү энэ л юм. Тиймээс би та бүгдэд хэлье, үүнээс хойш та нар энгийн хүний нийгэмд ямар ч зөрчилдөөнтэй тулгарсан бай, шиньшин-ий ямар ч мөргөлдөөн гарсан бай, хэн нэгэн чамайг уурлуулсан ч бай, хэн нэгэн чамайг хохироосон, хэн нэгэн чамайг дээрэлхэж, эсвэл чи ямар нэг хэлбэрээр зовж шаналах нь хамаагүй, энэ нь заавал муу зүйл байх албагүй гэж би та нарт хэлье. Хэрэв чи үнэхээр бясалгахыг хүсэж байвал би чамд хэлье, чиний энэ амьдралын замыг шинээр чамд зохицуулж өгнө. Яагаад үүнийг шинээр зохицуулах хэрэгтэй вэ? Яагаад гэвэл хүнд хүний нэг насны амьдрал байдаг, хүн бясалгахаас өмнө түүний ирээдүй энгийн хүний нэг насны амьдрал юм, аль нэг өдөр магадгүй үхнэ. Зарим хүн бусдаас урт наслаж болох ч ийм хүмүүс хэзээ хүнд өвчин тусах, хэдэн жил өвчтэй байхыг хэн ч мэдэхгүй. Ийм хүмүүс яаж бясалгах юм? Эсвэл зарим хүн томоохон бэрхшээлүүдийг туулж магадгүй. Энэ бүгд бясалгах боломжгүй болгоно. Би чиний энэ замыг цэвэрлэж, эдгээр бүх зүйлийг арилгаж, бясалгалын замыг чинь зохицуулж өгнө. Мэдээжийн хэрэг, энгийн хүмүүст үүнийг хамаагүй хийж өгч болохгүй. Гагцхүү бясалгадаг хүнд л хийж өгч болно.

Тэгвэл бясалгадаг хүн яагаад ийм онцгой байдаг вэ? Яагаад гэвэл хүний амьдрал хүн байхын тулд байдаггүй болохоор тэр юм. Чиний амь энэ

Дэлхийгээс үүсэлтэй биш юм; чиний амь бүр дээд орон зайнаас үүсэлтэй. Буцаж явах нь чиний амьдын зорилго юм, иймээс бясалгах хүсэл нэг төрөхөд энэ нь алтнаас ч илүү гялалзаж, арван зүгийн хорвоо ертөнц даяарх Будда нар бүгд хардаг. Хүнд бясалгах хүсэлтэй ийм бодол төрөхөд ийм л нандин байдаг. Энгийн хүнд хамаагүй хийж өгч болохгүй, яагаад гэвэл энгийн хүмүүс ер нь өмнөх амьдралууддаа сайнгүй зүйл хийсэн байдаг тул энэ насандаа тэд үүнийг төлөх ёстой болдог. Хэрэв чи түүний нүглийг хамаагүй арилгаж өгвөл, зовлон зүдүүрээс нь салгаж өгвөл, хүмүүс муу зүйл хийж болно, үүнийгээ төлөх хэрэггүй гэсэнтэй адил болно. Энэ нь Буддын зарчмуудыг болон Тэнгэрийн Фа-г эвдэж байна гэсэн үг. Ийм зарчим гэж хаана байх юм? Огт байхгүй. Будда, Бумба, Бурхад бүгд орчлон ертөнцийн зарчмуудыг хамгаалж, Жэнь, Шань, Рэнь-ий Фа зарчмуудыг сахин хамгаалах зүйлс үйлддэг. Тийм учраас бясалгагч хүний хувьд чи ямар нэг зовлонтой тулгарахад, ямар нэг бэрхшээлтэй тулгарахад дөрвөн зүйл олж авна гэж би хэлдэг. Хүн чамайг дээрэлхэж, чамайг хохироож, ашиг сонирхолд чинь халдахад, тэр хариуд нь чамд буянаа өгөх болно, тэдгээр нь [чиний олж авсан зүйлс] илүү том ашиг болж хувирч болно. Түүнчлэн чи гашуун зовлон амсахад, чи алдсан талд харьяалагддаг, чи гашуун зовлон амссан болохоор чиний бие дэх нүгэл бас буян болон хувирдаг. Хэр их хэмжээгээр зовно, тэр хэмжээгээр хувирана. Тэгвэл чи бясалгадаг хүний хувьд энэ зөрчлийн дунд бусдын адил хандаагүй. Чи сэтгэлдээ асуудлыг бусдын адил авч үзээгүй тул чиний гон өсөх болно. Яагаад тэр вэ? Чиний шиньшин сайжирсан учраас тэр юм. Шиньшин-ий түвшин хэдий чинээ өндөр байна, чиний гон тэр хэмжээгээр өндөр байдаг— энэ бол туйлын үнэн. Чиний шиньшин дээшлээгүй байхад, гон чинь өснө гэж байхгүй, энэ бол боломжгүй, учир нь энэ орчлон ертөнцийн Фа бүх амь бодийг хязгаарладаг. Энэ орчлон ертөнцийн бүх бие бодь бүгд амьд юм, тэдгээрийг бүгдийг нь Жэнь, Шань, Рэнь бүтээсэн. Тиймээс тэд ч гэсэн хүнийг хязгаарлаж байдаг, хэрэв чи тэр шалгуурт нийцэхгүй бол бүх хүчин зүйлс чамайг дээшлүүлэхгүй. Энэ нь миний ярьсан нэг зарчимтай адил юм: нэг лонхыг бохир зүйлсээр дүүргээд усанд хаявал "пол" хийгээд тэр шууд ёроол руу живнэ. Чи тэр бохир зүйлсээс бага зэрэг гаргавал энэ нь бага зэрэг дээш хөвнө; дахиад бага зэрэг гаргавал, дахиад бага зэрэг хөвнө. Чи лонхноос бүх бохир зүйлийг гаргаж хоосолбол, доош дарсан ч живэхгүй болно. Энэ нь усан дээр хөвөх бөгөөд байх ёстой газартаа байна. Хэрэв чи жинхэнэ бясалгавал, энэ нь бохир зүйлийг гаргахтай адил юм: хэр их гаргана тэр хэмжээгээр бясалгаж хүрнэ гэсэн үг. Ийм л зарчимтай байдаг.

Надад ярихыг хүссэн их олон зүйлс байдаг. Яагаад гэвэл би та бүхнийг Фа-гаас илүү ихийг олж авахад туслахыг хүсэж байна, тиймээс ярьж эхэлмэгцээ та нарт олон зүйлийн талаар ярьж өгмөөр санагддаг. Мэдээж, энэ маш хязгаарлагдмал хугацаанд ярих гэсэн бүх зүйлээ ярих боломжгүй юм. Энэхүү "Жуань Фалунь" ном бол миний Хятадад Фа тараан зааж байх үеийн хэд хэдэн цуврал лекцийн агуулгыг багтаасан. Би тэдгээрийг нэг ном болгон эмхэтгэж, хэвлэгдэхээс нь өмнө биечлэн засварласан. Тиймээс энэ нь

бясалгалыг системтэйгээр удирдан чиглүүлэх Фа юм. Одоо миний лекцүүдийн аудио болон видео бичлэгүүд байгаа тул та нар үзэж, сонсоод бясалгалдаа нэмэлт болгож болно.

Мөн би та бүхэнд хэлье, Буддын Фа-гийн агуу хүч болон өөрийн төрөл бүрийн чадварыг энэхүү номонд, энэ Фа-д би шингээж өгсөн. Видео бичлэг ч бай, аудио бичлэг ч бай, ном ч бай - та нар үүнийг үзэж, сонсож, уншсан л бол өөрчлөлтийг мэдрэх болно. Уншсан л бол та нар өвчнөөс дархлагдаж чадна. Чи бясалгаж л байвал чиний биед үндсэн өөрчлөлт гарах болно. Чи цаашдаа тууштай байгаад л байвал, чамд чадвар гарна. Мөн та нар Дафа-гийн хязгааргүй ач ивээлийг харж, сонсож, мэдрэх болно. Хэрэв чи жинхэнэ бясалгагч бол би чамд Буддын Фа-гийн бүх хүчирхэг хүчийг өгөх болно. Чи бясалгаж л байвал тэдгээрийг олж авах болно. Мэдээж, чи бясалгахгүй бол олж авахгүй нь ойлгомжтой.

Номын дотоод утга санаа нь маш гүн гүнзгий бөгөөд анхны удаа уншихад бол илчлэгдэхгүй мөн ойлгогдохгүй. Яагаад гэвэл та нар алхам алхмаар бясалгах хэрэгтэй, энгийн хүний энэ түвшнээс эхлэж байгаа болохоор, чамайг энэ түвшний Фа-гаар удирдан чиглүүлж бясалгуулна. Харин чи бясалгаад дээшлэх үед, дахиад энэ зарчмаар чамайг удирдан чиглүүлнэ гэвэл үйлчлэхгүй. Жишээлбэл, хэрэв чи дунд сургуульд сурахдаа бага сургуулийн сурах бичгийг ашиглавал бага сургуулийн сурагч хэвээрээ л байна. Хэрэв чи коллежид суралцсан ч бага ангийн сурах бичгийг ашигласаар байвал бага ангийн сурагч хэвээрээ л байна. Өөрөөр хэлбэл, чи бясалгалаар тодорхой түвшинд хүрэх үед тухайн түвшний Фа илэрч чамайг удирдаж бясалгуулна. Зөвхөн ийм байдлаар л чи дээшээ бясалгах боломжтой юм. Жуань Фалунь номонд би энгийн хүний түвшнээс орчлон ертөнцийн хамгийн дээд түвшин хүртэлх Фа зарчмуудыг багтаасан. Бүх түвшний Фа зарчмуудыг номонд шингээсэн байгаа, гэхдээ тэдгээр нь өнгөн дээрээ харагдахгүй. Эхний уншилтаар хэрхэн сайн хүн болох зарчмыг олж мэдэх болно. Чи үүнийг хоёр дахь удаагаа уншихад энэ нь өөр гэдгийг ойлгох болно. Гурав дахь удаагаа уншсаны дараа чи жинхэнэ бясалгалын ном болохыг олж мэднэ. Чи үүнийг үргэлжлүүлэн унших тусам энэ нь тэнгэрийн ном болохыг олж мэдэх болно. Адилхан нэг өгүүлбэрээс чи өөр өөр түвшний, өөр өөр хүрээний, өөр өөр танин мэдэхүй, өөр өөр ойлголтыг авна. Номонд асар их утга агуулагдаж байгаа. Одоо маш олон хүн энэ номыг уншиж байгаа, зарим нь зуу гаруй удаа уншсан ч уншсаар л байна. Чи арван мянган удаа уншсан ч, унших юмгүй болсон мэт санагдахгүй. Харин эсрэгээрээ чи өмнө нь мэдэрч байгаагүй маш олон зүйл байгааг олж мэдэх болно, мөн чи маш олон шинэ ойлголттой болсоор байх болно, тийм ч учраас энэ ном маш нандин юм. Би энд бүх талыг багтааж ярих боломжгүй. Хэрэв чи бясалгаж чадна гэвэл, миний бодлоор, үүнийг нухацтай авч үзэн үргэлжлүүлэн сур, ахин дахин унш, чи бүх зүйлийг олж авах болно. Чиний эхний уншилтаар гарч ирсэн асуултуудынхаа хариуг хоёр дахь уншилтаараа олж авах болно. Дараа нь чамд шинэ асуултууд гарч

ирэх боловч гурав дахь удаагаа уншихад эдгээр бүх асуултын хариултыг дахин олж авах болно. Чи үүнийг үргэлжлүүлэн унших тусам чамд илүү дээд түвшний асуултууд гарч ирэх бөгөөд чи уншихаа зогсоохгүй л бол чи бүх асуултандаа хариултыг авах болно.

Миний ярьсан зүйлс та бүгдийн таалалд нийцэх эсэхийг мэдэхгүй байна. (Алга ташив) Би та нарыг бясалгалдаа дээшлээсэй гэж хүсэж байгаа тул би арай өндөр түвшний зүйлийн талаар ярилаа. Хэрэв ямар нэгэн зохисгүй зүйл байвал та нар хэлж болно. Та бүхэнд баярлалаа. (Удаанаар алга ташив)



## АНУ-д болсон Анхны Фа сургаал

Ли Хонжи

1996 оны 10-р сарын 5 ~ Сан Францискогийн хойгт

Хүн бүрд харагдахын тулд би энд сууя. (Алга ташилт)

Олон хүн алс холоос энд өглөө эрт унаагаар яаран ирцгээсэн. Одоо энд байгаа олон хүн бясалгаж байгааг би мэднэ, би ч гэсэн АНУ-д ирж үзье гэж боддог байсан. Янз бүрийн шалтгааны улмаас энд ирэх боломж надад олдохгүй байлаа. Энэ удаад та нартай уулзаж буй нь хувь тавилан юм, энэ бясалгалыг сурах нь бас хувь тавилан юм. (Алга ташилт) Би АНУ-д илүү олон хүнтэй уулзахын тулд, Хьюстонд уулзалт хийхээр төлөвлөсөн байсан тул замдаа энд түр саатан та бүхэнтэй хамгийн түрүүнд уулзаж байна. (Алга ташилт)

Энэ бясалгал, энэ Фа-гийн талаарх хүн бүрийн мэдлэг гүн, гүехэн байдаг шиг ойлголт нь бас өөр өөр байдаг, яагаад гэвэл миний заан тарааж буй зүйл бол Буддын системийн бясалгалын арга, Буддын системийн хэллэгээр, үүнийг олж авах нь хувь тавилан юм. Яг одоо чи үүнийг ямар нандин болохыг мэдэхгүй байгаа ч, нандин гэдгийг нь мэдэх үед чи өөрийгөө маш азтай гэдгээ мэдрэх болно. Миний заадаг эдгээр зарчмуудыг болон хүн бүрийн бясалгалыг удирдан чиглүүлж чадах зүйлсийг олон зуун, олон мянган жилийн турш, үнэндээ бүр ч урт удаан хугацаанд хэн ч олон нийтэд ярьж байгаагүй. Түүхэнд хэн ч энэ тухай огт ярьж байгаагүй. Бясалгалын тухай ярихад, Хятадын энэ онцгой орчин дахь олон тооны түүхэн бясалгагчид хүн бүрийн санаанд ордог. Үнэндээ тэдгээр бясалгагчид одоо ч байсаар байгаа, мөн дэлхий даяар тархсан бусад маш олон бясалгагчид байдаг. Хүний хөлөөс зайдуу газар бясалгадаг хүмүүс байсаар ирсэн, тэд нэлээд өндөр настай хүмүүс байдаг. Тэд хүмүүсийн орчноос зайлсхийж, энгийн хүмүүстэй харьцдаггүй тул энгийн хүмүүс тэдний талаар мэддэггүй.

Өнөөгийн шинжлэх ухаан, технологи хөгжихийн хэрээр, хүмүүс "бодит байдал"-ыг улам бүр хүлээн зөвшөөрснөөр, хүн төрөлхтний жинхэнэ түүх, тэр жинхэнэ үнэн аажмаар орхигдсон. Орчин үед хүмүүс ийм зүйлсийн талаар ярих болгонд үлгэр домог ярьж байгаа мэт санадаг, үнэндээ тийм биш юм. Эдгээр ариун шашин болоод эртний маш олон домог түүх яагаад хэдэн мянган жилийн турш тасралтгүй үргэлжилж чадсан бэ? Үүнд ямар нэгэн шалтгаан байх нь зайлшгүй. Энгийн хүний нийгэмд бид өөрсдөө ч тайлбарлахын аргагүй маш олон, маш олон янз бүрийн үзэгдлүүдтэй

тааралддаг, эсвэл сонссон, эсвэл өөрсдийн биеэр мэдэрсэн байдаг. Тэдгээрийг өнөөгийн сэтгэлгээний хэв маяг, шинжлэх ухааны онолоор тайлбарлах боломжгүй юм. Учир нь шинжлэх ухаан хангалттай хөгжөөгүй, бас тийм өндөр түвшинд хөгжиж чадахгүй байгаа учраас юм. Үнэндээ эдгээр зүйлс бүгд байдаг гэж би хэлнэ. Гагцхүү орчин үеийн хүмүүс шинжлэх ухаанд хэт их итгэдэг, гэвч энэ нь тийм ч дэвшилтэт биш юм, шинжлэх ухаанаар энэ орон зайг нэвтэлж, үнэнийг ойлгох ямар ч арга байхгүй.

Өнөөгийн шинжлэх ухаан, технологийн тухайд, хүмүүс маш их хөгжсөн гэж боддог ч үнэндээ орчлон ертөнцийн Үнэн-тэй харьцуулахад маш доогуур түвшинд байна. Хүмүүс компьютерийг маш дэвшилтэт гэж үздэг ч, хичнээн дэвшилтэт байсан ч хүний тархитай харьцуулшгүй; хүн төрөлхтний хувьд хүний тархи нь үүрд мөнхийн нууц байх болно. Ирээдүйд маш олон хүн Фа-д суралцаж бясалгаснаар гон нь нээгдэж гэгээрэх, бясалгаад Төгс төгөлдөрт хүрэх тэр үед маш бичил түвшнээс, агуу уудмын түвшин дэхь амь бодь, орчлон ертөнц, бие бодийг ойлгох болно.

Та бүхэн мэдэж байгаа, бие бодийн тухайд бичил ширхгүүд нь арай том давхаргын ширхгүүдийг бүрдүүлдэг, дараа нь эргээд арай том ширхгүүдийн давхарга нь бүр том давхаргын ширхгүүдийг бүрдүүлдэг, эцэст нь гадаргуйн бие бодь буюу гадаргуйн матери үүсдэг. Ийм байдлаар нейтрино хэрхэн кварк, дараа нь атомын цөм, дараа нь атомыг бүрдүүлдэгтэй төстэй юм. Хүн төрөлхтний хамгийн гадна талын гадаргуйг бүрдүүлдэг энэ давхрагын бие бодь буюу гадаргуй дээрх молекулын ширхгүүд нь бүгд янз бүрийн, бүр бичил хэмжээний бие бодиудаас бүрддэг. Өнөөгийн эрдэмтэд зөвхөн микроскопоор харах боломжтой бичил ширхгүүдийн бүтцийн талаар л мэддэг. Тэд молекулууд, атомууд гэх мэтчлэн нейтрино хүртэл л байдгийг мэддэг. Дахиад цааш нь хөөвөл, багаж хэрэгсэлийн тусламжтайгаар ч харагдахгүй. Хэрэв хангалттай хүчирхэг, том диаметртэй микроскоп байсан бол, молекулын нэг ширхэг эсвэл хэд хэдэн молекулын ширхгийг биш, харин бичил ширхгүүдээс бүрдсэн тухайн давхаргыг харж чадвал, хүн өөр орон зайг харж байна гэсэн үг юм. Олон жилийн туршид хүн энэ үзэл бодлын хүрээг нэвтэлж чадаагүй, зөвхөн нэг буюу хэд хэдэн бичил ширхгүүдийг ажиглах дээр төвлөрдөг. Тэд энэ үзэл баримтлалаас салаагүй болохоор, тэдгээрийг холбож түүний бүхэл бичил ширхгүүдийн оршиж буй хавтгай ямар янзтай байгааг мэдэж чадахгүй. Ийм байвал, энэ нь өөр орон зай гэсэн үг юм. Ийм л энгийн. Одоо эдгээр зүйлст нэвтэрч чадахгүй; өнөөгийн технологи ч үүнд хүрч чадахгүй.

Би сая эдгээр зүйлсийн талаар орчин үеийн хүний сэтгэлгээний хэв маяг, хэл яриаг ашиглан ярилаа, эдгээр нь хүн мэдэхийг хүссэн ч мэдэхийг зөвшөөрдөггүй байсан зүйлс юм. Орчлон ертөнцийн жинхэнэ зарчмуудыг хэн ч хүнд илчилж байгаагүй, урьд нь хүнд мэдэхийг зөвшөөрдөггүй байсан. Учир нь тэнгэрийн зарчим дагуу, хүн маш өндөр түвшний тэнгэрээс алхам

алхмаар энэ энгийн нийгэмд бууж ирсэн, өөрөөр хэлбэл тэд дэлхий рүү бууж ирсэн. Бясалгалын хүрээнд Дарвины хувьслын онолыг хүлээн зөвшөөрдөггүй, яагаад гэвэл хүн сармагчнаас хувьсаж үүсээгүй. Үнэндээ дээд оршихуйн амь бодиудын хардаг зүйл нь үнэхээр огт өөр байдаг. Өнөөгийн туршлага дээр суурилсан шинжлэх ухааны мэдлэг нь олон хуурамч зүйлсийг зохиомлоор бий болгосон, хүн төрөлхтөн үүнийг нэвтэлж зүрхлэхгүй байна. Хүн эдгээр маш доогуур түвшний ойлголтоос зарим бодит ашиг тусыг хүртэж шинжлэх ухааны мэдлэгтэй болсон мэт боловч, үнэн хэрэгтээ эдгээр нь бүгд хүн төрөлхтөн, амь, орчлон ертөнцийг сүйтгэх чанартай бөгөөд алив амь бодид дээшлэх зүйлсийг хэзээ ч авчрахгүй. Тийм ч гэсэн, зарим хүн эрх мэдлийн төлөө, өөрийнхөө эрдэм мэдлэг гэгчээ хамгаалдаг, тэр зүйлсээ бусдаар үгүйсгэгдэхээс хамгаалдаг, бусдыг бүр өндөр ойлголттой байхыг хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс, зарим зүйлд хүн буруугаа мэддэг ч сэтгэл хөдлөлөөрөө эдгээр зохисгүй зан байдлыг хамгаалдаг. Гэвч орчлон ертөнцийн үнэний тухайд, хүн өөрөө өөрийнхөө үйлдлээр өөрийгөө битүүмжилчихсэн юм. Бясалгал бол хүнийг жинхэнэ утгаар нь дээшлүүлдэг, бясалгадаг хүн амь ба орчлон ертөнцийн үнэнийг харж, түүнтэй холбогдож чаддаг.

Өнөөгийн хүмүүс орчин үеийн шинжлэх ухаанаар маш нягт битүүмжлэгдсэн байдаг болохоор эдгээр үнэнийг тэд бүгдийг нь "мухар сүсэг" гэж үздэг. Гэхдээ мухар сүсэг байлаа ч, эрдэмтэн, ухаантай хүмүүс үүнийг яагаад мухар сүсэг гэж байгааг, хүн яагаад үүнд маш их итгэж байгааг судлах хэрэгтэй. Өнөө үед хэн ч ийм зүйлд хүрч зүрхлэхгүй байна. Миний бодлоор, АНУ-ын энэ орчинд энэ нь хавьгүй дээр байж магадгүй юм, маш олон хүнд энэ хязгаар байдаггүй, гэхдээ орчин үеийн эмпирик шинжлэх ухааны бий болгосон хүлээс нь хүнийг өөрийн оюун ухаанаа битүүмжлэхэд хүргэсэн, тийм болохоор амь, орчлон ертөнц, бие бодийн үнэн байдлыг танин мэдэхэд тун хэцүү болсон.

Бясалгалаар, ялангуяа Буддын Фа-гаар орчлон ертөнцийн үнэнийг танин мэдэж, ойлгож болно. Харин одоогийн хүмүүс зөвхөн орчин үеийн шинжлэх ухаанд л итгэдэг, тэдгээр зүйлсийг Бурханлаг сургаал, шашинд хамаардаг зүйлс гэж үздэг, шинжлэх ухаан биш гэдэг. Үнэндээ бол энэ нь хүн төрөлхтний хувьд орчлон ертөнцийг ойлгох цорын ганц арга зам юм. Та бүхэн мэдэж байгаа, Эйнштейн өөрөө амьдралынхаа сүүлийн жилүүдэд шашинд итгэдэг болсон. Шинжлэх ухаанд нэлээд амжилтанд хүрсэн гэгддэг олон хүн эцэстээ шашин руу орсон. Тэд шашинд номлодог зарчмууд нь бүр дээд үнэн гэдгийг олж мэдсэн. Хүн төрөлхтний ойлголт хязгаарлагдмал бөгөөд энэ хязгаарыг давж гарахад, шинжлэх ухаан хүчин мөхсөддөг. Харин Буддын Фа бол орчлон ертөнцийн бүх үзэгдлийг тайлбарлаж чаддаг. Тэдгээр хүмүүс Бурханын сургадаг зүйл нь бүр дээд зэргийн шинжлэх ухаан гэдгийг олж мэдээд шашин руу орсон юм.

Мэдээж, би энэ Фа-г чийгон хэлбэрээр зааж байгаа ч үнэн хэрэгтээ үүнд багтсан зүйлс асар агуу юм. Түүхэнд үүнийг хэн ч ярьж байгаагүй зүйлс, би үүнийг гаргаж ирж ярьсан. Хэрэв чи Жуань Фалунь номыг чин сэтгэлээсээ уншиж чадвал, энэ нь үнэхээр нандин болохыг олж мэдэх болно. Үүнд маш олон тэнгэрийн нууц илчлэгдсэн байдаг бөгөөд зүгээр өнгөцхөн уншсан ч гэсэн хүнд маш их ашиг тусыг өгдөг. Яаж хүн байх ёсыг ерөнхийд нь ойлгох болно. Харин бясалгахыг хүсдэггүй хүн Жуань Фалунь-ий дотоод утга агуулга, түүний дээд түвшний зарчмыг олж харахгүй. Гэхдээ түүний дотоод агуулга нь асар том бөгөөд хүнийг бясалгуулаад Төгс төгөлдөрт хүргэж чаддаг. Мөн энэ нь Төгс төгөлдөрт хүргээд зогсохгүй, тухайн амийг бүр өндөр түвшинд гаргаж чаддаг.

Бясалгалын зүйлс бол биеийн тамирын дасгалаас өөр зүйл гэдгийг та бүхэн мэднэ. Би та бүхэнд зөвхөн бие сайжруулах дасгалыг заасан бол, ийм агуу Фа-г заахгүй байх байсан. Яагаад гэвэл та бүхнийг энэхүү Фа-г олж аваг, энэ орчлон ертөнцийн үнэнийг мэдэг, бясалгаж чадах боломж олгоё, бүр өндөр түвшинд өөрийгөө бясалгаж дээшлүүлэх боломжийг олгоё, та нарыг ахиг гэсэн үүднээс би хийсэн. Хэрэв та нар бясалгалын явцад миний тодорхойлсон зүйлсийг хийж чадвал энэ ном та нарыг зорилгодоо хүрэхэд тань чиглүүлэх болно. Харин бясалгахыг хүсдэггүй хүмүүс энэ бүхнийг харахгүй. Яагаад харж чадахгүй гэж байгаа вэ? Ер нь хүн анх удаа энэхүү номыг уншихад хэрхэн сайн хүн болох зарчмыг зааж байгааг олж хардаг. Тэр үүнийг хоёр дахь удаагаа уншихад өөр байна; энэ үед үүнийг бясалгалын ном болохыг харах болно. Хэрэв үүнийг гурав дахь удаагаа уншвал, үнэхээр дараалан гурван удаа уншиж чадвал, номыг орхихыг хүсэхгүй болж магадгүй. Зав л гарвал уншаад байна, тэгээд энэ нь тэнгэрийн ном болохыг чи олж харна.

Утга зохиолын талаас харахад дүрэм, хэл зүйн бүтэц тийм ч стандарт биш байгааг та нар анзаарсан байх. Яагаад гэвэл өнөөгийн стандартчилагдсан хэл маш гүн гүнзгий утгыг агуулж чадахгүй, би хэт стандарчлагдсан энэ орчин үеийн дүрмийг ашиглаж заагаагүй, түүнээс зайлсхийсэн; түүнчлэн стандартчилагдсан хэл ба стандартчилсан нэр томъёо нь зарим зүйлийг тайлбарлаж чадахгүй тул би нутгийн хэллэгийг маш их ашигласан. Мөн шашны нэр томъёонд хамаарах олон зүйл байгаа, эртний Хятад хүмүүсийн бясалгалыг ойлгодог хэллэг бас бий. Ийм байдлаар би энэ Дафа-г хамгийн нийтлэг, хамгийн түгээмэл хэлээр, хамгийн энгийнээр, хамгийн ойлгоход хялбар хэлээр заасан. Боловсролтой болон боловсролгүй хүмүүс бүгд ойлгож, мөн бясалгаж чадна, үүнд агуулагдах зарчмууд нь маш гүн гүнзгий юм.

Та бүхэн бясалгал гэж мэддэг болсон. Хэрвээ би хүмүүсийг чийгон-оор эрүүл чийрэг байлгахын тулд л заасан бол, чийгон-оор хэрхэн амьсгалаа зөв зохицуулах, сэтгэл санаагаа хэрхэн тайвшруулахыг л заахад болох байсан, эдгээр аргуудаар өвчнийг арилгах, биеэ сайжруулах зорилгод хүрч болно. Хэрэв хүн илүү өндөр түвшинд бясалгана гэвэл, эдгээр зүйлс нь юу ч биш

болно, яагаад гэвэл эдгээр нь хүмүүсийн бясалгалыг дээд түвшинд удирдан чиглүүлж чадахгүй. Яг л сургуульд явахтай адил юм. Хэрэв та нар коллежид элсэхийг хүсвэл бага сургууль, дунд сургууль, ахлах сургуулийн суурь мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай. Та нар бага дунд сургуульд суралцахын тулд бага, дунд сургуулийн сурах бичгийг ашигладаг; ахлах ангийн сургуульд явахдаа ахлах ангийн сургуулийн сурах бичгийг ашигладаг; тэгээд эцэст нь коллежид орохдоо коллежийн сургалтын хөтөлбөр дагуу сурдаг. Хэрэв чи коллежид бага ангийн сурах бичгийг ашигласан бол бага сургуулийн сурагч хэвээрээ л байна. Яагаад гэвэл чи коллежийн зүйлийг олж авч чадахгүй, үүнтэй адил дээд түвшний Фа-г сурахгүй бол дээшээ бясалгаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, чамайг дээд түвшин рүү бясалгахад удирдан чиглүүлэх, чамайг бясалгахад удирдах дээд түвшний зарчмууд байх шаардлагатай гэсэн үг юм.

Жуань Фалунь ийм гүн гүнзгий утгыг агуулдаг боловч энэ нь номын өнгөн дээрээс харагддаггүй. Гагцхүү чамайг дээшилсний дараа нэг өгүүлбэрийг дахин уншихад, өмнөхөөсөө өөр утгатай болохыг олж мэдэх болно, энэ нь өөр утгатай болчихдог, лавтай ийм байна. Өөр ямар ч ном ийм байж чадахгүй, яагаад гэвэл тэдгээр нь бясалгалын ном биш, энгийн хүний онолын хүрээнд л байдаг. Гэвч энэ Фа энгийн хүний онолоос бүрэн давж гардаг тул түүний дотоод утга нь нэлээдгүй агуу, энэ бол бясалгал юм. Буддын системээр ярьдаг, "энгийн хүний энэ алхмаас эхэлж бясалгах" гэдгийг би "Гурамсан ертөнцийн Фа бясалгал" гэж нэрлэдэг, өөрөөр хэлбэл хүний биеийн бясалгал гэж нэрлэдэг. Энэ хугацаанд хүн маш олон талын сайжралтыг хийж дуусгах хэрэгтэй. Хүний биеийн бясалгалын тухай урьд нь бясалгалын номуудад нэлээд их бичигдсэн байдаг, хэдийгээр тэр нь маш тодорхой бус байсан ч, тэдгээр бичсэн нь бүгд энэ талын зүйлс л юм.

Энэ ном чамайг зөвхөн Гурамсан Ертөнцийн Фа бясалгалд удирдана гэвэл, чи Гурамсан ертөнцөөс цааш бясалгаж чадахгүй, тэгвэл энэ ном заавал хүний биеийн бясалгал болон Гурамсан ертөнцийн түвшин болгоны бясалгалын зарчмуудыг, мөн Гурамсан ертөнцөөс давсан зарчмуудыг агуулсан байх ёстой. Бясалгадаг хүн зөвхөн тухайн түвшин болгоны зарчмуудын удирдамжаар тэр түвшинд бясалгаж хүрч чадна, тэгвэл бас заавал бүр өндөр түвшний зарчмууд чамайг удирдсанаар чи тэр түвшинд бясалгаж хүрнэ. Өөрөөр хэлбэл, чи Гурамсан ертөнцөөс гарч бясалгана гэвэл, заавал Гурамсан ертөнцөөс гарсан зарчим байх ёстой. Энэ нь миний сургуульд явах тухай ярьсантай адил юм. Хэрэв энэ нь тийм өргөн уудам дотоод утга агуулаагүй байсан бол чи огт бясалгаж чадахгүй, ийм л утгатай юм. Яагаад гэвэл өнөөдрийн миний заан тарааж буй Фа бусад чийгон багш нарын заадгаас бүхэлдээ өөр юм, тэдгээр чийгон багш нар хүмүүст зөвхөн өвчнийг арилгах, бие сайжруулах зүйлсийг л заадаг. Энд би бусад чийгон багш нарын түвшин өндөр биш, сайн биш гэж байгаа юм биш, ийм утгатай биш юм, хэн ч ийм зүйл хийгээгүй гэж л хэлж байгаа юм. Гэхдээ одоо зөвхөн би хийж байгаа гэж л мэднэ, та нар номыг

уншсан, маш олон хүн миний юу хийж байгааг ойлгосон. Хятадад ч бай, бүх дэлхийд ч бай, үүнийг хийдэг хүн байхгүй, яагаад гэвэл энэ бол жижиг асуудал биш юм. Энэ нь хүнийг дээд түвшин рүү дагуулдаг, нэгэнт хийж эхэлсэн л бол, асар том асуудлуудыг дагуулдаг.

Ариун Фа-г заан түгээхэд маш хэцүү байдаг. Та бүхэн мэднэ, Есүс тухайн үедээ ариун Фа-г түгээснийхээ төлөө цовдлогдсон, Шагжамүни ч бас нирвааны замыг сонгохоос өөр арга байгаагүй. Энгийн нийгэмд маш олон төрөлхийн мэт салшгүй үзэл бодлууд, хүн төрөлхтний янз бүрийн нөлөөллийн хүч, шашны нөлөөллийн хүчнүүд байдаг, түүнчлэн маш олон хүчин зүйлс өөрсдийн хүрээлэн буй орчныг бий болгосон. Эдгээр хүчин зүйлс нь эерэг, сөрөг талыг агуулдаг бөгөөд сөрөг тал нь муу хүчин юм. Хүн төрөлхтний нийгэмд аливаа эерэг зүйл болгонд сөрөг зүйл агуулагддаг, сөрөг зүйл нь хүнд хор хөнөөл учруулах, хүнийг дарах, хүн рүү дайрах, улс төрийн эрх мэдлийг ашиглаж янз бүрийн арга хэрэгслээр хүнийг дарангуйлдаг. Тиймээс ариун Фа-г заан түгээх нь хамгийн хэцүү байдаг. Муу хүн буруу номыг тараахад, хэн ч тэдэнд саад болдоггүй.

Буддын нүдэнд хамаг амь бодь зовж байгаа нь харагддаг. Есүс зөвхөн найз нөхдөө төдийгүй дайснуудаа ч бас хайрлах хэрэгтэй гэж хэлсэн. Яагаад гэвэл тэд бүх амь бодид энэрэнгүй ханддаг байсан тул, дэлхийн хүмүүсийг аврахыг хичээсэн. Тэгвэл нэг бясалгадаг хүний хувьд, хувь хүний бясалгалын явцад, нэгэн цагт энгийн хүний дунд чиний эсрэг байсан хүнийг хайрлаж чадахгүй бол чи Будда болж чадахгүй. Энэ бол үнэхээр үнэн, яагаад гэвэл бясалгагчид энэрэнгүй байх хэрэгтэй. Энэрэнгүй байна гэдэг нь энгийн хүний дундах бүх гомдол хорслыг орхих, энгийн хүний бүх зүйлд зууралдахгүй байх, энгийн хүний нэр, ашгийг эрэлхийлэхгүй байх, хүний сэтгэлийг орхихыг хэлнэ. Бясалгалын явцад энгийн хүний бүх зүйлд хөнгөн ханд, тэгж байж л та нар түүнээс өөрийгөө чөлөөлж чадна гэсэн үг.

Мэдээж энд яригдаж буй шаардлага арай өндөр байж магадгүй юм, яагаад гэвэл миний заадаг зүйлс энгийн хүмүүсийн дунд байдаг энгийн чийгон биш, энэ бол жинхэнэ бясалгал юм, гэхдээ үүнийг чийгоноос салгаж болохгүй. Яагаад вэ? Яагаад гэвэл чийгон-ы дээд түвшин бол бясалгал юм, энэ бол гарцаагүй, гэхдээ нийгэмд тарсан тэдгээр чийгон бясалгалууд бүгд бясалгалын хамгийн доод түвшнийх бөгөөд эрүүл биетэй болох, өвчнөөс ангижрах зорилгоос өөр дээд зүйл байхгүй. Яагаад гэвэл үүнийг хийхэд маш хэцүү, маш хэцүү... хэн нэгэн сэтгэлийн хөөрлөөр гарч ирээд хийчихдэг зүйл биш.

Би та бүгдэд үүнийг маш хэцүү гэж хэлдэг нь, надад үүнийг түгээхэд хэцүү байсан, та нарт ч үүнийг олоход маш хэцүү байсан. Энд сууж байгаа та нарын ихэнх нь хувь тавилангийн барилдлагатай, магадгүй том хувь тавилан байж болох юм. Зарим хүн “энэ бүхэнд ямар ч онцгой зүйл алга, би энэ номтой

зүгээр л учирсан, би энэ Фа-г зүгээр л олж мэдсэн, энэ бясалгалаар хичээллэдэг хүнийг санамсаргүй байдлаар олж мэдсэн, эсвэл манай найз надад үүнийг хэлсний дараа би зүгээр л сурч эхэлсэн” гэж бодож магадгүй юм. Яагаад гэвэл энэхүү энгийн хүний нийгэм төөрөгдлийн дунд байдаг, гэнэт нэг бурхан нисэж ирээд чамайг энэ Фа-г сур гэж хэлэх боломжгүй. Ийм байдаггүй, хэрэв тэгвэл энгийн хүний нийгмийн энэ төөрөгдлийг эвдэнэ гэсэн үг. Энэ төөрөгдлийг эвдчихвэл, ухамсарлалт гэж байхгүй болно, бясалгахад ч амаргүй болно. Тийм учраас хүмүүстэй тааралдсан зүйлсийн ихэнх нь санамсаргүй мэт санагддаг ч үнэндээ санамсаргүй байх албагүй.

Би Хятадад сурагч нартайгаа ярилцаж байхдаа, олон хүн үүнийг мэдэхгүй байгаа гэж хэлсэн. Чи зүгээр л энэ ангид хичээл сонсох гэж ирсэн гэж бодож байна, гэхдээ чи энэ Фа-г олж авахын тулд урьдны хэд хэдэн төрөл, тэр битгий хэл хэд хэдэн төрөл, хэдэн арван төрөлдөө бүгдэд нь зовлон амсаж ирсэн (алга ташилт). Гагцхүү чи үүнийг мэдэхгүй. Зарим хүн энэ Фа-г олж авахын тулд амиа алдаж байсан. Бясалгалын явцад би та нарын сайн сайхны төлөө цөхрөлтгүйгээр зааж, дагуулж байна, учир нь би та нарыг түүхэнд хэн байсныг мэднэ, өнөөдөр үүнийг олж авахын тулд ямар их зүйлээ золиосолсон гэдгийг чинь ч бас би мэднэ. Би ингэж заахгүй бол, чиний урмыг хугалах болно.

Мэдээж, миний хэлсэн зүйл сонсоход жаахан ойлгогдохгүй, гүн гүнзгий байж болох юм. Үнэндээ, энэ дэлхийд амьдарч буй хүн зөвхөн хүний гадаргуйн энэ өчүүхэн орон зайн энэ хэдхэн арван жилд болдог зүйлсийг л мэдэж чаддаг. Гэвч хүний амь хүний үхлээр дуусдаггүй. Тэр там руу очсон ч гэсэн, тэр ч байтугай доошоо Тамын арван найм дахь түвшинд очсон ч гэсэн, энэ нь төгсгөл биш юм. Том нүгэл үйлдсэн амь бодь бүр доошоо унаж, устгагдана, үгүй болно. Хүн хорвоог орхиход, зөвхөн молекулын давхаргаас тогтсон бие махбод л хаягддаг, харин жинхэнэ амь нь хүнийг үхэхэд тэр агшин зуурт биенээс салан гардаг. Хүн үхэхээсээ өмнө их айдаг бололтой байдаг, үнэндээ айх зүйл байхгүй гэдгийг би та бүхэнд хэлье. Хүнд бодол байгаа цагт, айдсыг мэдэрдэг, хүний тархи махан эсүүдээс бүрддэг, ажиллахаа больсон даруйд тэр хүн өөрийгөө шинээр төрсөн мэт, чөлөөлөгдсөн мэт мэдрэмж төрдөг – нэг төрлийн сэтгэл хөөрлийн мэдрэмж байдаг. Түүгээр ч зогсохгүй бие нь хөнгөн, махан биений ямарч хүлээс байхгүй, мөн бодол сэтгэхүй нь бүрэн нээгддэг. Хүний амьдралдаа хийсэн бүх зүйл нь хэдхэн минутын өмнө хийгдсэн мэт тов тодорхой харагддаг, аливаа жижиг зүйл бүр мартагдаагүй байдаг, яагаад гэвэл тухайн аминий бодол сэтгэхүй нь чөлөөлөгддөг. Тэр үед хүн өөрийгөө жинхэнэ хэн бэ гэдгийг мэдэж, амьдралдаа хийсэн зүйлс нь сайн эсвэл муу байсныг тов тодорхой мэдэх болно. Яг л унтаад сэрсэн хүн шиг байдаг.

Мэдээж миний ярьсныг чи хэзээ ч сонсож байгаагүй байх, гэхдээ үнэндээ ийм л байдаг. Би энэ тал дээр маш их мэддэг, бас маш их ажиглаж байсан. Ялангуяа, заримдаа би эмнэлэгт эмч нар өвчтөнийг аврахыг хичээж байхыг

харж байх үед, өвчтөн аль хэдийн нас барсан байсан ч хүмүүс түүнийг аврах гэж оролдсоор байсан. Тэр хүний Эзэн сүнс нь аль хэдийн биеэсээ гараад явсан байсан. Яагаад гэвэл хоёр цаг хугацааны орон зайн ухагдахуун адилгүй байдаг—цаг хугацааны хурдан, удаан нь өөр байдаг, тэр орон зайн бүтэц нь хүний энэ орон зайнаас өөр байдаг, хүний биеэс нэгэнт ангижрах агшинд нэг насны амьдралдаа хийсэн бүхэн нь саяхан болсон юм шиг санагдах болно. Дөнгөж дуг хийгээд сэрсэн мэт санагдах болно. Будда хүнийг бас ийм байдлаар хардаг. Хүн төөрөгдлийн дунд сэргэг бус байдаг, хүний амь богинохон болоод түр зуурынх юм.

Би та бүхэнд энэ Фа-г зааж өглөө, ямар ч байсан та нар үүнийг олж авах хувь тавилантай байсан юм. Миний бодлоор та нар үүнийг олж авсан болохоор ажлынхаа дараа чөлөөт цагаа ашиглан номоо уншиж болно. Та бүгд илүү ихээр уншаад үзээрэй, миний хэлсэн шиг байх эсэхийг үзэж болно. Хэрэв тийм биш бол та нар үүнийг сурахаа больж болно, хэрэв чи үүнийг надаар илүү их зүйл хэлүүлэлгүйгээр чин сэтгэлээсээ уншвал, чи үүнийг орхихгүй, учир нь чи үүнээс бүр дээд үнэнийг олж харсан, чи уншаад л байх болно. Энэ нь энгийн хүний мэдлэгээс давж гардаг. Хүн болгонд Буддын мөн чанар байдаг, чи үүнийг уншаад л байвал гарнаасаа тавихгүй дурлан уншина, дахин орхихыг хүсэхгүй.

Би энэ Фа-г заахдаа эх газрын Хятадад байдаг хүмүүсийн сэтгэлгээнд үндэслэн заасан байж болох юм, энэ номыг мөн адил байдлаар эмхэтгэсэн. Хэдийгээр америкчууд болон дэлхийн бусад орны хүмүүсийн сэтгэлгээний хэв маяг, асуудлыг харах арга нь ялгаатай ч, мөн бичсэн зүйл дэхь сэтгэлгээний гадаргуйн бүтэц, ойлгох хэр хэмжээ нь өөр өөр байдаг ч, бясалгалын явцад Фа зарчмуудын дотоод утга нь адилхан байдаг. Аль ч бүс нутаг, аль ч улс орон, аль ч үндэстэн ястны хүмүүс үүнийг сурах боломжтой тул чи үүнийг унших л юм бол бүгд адилхан байна. Та нар сурах явцдаа эдгээр зүйл дээр бүү анхаар, би та нарыг хүлээн авч чадна гэж бодож байна, яагаад гэвэл үүнийг ганц хоёр өдрийн дотор бэлдчихдэг зүйл биш, түүхэнд маш эрт дээр үеэс аль хэдийнээс үүнийг хийхэд бэлдэж ирсэн.

Та бүхэн аль хэдийнээс мэддэг болсон, энгийн хүний нийгэмд ямар нэгэн зүйл тохиолдох бүрт санамсаргүй зүйл гэж байдаггүй, тэр бүхэн тэнгэрийн өөрчлөлтөөс үүдэлтэй байдаг. Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд, хэрэв ийм зохицуулалт хийгдээгүй байсан бол, энэ зүйл түүхэнд огт гарахгүй байх байсан. Та бүхэн тоо томшгүй олон дээд түвшний амь бодиуд байдаг гэдгийг мэднэ. Буддын системд Будда нар хаа сайгүй байдаг гэж ярьдаг, энэ тоо нь гайхамшигтай их. Түүгээр ч барахгүй хэлбэр дүрстэй бурхад, хэлбэр дүрсгүй бурхад байдаг, тэд орчлон ертөнц даяар байдаг. Энгийн хүний нийгэмд байдаг маш олон тооны бичил хэмжээний бие бодиуд мөн багтдаг, хүмүүс тэдгээрийг микроэлемент гэж нэрлэдэг ч бай, эсвэл агаар дахь янз бүрийн элементүүд гэж нэрлэдэг ч бай, энэ бол хүмүүсийн мэдэж чадсан л зүйлс юм. Мөн



хүмүүсийн ойлгож чадахгүй бүр бичил хэмжээний, бүр ч илүү бичил хэмжээний бие бодиуд байдаг. Өргөн уудам орчлон ертөнцөд нэвчсэн бие бодиуд бүгд Буддын мөн чанартай дээд түвшний амь бодиуд юм, тэд бүгд хүнийг ширтэж, хүнийг харж, хүнийг ажиглаж байдаг. Тийм ч учраас хүн төрөлхтний нийгэмд санамсаргүй зүйл гэж байдаггүй.

Энэхүү Дафа олон нийтэд тарж гарахад тэнгэр, газрыг доргиосон. Одоогийн байдлаар энгийн хүний нийгэмд ингэж харагдахгүй байгаа ч бусад орон зайнуудад ийм байдаг. Түүхэнд хэн ч орчлон ертөнцийн жинхэнэ зарчмуудыг хүмүүст зааж байгаагүй—хэзээ ч байгаагүй. Та бүхэн Лаози, Шагжамүни, Есүс гэх мэт хүмүүсийг мэднэ, тэд зөвхөн энэ орчлон ертөнцийн Фа зарчмуудаас өөрсдийн танин мэдсэн, өөрсдийн ухамсарлаж гэгээрсэн хэсгээ л заасан. Тэд зөвхөн танин мэдсэн зүйлээ л заасан. Гэвч орчлон ертөнцийн Фа нь хязгааргүй юм. Татагата / Рулайг давсан Будда нар тоо томшгүй олон байдаг ба тэдний таньж мэдсэн Фа нь бас маш агуу юм. Мөн Буддын түвшнээс маш хол давсан хэлбэр дүрсгүй асар том амь бодиуд байдаг, тэд бүгд Буддын мөн чанартай байдаг. Орчлон ертөнц нь хүн төрөлхтний шашинд танин мэдсэн шиг тийм өчүүхэн зүйл биш. Хүн төрөлхтний танин мэдэхүй нь энэ хүний нийгмээр хязгаарлагддаг. Хүмүүс шашны танин мэдсэнийг маш агуу гэж үздэг ч дээд бурхдын нүдэнд энэ нь маш өчүүхэн зүйл байдаг.

Миний ярьсан зарчмууд бүр ч том байж магадгүй юм, мөн би үүнийг хүнд заасан, энэ бол үнэхээр түүхэн дэх анхны тохиолдол юм. Миний хийсэн зүйл бол, хүний дүр төрхөөр, хүний хэлээр, хамгийн доод бясалгалын хэлбэрээр, би ийм нэг хамгийн аугаа зүйлийг хийж байна. Одоогоор хэл болон орчны ялгаатай байдлаас шалтгаалан, АНУ болон бусад газруудад Дафа сурч байгаа хүмүүс эх газрын Хятадтай харьцуулахад тийм ч их биш байна. Эх газрын Хятадад сурч байгаа хүмүүсийн ихэнх нь жинхэнэ бясалгаж байна; 10 сая гаруй хүн өдөр бүр дасгал хийж, бясалгаж байна; үүнийг алдаг оног хийж байгаа хүмүүсийг тооцвол энэ тоо хэдэн арван саяд хүрнэ; Хятадад миний зааж байгаа энэ бясалгалын талаар мэддэг хүний тоо хэдэн зуун саяар тоологдох бөгөөд үүнийг дурдахад л бүгд мэддэг бололтой байдаг. Гэхдээ би энэ бясалгалыг улс төржүүлэх дургүй, улс төрд хутгалдуулах ч үгүй. Бясалгалын зүйлс улс төрд орчихвол буруу ном болдог. Бид үүнийг зүгээр л ард түмний дунд түгээнэ. Бид албан ёсны сонин гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаагүй, сурталчилгааны ажил ч хийгээгүй. Бясалгаж байгаа хүмүүс өөрсдийн биеэр сайн гэдгийг нь мэдрээд, бусдыг ирж сурахыг урьдаг. Нэг хүн үүнийг сайн гэж мэдэрвэл, гэрийнхнийгээ бас сурахыг уриалдаг. Та бүгд мэднэ, хэрэв өөрөө нэг их ойшоож үзээгүй бол, гэрийнхнийгээ сур гэхгүй. Гэрийнхнийх нь сайн гэж үзвэл хамаатан садан, найз нөхдөө ирж сурахыг уриална. Ингэж л хүмүүсийн дунд тархдаг. Би ч гэсэн хамгийн доод түвшнээс эхэлж ярьсан, аажмаар дээд түвшин лүү ахиулсан, ингэж яриад хоёр жил болж байна. Эцэст нь би Агуу Хуулийг (Дафа) жинхэнэ заахын тухайд

дахиад хоёр жилийг авсан. Ингээд нийтдээ дөрвөн жил болсон байна, Хятадад одоо бараг айл өрх бүр энэ тухай мэддэг болсон. Энэ нь гадаадад ч нэлээд нөлөө үзүүлсэн, учир нь хүмүүс хараахан хичээллэж амжаагүй байгаа ч олон хүн энэ талаар сонссон. Зүүн өмнөд Азид үзүүлсэн нөлөө нь АНУ-ынхаас илүү байж магадгүй юм, олон улс орнууд сургалтын төвүүд, Фалунь Дафа Буддын Фа Холбоо, Фалунь Дафа Нийгэмлэгийг байгуулсан. Бид хурдацтай өсөх хандлагыг харж байна.

Энд би та нарт нэг зүйлийг хэлмээр байна. Шагжамүнигийн хэлснээр яг одоо бол Дарма-гийн төгсгөлийн үе, өөрөөр хэлбэл Дарма үйлчлэхээ больсон үе юм. Шагжамүни Дарма-гийн төгсгөлийн эрин үед түүний Дарма хүмүүсийг аварч чадахгүй гэж хэлсэн. Мэдээж, олон лам хувраг хэрхэн бясалгаа мэддэггүй болсон тул бясалгаад амжилтанд хүрч чадахгүй; тэд судруудыг ойлгохоо больсон, судруудын жинхэнэ утгыг ойлгохоо больсон. Тиймээс бясалгахад маш хэцүү болсон. Өнөөдөр олон хүн [Дафа]-г сурч байна. Хүн төрөлхтний нийгэмд гарч байгаа аливаа үзэгдэл санамсаргүй зүйл биш гэдгийг би та нарт хэлье. Маш олон хүн үүнийг сурахаар ирж байна. Ийм тэнгэрийн үзэгдэл байхгүй байсан бол, ийм байдал гарахгүй, тийм үү? Үүнд гарцаагүй шалтгаан байдаг гэдгийг би та бүхэнд хэлье.

Хүн төрөлхтөнд харилцан үүсэх, харилцан харшлах гэдэг зарчим үйлчилдэг; зөв сайн зүйл гарч ирэхэд, муу зүйл ч гарч ирэх нь гарцаагүй. Нөгөө талаас нь яривал, өнөөгийн нийгэмд янз бүрийн буруу шашин, маш их хэмжээний хуурамч чийгон бясалгалууд олширч байна, өнгөц харахад эдгээр зүйлийг хийдэг хүмүүс мөнгө, алдар нэрийн төлөө хийдэг ч, үнэн хэрэгтээ ихэнх нь нийгэмд эмх замбараагүй байдлыг авчрахын тулд хорон муу чөтгөрүүдийн хойд дүрүүд байж болох юм. Шагжамүни Дарма-г түгээж байхдаа хүн төрөлхтний нийгэмд “таван муу” байгааг харсан гэж хэлсэн. Үнэн хэрэгтээ өнөөгийн нийгэм тэр үеийг бодвол хамаагүй ээдрээтэй юм, энэ нийгэмд “арван муу” дүүрсэн бөгөөд буруу шашин бас маш ихээр олширсон.

Би энд та бүгдэд хэлье, бид огт шашны зүйлсийг хийхгүй. Хэрэв чи ирж, манай бясалгалд суралцахыг хүсвэл ирж болно, хэрэв чи үүнийг сурахыг хүсэхгүй бол больж болно—энэ бүгд сайн дурын хэрэг. Жишээлбэл, бид чамайг сурахыг албадаж, чамд тулгаж, чамайг сургасан гэж бодъё; тэгээд нэгэнт сурч эхэлсэн болохоор чамайг явуулахгүй, энд үлдэх ёстой болсон гэж бодъё. Та бүгд мэднэ, ийм байвал хорон муу зүйл хийж байна гэсэн үг. Харин ариун Фа бол, тухайн хүн өөрөө үүнийг чин сэтгэлээсээ сурах хүсэлтэй байх ёстой. Хэрэв хүнийг хүчээр бясалгуулна гэвэл, тэр бясалгаж чадах уу? Тэр жинхэнэ бясалгахгүй нь лавтай. Гагцхүү хүн чин сэтгэлээсээ хүсэх үед л бясалгана. Тиймээс хүнийг хүчээр үлдээх нь огт утгагүй зүйл юм. Бид ингэдэггүй. Чи сурахыг хүсвэл, сур. Чи сурвал, би чиний өмнөөс хариуцлага хүлээнэ. Хувь тавилан чинь хичнээн том байсан ч хамаагүй, хэрэв чи үүнийг сурахыг хүсэж байвал би чиний өмнөөс хариуцлага хүлээх болно. Хэрэв чи

үүнийг сурахыг хүсэхгүй байвал, явж хүссэн бүхнээ баяртайгаар хийхэд чөлөөтэй.

Миний энэхүү Фа-г түгээх зорилго нь та бүгдэд эдгээр гайхалтай зүйлс болон сайн мэдээг өгөх явдал юм. Та нарын олонхи нь үнэхээр хувь тавилантай, энэ Фа-г олж авах ёстой; та нар энэ Фа-г бас олж авахыг хүлээсээр ирсэн. Хүн төрөлхтөн энэ маш эмх замбараагүй цаг үед ирснээр бүхэл нийгмийн ёс суртахуун доройтож байна. Их гамшиг болно гэж олон хүн ярьдаг. Би та бүгдэд хэлж өгч болно, одоогийн тэдний ярьж байгаа шиг тэр их гамшиг болохгүй, гэхдээ хүн төрөлхтний хувьд ингэж доройтож байгаа нь маш их аюултай. Яагаад аюултай вэ? Та бүгд бодоод үз дээ: өнөөгийн нийгэмд хүмүүс ямар болсон байна? Янз бүрийн доройтсон муухай үзэгдлүүд зүгээр л маш олон болсон байна, тоо томшгүй олон болсон. Хүнийг... яагаад хүн гэж нэрлэдэг вэ? Яагаад гэвэл хүмүүс дэлхий дээр амьдрах л юм бол хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ, хэв шинж дагуу амьдрах ёстой, тэгвэл л чи хүн юм. Эс бөгөөс хүн гэж нэрлэж болохгүй. Толгойтой, дөрвөн мөчтэй л бол хүн болчихдог юм биш. Сармагчин ч гэсэн дөрвөн мөчтэй биз дээ, бусад орон зайнуудад хүнтэй төстэй амь бодиуд бас маш олон байдаг, тэднийг хүн гэж нэрлэж болохгүй. Яагаад гэвэл хүнд хүний зан төлөв, ёс суртахууны хэм хэмжээ байдаг, хүний ёс суртахууны дүрэм байдаг, тэгээд хүн болдог. Хэрэв хүн ёс суртахууны дүрэм, ёс суртахууны хэм хэмжээгээ алдвал, амьтантай адил болно, тэгвэл тэнгэр хүнийг хүн гэж үзэхгүй, харин адгуус гэж үзэх болно. Тэр үе ирэхэд хүн төрөлхтөн аймшигтай байдалтай тулгарах болно.

Яагаад аймшигтай гэж? Та бүгд бодоод үз дээ: энэ бол хүн төрөлхтний орон зай, бурхад дэлхийг адгуусны төлөө биш харин хүний төлөө тусгайлан бүтээсэн. Хэрэв тийм бол, маш олон муу хүн одоо замбараагүй юу ч хийж зүрхэлж байгааг нь битгий хар, тэд бүрмөсөн устгагдах аюулд орох бүрэн магадлалтай. Сайхан сэтгэлтэй олон хүн, олон сайн хүн бас дагаж доошоо унаж байна. Одоогийн байдлаар хүн бясалгахгүй байсан ч, би хүнд энэ зарчмыг хэлэхэд хүн сэрэх болно, хүн төрөлхтөн ямар болсныг ухаарна, үүний үр дүнд тэрээр аймшигтай үр дагаварт хүрэхгүйн тулд цааш унахгүй болно.

Би нэг яривал мөд дуусдаггүй, та нарт эдгээр зарчмыг бүгдийг нь хэлж өгөхийг хүсдэг. Би нэгэнт Хьюстон руу уулзалт хийхээр явж байгаа болохоор энэ боломжийг ашиглаад замдаа та нартай уулзаж товчхон ярилцахыг хүслээ, (алга ташилт) энэ Фа-г үнэхээр нандин гэдгийг дахин хэлмээр байна. Би ямар ч хариу харалгүй та нарт зааж байна. Энэ бол хүн хэдэн зуун, бүр хэдэн мянган жилийн турш мэдэхийг хүссэн ч, хэн ч тэдэнд заагаагүй үнэлж баршгүй жинхэнэ Фа юм. Хүн, үнэ цэнэт зүйлийн эрэлд яваад өчүүхэн төдийг ч гэсэн олбол, ганц өгүүлбэр ч олж авсан бол түүнийгээ хамгийн ихээр нандигнадаг нь хүний зан юм. Та нар үүнийг насан туршдаа мартахагүй. Хэрэв бүр нандин зүйл ирвэл, тэр ч байтугай би чамд бүхэлд нь даатган өгвөл, чамд

энэ нь амархан олдсон мэт санагдах тул зарим хүн үүнийг нандигнахгүй байж магадгүй юм. Хүн амархан олдсон зүйлээ нандигнахгүй байх хандлагатай байдаг. Гэвч, би та бүхэнд хэлье, өөр арга байхгүй. Би хүн бүрийг намайг хаа сайгүй хайж явахыг нь хүсэхгүй байна. Би зөвхөн та нарт энэ бүгдийг л өгч чадна, та бүгдэд мэдүүлж, бүр их хүнд мэдүүлж, энэ хувь тавиланг дахин холбоно, зөвхөн ингэж л хийж болно, үүнийг нандигнах эсэх нь та нарын хувийн хэрэг, та нар хувь тавилантай болохоор тэр юм. Хүн дүн шинжилгээ хийх чадвартай байдаг, чи эдгээр зарчмуудыг сайн эсэхийг дүгнэж болно. Буддын мөн чанар хүн болгонд байдаг гэж би боддог, чи өөрөө л ухамсарла. (Алга ташилт)

Та нарын зарим нь маш хол зам туулж ирсэн бололтой, хэн ч явахыг хүсэхгүй байна.

*Сурагч: Багш аа, бид зураг авч болох уу?*

Багш: Зураг авч олно.

*Сурагч: Бид асуулт асууж болох уу?*

Багш: За ингэж хийцгээе. Бид хэтэрхий удаж болохгүй, би та бүгдэд дахиад хагас цаг өгье. Би та нарын зарим асуултанд хариулья. Гэхдээ би та бүгдэд нэг шаардлага тавья: нийтэд хамааралтай, эсвэл үнэхээр эргэлзээтэй асуудал байгаа бол асууж болно. Ном уншаад хариултыг нь олж болох асуулт битгий асуугаарай. Яагаад гэвэл энд ийм олон хүн байна, хүн бүрийн асуултад хариулбал хоёр цаг ч багадана. Ойлгомжтой юу?

*Сурагч: Би нэг асуулт асууж болох уу?*

Багш: Болно, болно.

*Сурагч: Би Багшийн бүх номыг уншсан, бас Фа сурч байгаа. Би бас олон найз нөхөд, хамаатан садандаа хэлсэн. Тэдэнд эргэлзээтэй байгаа зүйл бол тэдний ихэнх нь Буддын шашин шүтдэг. Мэдээж бас, зарим найзуудаас маань Христэд итгэгчид олон байдаг. Хэрэв тэд одоо Фалунь Гон-ыг сурч эхэлбэл, зарим нь өмнөх шигээ судар уншиж, эсвэл сүмд явж байж болох болов уу гэдэгт санаа зовж байна.*

Багш: За, би тайлбарлая. Чиний асууж байгаа зүйл бол өөр шашинтай хүмүүс Фалунь Гоныг сурч чадах эсэх, үймүүлэл байгаа эсэхэд байна. Би эдгээр зүйлсийн талаар аль хэдийнэ номондоо тайлбарласан, би дахиад энэ талаар ярья.

Буддад бясалгах гэдэг нь энгийн хүмүүсийн ойлгодог шиг ямар нэг төрлийн мэдлэг биш. Буддад бясалгана гэдэг нь маш нарийн асуудал юм. Дэлхий дээр үүн шиг нарийн, гайхалтай зүйл гэж байдаггүй. Бясалгал нь янз бүрийн

системд хуваагддаг, Буддын шашинд бас хоёргүй номын үүд гэж ярьдаг. Буддын шашин Дарма-гийн төгсгөлийн үед хүрэхэд, бясалгахад хэцүү гэж би сая хэлсэн. Яагаад бясалгахад хэцүү гэж байгаа вэ? Энэ үед хүмүүс судрын дотоод утгыг ойлгож чадахгүй болсон. Ялангуяа, орчин үеийн буддын сургаалийн толь бичгүүдийн тайлбарууд нь Шагжамүнигийн тухайн үеийн ярьсан утгатай бүгд адилгүй болсон явдал юм. Тухайлбал, Будда Шагжамүнигийн заасан хоёргүй номын үүд гэсэн зарчим нь хүн бясалгах явцдаа бясалгалыг хооронд нь хольж болохгүй, хоёр ба түүнээс дээш зүйлийг нэгэн зэрэг бясалгаж болохгүй гэсэн үг юм. Жишээлбэл, чи Зэн буддизмыг сурч байна гэж бодъё. Тэгвэл чи Ариун орны номыг сурч болохгүй. Хэрэв чи Ариун орны номыг сурч байгаа бол Тианьтай, Хуаяань буддизмыг сурч болохгүй. Хэрэв чи Хуаяань сурч байгаа бол Тианьтай, Зэн буддизм эсвэл Тантризмыг сурч болохгүй.

Яагаад тэр вэ? Орчин үеийн хүмүүс үүнийг ойлгохгүй, Будда л бол тэд мөргөдөг, Будда л бол түүнийг ямар бясалгалынх байхаас үл хамааран бүгдийг нь шүтдэг. Өнөөгийн лам хувраг нар бясалгаад үр дүнд хүрч чадахгүй байгаагийн хамгийн гол шалтгаануудын нэг энэ юм. Үнэндээ, Будда бүр өөрийн тэнгэрийн орноо удирддаг, тэнгэрийн орон бүр нэг Рулайтай байдаг. Жишээлбэл, Оточ Манал Будда Лиули диваажинг удирддаг; Хуаяань Диваажин нь Хуаяань Рулай байдаг; Бадамлянхуа диваажинд Бадамлянхуа Рулай байдаг; Сухавати диваажинд Будда Амитаба Рулай байдаг гэх мэт. Рулай Будда бүр өөрийн гэсэн цогц бясалгалын аргатай байдаг, аливаа Буддын зарчмын үндсэн суурь нь орчлон ертөнцийн Фа зарчмуудаас ухамсарлаж гарсан байдаг. Гэвч Рулай бүрийн ойлголт, бясалгалын арга нь өөр өөр байдаг. Яагаад вэ? Буддын чадвар өөр өөр байдаг учраас Будда бүр өөр өөр байдгийг та нар мэдэж байгаа байх. Энэ Будда ийм чадвартай, нөгөө Будда тийм чадвартай, гэвч тэд бүгд нэг хүрээнд байдаг ч чадварууд нь бүгд адилгүй байдаг. Та нар коллежид орохтой адил юм. Чи коллежийн оюутан, тэр ч мөн адил коллежийн оюутан. Чи шинжлэх ухаанд суралцдаг, тэр хүмүүнлэгийн чиглэлээр, өөр хүн хөдөө аж ахуйн чиглэлээр, нөгөө нь одон орон судлалаар суралцдаг. Бүгд адилгүй байдаг. Тэд бүгд коллежийн оюутнууд боловч тэдний сурсан зүйл, олж авсан мэдлэг нь өөр өөр юм. Би маш энгийн жишээгээр авч ярилаа.

Хүний хувьд... чи ямар нэгэн диваажинд очихыг хүсвэл, урьд өмнө Буддын шашинд хүсэлт тавих ёстой байдаг байсан. Жишээ нь: “Би ариун орны диваажинд очмоор байна, бясалгаад Будда Амитабагийн оронд, түүний дор орших амь бодийн нэг болмоор байна” гэж хэлэх, эсвэл бясалгаад Бодьсаттва, Архатад хүрмээр байна. Тэгээд чи хүсэлт тавьсаны дараа чи түүний системд бясалгаж, зөвхөн Амитабагийн судрыг уншиж, зөвхөн Амитабагийн нэрийг уншина. Мөн өөр ямар ч судар уншиж болохгүй. Үүнийг "хоёргүй номын бясалгалын арга" гэж нэрлэдэг. Хэрэв хүн Хуаяань диваажинд очихыг хүсвэл, чи "Хуаяань судар"-аас өөр судар уншиж болохгүй. Хүн энэ бүгдийг буддын

зарчмууд гэж үздэг, бүгд хүмүүст ашиг тустай гэж боддог, энэ бол зөвхөн хүний л бодол. Хэрэв үүнийг анхааралтай бодож үзэхгүй бол замбараагүй болно. Нэг боть судар нь хамгийн доод түвшнээс дээд түвшин хүртэл бясалгагчдад хэрэгтэй бүх зарчмуудыг агуулдаг. Эдгээрийг хольж бясалгах нь ашиг тустай гэж үздэг нь зөвхөн хүний сэтгэл юм.

Энэ хүн төрөлхтний нийгэм битүүмжлэгдчихсэн байдаг, нэгэн цагт хүмүүсийг аврах үүрэг хүлээж байсан бүх зөвт бурхад хүнийг харж хандахаа больсон. Тэд өнөөгийн хүмүүсийг хэтэрхий доройтсон гэж үздэг тул хүнийг хайхрахаа больсон, тэднийг хүсэхгүй, аврахыг ч хүсэхгүй болсон. Би сая нэг зүйлийг хэлсэн. Тухайлбал, надад энэ Фа-г түгээх нь маш хэцүү байдаг гэж хэлсэн, маш олон Бурхад болон Будда нар намайг үүнийг хийлгэхгүйг хичээсэн. Тэд өнөөгийн хүмүүсийг аврах боломжгүй, тэднийг үлдээх ёсгүй гэж үздэг. Эдгээр зүйлсийг хүн мэддэггүй, харин хүмүүс өөрсдийгөө сайхан амьдарч байна гэж үздэг. Өмнөх болон одоогийн хүмүүсийн ёс суртахууны хооронд ямар том ялгаа байдгийг хүн мэддэггүй. Тэнгэр, газар хоёрын хооронд ямар агуу ялгаа байдгийг, Бурхад болон Будда нар хүнийг хэрхэн үздэгийг, Тэнгэрт ямар цэвэр ариун байдгийг, Будда нар ямар гайхамшигтай, агуу байдгийг хүмүүс мэдэхгүй!

Хүн болон тэнгэрийн хүний хооронд асар том ялгаа байдаг. Хүний ертөнцийн тэнгэр цэлмэг харагддаг ч, хүн энэ газрын бие бодиос бүрдсэн хүний махан нүдээр хардаг болохоор тэр юм; хэрвээ хүн дээд орон зайнаас хүн төрөлхтнийг харах чадвартай байсан бол, хүн төрөлхтний нийгэм асар их үйлийн үрийн хуйларсан, хар давалгаа бүхий аймшигтай бохир болохыг олж мэднэ. Тиймээс Бурхад, Будда нарын хүний талаарх үзэл бодол нь хүмүүсийн төсөөлдөг шиг биш юм. Хүмүүсийг аврах нь Бурхад болон Будда нарын хүмүүст үзүүлж буй нигүүлсэл юм. Чи Буддаг сайн гэснээр, Будда чамайг авна гэсэн үг биш. Тэгээд ч чиний хүссэн бүхнийг Бурхад, Будда нар чамд өгөх албагүй. Үнэндээ Бурхан ч бай, Будда ч бай тэд бясалгалын хэлбэрийг төдийлөн чухалчилдаггүй. Шашин хэчнээн томорсон ч, энэ нь бясалгалтай тэнцэх зүйл биш. Би ч бас шашныг түгээж байгаа юм биш, харин хүний төлөө үүнийг хийж байгаа. Бурхад, Будда нар шашны хэлбэрийг хүлээн зөвшөөрдөггүй, зөвхөн хүнийг л хүлээн зөвшөөрдөг.

Хүмүүс үргэлж "Миний сүсэглэдэг шашин маш сайн" гэдэг. Тэр хүн Буддаг сахин хамгаалж байгаа юм шиг байдаг, эсвэл Есүс болон Эзнийг сахин хамгаалж байгаа юм шиг байдаг. Гэхдээ энэ нь тийм биш юм. Хүн шашинд улам урам зоригтой орох тусам, үүнд илүү их автдаг; мөн тэрээр хэдий их автана, тэр хэмжээгээр Бурханаас холддог. Шашин бол хүний л бий болгосон бясалгалын хэлбэр юм, тэр шашны хэлбэр нь хичнээн бүрэн, төгс байсан ч [тэр шашинд] хүн сайн бясалгасан гэсэн үг биш юм. Хүмүүс [бясалгахын оронд] эдгээр зүйлд сэтгэлээ зориулахад, Будда болон Бурхад хараад маш тааламжгүй байдаг. Будда хүний ертөнцөд та нарын авч хэрэглэсэн

бясалгалын хэлбэрийг хардаггүй. Магадгүй та нар сахил хүртсэн эсвэл баптизм хүртсэн байх, сэтгэл нь энгийн хүнээрээ байвал ямар хэрэг байна? Хүн хэвээр байвал энэ нь ямар ялгаатай гэж? Будда эдгээр зүйлсийг хардаггүй; тэд чамайг үнэхээр өөрийгөө бясалгаж байгаа эсэхийг л хардаг. Хэрэв чи сахил санваар, адис хүртээгүй, хүж ч өргөөгүй, Буддын нэрийг уншаагүй ч Бурхад болон Буддын тогтоосон жишгийг дагаж мөрдөж, бясалгалдаа чин сэтгэлээсээ, тууштай байвал тэд чамайг харахаараа баярлахгүй байж чадахгүй. Чи гуйх шаардлагагүй, тэд чамайг байнга хамгаалж, харж, бясалгахад чинь үргэлж туслах болно. Ийм зарчимтай биш гэж үү? (Алга ташилт)

Хүмүүс “Би буддын шашны номыг орхиж чадахгүй”, “Би Библийг орхиж чадахгүй” эсвэл “Би тарни уншихаа больж чадахгүй” гэж хэлдэг. Тэдний орхиж чадахгүй байгаа зүйл нь Будда биш харин шашин шүтлэг юм. Та бүгд сайн бодоод үзээрэй. Шашны сүсэгтнүүд ийм л байдаг биз дээ? Хүмүүс яагаад эдгээр зүйлсийг орхиж чаддаггүй вэ? Өөрөө өөрийнхөө зүрх сэтгэлийг гүн ухаж үзээрэй, тэр сэтгэл энэ асуудлыг яаж ойлгож байгааг ажиглаарай. Зарим зүйлийг гадаргуйн байдлаар нь битгий харж бай, өөрийгөө чин сэтгэлээсээ бясалгадаг хүмүүс Бурхад, Буддад үнэхээр итгэдэг. Будда нар ч гэсэн үүнийг ингэж хардаг; тэд шашныг хэр сайн дагаж байгааг тоодоггүй. Та бүхний мэдэж байгаагаар түүхэнд шашин шүтлэгээр яваагүй олон хүн бясалгалаар гэгээрэлд хүрсэн байдаг. Олон агуу буянтай хүмүүс шашнаар бясалгаагүй байдаг. Хүн өөртөө үргэлж хатуу шаардлага тавьж, хэрхэн сайн хүн байхыг эрмэлздэг. Тэд үүнийг тууштай, удаан хугацаанд хийж, улам сайжирч чадвал Будда нар тэдэнд анхаарал халамж тавьж, тэд Төгс төгөлдөрт хүрэх болно.

Миний ярьж буй зарчим бол эцсийн дүндээ та нарыг сайн хүн болгох, бүр илүү сайн хүн болгох, энгийн хүнээс илүү сайн хүн болгох юм. Ингэж чадвал чи энгийн хүнийг давах болно, цааш дээшилбэл бүр ч өндөр оршихуйн амь бодь болно. Ийм хүн тэнгэрийн диваажинд очихгүй бол дэлхий дээр байж чадах уу? Хүн бол хувиа хичээсэн, өрсөлдөмтгий байдаг, алдар нэр, ашиг хонжооны төлөө тэмцэлддэг. Энэ нь дэлхий дээрх хүн чамаас өөр гэсэн үг юм. Ийм л зарчимтай юм. Хэрэв чи тэдгээр [шашин шүтлэгтэй] хүмүүстэй эдгээрийн дагуу ярилцвал ямар шашин байх нь хамаагүй, бурхад нэгэнт тэднийг орхисон бол энэ нь энгийн хүмүүсийн дундах нийгмийн хэлбэр л болно, энгийн нийгэм дэх ажил алба л болдог. [Тэдний шашин шүтлэг] жинхэнэ бясалгалд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Гэхдээ энд бясалгалд нухацтай хандах асуудал бий. Нэг бясалгалдаа тууштай байвал, энэ нь жинхэнэ бясалгал юм. Хэрэв хүн [манай Дафа] сурахыг хүсэж байвал, сурч болно. Хэдийгээр [өөр шашинтай байсан ч] [Дафа-д бясалгахад] саад болохгүй ч, бясалгалын нарийн чанд асуудал байдгийг тэдэнд ойлгуулаарай. Түүнд [түүний шашин шүтлэг] асуудал биш бөгөөд түүнд номыг уншсаны дараа бүх зүйлийг ойлгох болно гэдгийг хэлээрэй. (Алга ташилт)

*Сурагч: Таны бидэнд заасан таван дасгалаас гадна таны хийдэг гарын мудра багц хөдөлгөөнийг би хардаг.*

Багш: Эхлээд би мудра гэж юу болохыг ярья. Мудра-г Буддын нэг төрлийн хэл яриа, нэг төрлийн илэрхийлэх хэлбэр гэж үзэж болно, учир нь Будда нар ямар нэг зүйл илэрхийлэхдээ ярихыг хүсэхгүй бол тэд мудра (гарын хөдөлгөөн) хийдэг. Будда нар хоорондоо бодлоороо харилцах хэлбэрийг бас ашигладаг. Та нар миний Фашэнь-ийг харсан ч бай, эсвэл зүүдэндээ Будда, Бодьсадва нарыг харсан ч бай, тэд заримдаа чамтай амаа хөдөлгөхгүй ярьдаг. Гэхдээ чи тэдний дуу хоолойг сонсоно. Энэ бол бодлоор дамжуулан харилцах явдал юм. Орчин үеийн хэллэгээр үүнийг бодлын стерео дамжуулал гэж нэрлэдэг. Олон Бодьсадва, Архад нарт Фа айлдах үед ихэвчлэн гарын мудраг хэрэглэдэг. Энэ нь хүнийх шиг дохио зангааны хэл биш юм. Энэ бол илүү нандин, ариун бөгөөд хүчирхэг юм. Энэ бол Буддын хэл тул мудра хийх үед тэд энерги, хүчийг хамт гаргадаг, Буддын илэрхийлдэг зүйл бол түүнээс дооших бүх амь бодиудад Фа юм. Гэхдээ мудра бол ярианы үгтэй адил, үгсийг янз бүрийн аргаар нэгтгэж янз бүрийн санааг илэрхийлж болно. Аливаа нэг асуудлыг өөр өөр өнцгөөс тайлбарлаж болдог, тиймээс тэр нь тогтвортой биш, стандарт гэж байдаггүй. Гэхдээ дасгал хийхэд ашигладаг тогтсон мудра байдаг; өөрөөр хэлбэл, гараа нийлүүлэн хийдэг барилт байдаг, үүнийг Дин мудра гэж нэрлэдэг. Жишээлбэл, бадамлянхуа мудра, бид дасгалаа хийхдээ ашигладаг нь Дин мудра, эдгээр бүгд бол Дин мудра юм. Хөдөлгөөн дунд хийдэг мудранууд нь тогтсон Дин мудрагаас ялгаатай.

Видео бичлэг дээрх дасгалуудыг хийж байхдаа миний хийсэн мудра бол дасгал хийхээс өмнө би та нарын мэддэг талд болон өөр орон зайн оршихуйнуудад харуулах зориулготой юм. Тиймээс та нар тэдгээрийг сурах шаардлагагүй. Та нараас хожим Будда болох хүмүүс үүнийг хэрхэн хийхийг мэдэх болно. (Алга ташилт)

*Сурагч: Ли багшаа, Та өнөөдөр бид бүгдэд Фалуень-ийг суулгаж өгнө тийм үү? (Алга ташилт)*

Багш: Би та нарт хэлье, чи гагцхүү бясалгалдаа чин сэтгэлээсээ хандвал, чи энд ирсэн ч бай, эсвэл бие даан өөрөө ном уншдаг ч бай хамаагүй, бүгд авах болно. Би бас та бүгдэд хэлмээр байна: Энэ номыг эрхэмлэн дээдэлж байгаарай. Чи одоо үүнийг ойлгохгүй байж магадгүй, энэ номонд Буддын зарчмуудыг заасан юм шүү. Бясалгалын явцын бүх түвшнийг номонд багтаасан байгаа. Үнэндээ чиний бясалгалыг удирдан чиглүүлдэг нь Буддын Фа юм. Бясалгалын чинь явцад Будда болон Бурхад чамд туслах болно. Та бүгд бодоод үз дээ: Тэнгэрийн түвшин бүрийн оршин суугчид хэн байдаг бэ? Тэд Бурхад, Будда нар биш гэж үү? Тэд бүр дээд Будда, бүр бүр дээд Будда, бүүр бүүр бүүр дээд Будда нар биш гэж үү? Тийм ч учраас би та бүгдэд хэлье, энэ номын үг бүр тоо томшгүй олон давхаргын Будда нар байдаг, хамгийн эцэст нь миний Фашэнь байдаг, мөн түүнчлэн янз бүрийн түвшинд бас



Фалунь-ий илрэл байдаг. Яагаад зарим хүнд энэ номыг аваад уншсан даруйд их таатай мэдрэмж төрдөг вэ? Тэдний үйлийн үр яагаад үүнийг уншсан даруйд арилдаг вэ? Тэгээд яагаад үүнийг уншсан даруйд өвчин нь арилдаг вэ? Мэдээжийн хэрэг, бясалгалын явцад үйлийн үр нэг дор бүрмөсөн арилна гэсэн үг биш; эхний удаад чамд тийм ихийг арилгаж өгч болохгүй. Бодол дээш ахихад л нэг хэсэг нь дахиад арилдаг, ингэх нь бясалгалаар чамайг сайжруулахын тулд хийдэг. Тиймээс энэ Фа-гийн хүч асар их юм. Та бүгд бодоод үз дээ: надад Фалунь-ийг өөрийн биеэр суулгаж өгөх шаардлага байна уу? Хэн ч байсан Дафа-г чин сэтгэлээсээ сурна гэвэл, бясалгахыг хүсэж байвал, бүгд авч болно. Дафа дэлхий даяар тархаж байна. Би дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүн болгонтой уулзах боломжгүй. Хятадад зөвхөн миний хичээлд суусан сурагчид л намайг харж байсан; дийлэнх нь хэзээ ч намайг хараагүй. Фалунь гэх мэт миний чамд өгсөн зүйлгүйгээр чиний бясалгал хийгдэх болов уу? Үгүй, хийгдэхгүй. Тийм ч учраас би энэ номонд өөрийнхөө чадвараа оруулсан. Хүн гагцхүү бясалгаж л байвал, номоо уншиж эхэлмэгц бясалгахад шаардлагатай бүх зүйлийг олж авах болно.

Яг одоо намайг хаа сайгүй хайж байгаа олон сурагч байгаа ч би тэдэнтэй уулзмааргүй байна. Би тэдэнтэй уулзмааргүй байгаа шалтгаан бий, тухайлбал би тэднийг байгаа газартаа өөрсдийгөө тууштай, хичээнгүй бясалгаасай гэж хүсэж байна. Зарим сурагч намайг хараад сэтгэл нь амархан хөдөлдөг, энэ нь түүний бясалгалд саад болдог. Би тэднийг тайван сэтгэлээр бясалгаасай гэж хүсэж байна. Би Фа-г зүгээр л заан тараагаад байж болохгүй, чи бас Фа-г олж авах хэрэгтэй, чамд үүнийг уншиж өөрийгөө жинхэнэ бясалгах хугацаа өгөх хэрэгтэй. Тиймдээ ч би суралцагч нартайгаа бага уулзахыг хичээдэг, эсвэл уулздаггүй. Миний заан тарааж буй Фа чамд хариуцлага хүлээхгүй байсан бол миний хийсэн бүгд дэмий хоосон хийсэн болно. Тиймээс чи гагцхүү ном уншиж, жинхэнэ бясалгаж л байвал, энэ бясалгалаас авах ёстой бүхнээ олж авах нь дамжиггүй. Ийм байх нь лавтай. (Алга ташилт)

Хэдэн мянган жилийн турш Будда Шагжамүнигийн шавь нар багшийгаа харахгүйгээр өөрсдийгөө судар номоор бясалгаж л байсан, тийм ээ? Жинхэнэ бясалгаж л байвал, энэ Фа шаардлагатай бүх зүйлийг өгөх болно. Би ихэвчлэн чамд Фалунь-ийг суулгаж өгөхдөө чамд үүнийг харуулдаггүй, чамд ямар нэгэн зүйл өгвөл л бясалгал сурна гэсэн зууралдсан сэтгэлийг чинь арилгах зорилготой юм.

*Сурагч: Ли багшаа, Та жинхэнэ ба хуурамч чийгон байдаг гэж хэлсэн. Жинхэнийг нь хуурамчаас хэрхэн ялгах вэ?*

Багш: Жинхэнэ болон хуурамч чийгон бясалгалууд байдаг, өнөөгийн хүмүүсийн сайн мууг цэгнэдэг шалгуур нь өөрчлөгдсөн учраас жирийн хүмүүст тэдгээрийг ялгахад үнэхээр хэцүү байдаг. Хүн жинхэнэ бясалгах юм бол аажим аажмаар ялгаж салгадаг болно. Тухайн хүний юу ярьж байгаагаас

хамаарна. Түүний ярьж буй зүйлүүд нь зөв зарчим биш, эсвэл тэр хүмүүст өнгөн дээрээ сайн зүйл хийхийг хэлдэг ч, дотроо мөнгөний төлөө хүнийг хуурдаг. Буддын Фа-гаар бясалгах нь маш нарийн байдаг, мөнгөтэй хэзээ ч, огт хольж хутгаж болохгүй. (Алга ташилт) Хүн мөнгө олохын тулд дэлхийн юуг ч ашиглаж болно, гэвч гагцхүү Буддын Фа-г яасан ч болохгүй. Тэгээд ч зарим хүний зорилго нь алдар нэрд гарахын тулд байдаг, нэр ашиг бол энгийн хүмүүсийн хэзээд ч зууралддаг зүйл юм. Хуурамч чийгон багш нар хүмүүсийг гажуудсан зам руу хөтөлдөг, тэд хүмүүсийг аварч чадахгүй. Харин эсрэгээрээ тэд хүмүүсийг сүйтгэдэг.

Үнэн хэрэгтээ тэдний нүгэл багагүй. Хэрэв тэр Фа-г олж авахаар ирсэн өндөр түвшний суурьтай хүнийг сүйтгэвэл ямар том нүгэл болохыг төсөөлөөд үз дээ. Мөнгө, эд баялгийн төлөө тэр ийм том муу зүйл хийчихээд, "Мөнгө олох гэж ингэсэн" гэдэг нэрийдлээр ийм нүглийг зөвтгөж болохгүй. Хятадад чийгон ид оргилдоо хүрч байх үед чийгон багш нар чийгоныг ямар ч үнэ төлбөргүй түгээдэг байсан. Одоо гарч ирсэн хуурамчууд нь маш замбараагүй болсон. Гэхдээ бас маш олон чийгон багш нар анх гарч ирэхдээ маш сайн байсан. Тэд бүгд Дэд сүнсийг бясалгадаг, тэр өөрийн хүн талаараа юу ч мэдэхгүй. Цаг хугацаа өнгөрөх тусам түүний нэр, ашгийн сэтгэл нь гарч ирдэг. Тэднийг олон нийтэд гарахаас өмнө тэднийг багш нар нь хянадаг байсан, үүний зэрэгцээ тэдний Дэд сүнснүүдийн хязгаарлах нөлөө байсан. Гэвч тэд нийгэмд идэвхтэй болсны дараа тэдний хүн тал нь хүний алдар нэр, ашиг сонирхлын уруу таталтанд өртөмтгий болох нь тодорхой болно. Тэдэнд тийм хүсэл сэтгэл гармагц тэд доош унадаг. Тиймээс тэд гон-гүй болох бөгөөд ингэснээр чийгон багш байсан ч өвчин тусах болно.

*Сурагч: Багш аа, тухайлбал сурагчид бид Төгс гэгээрэлд хүрвэл хаашаа явах вэ?*

Багш: Надад Фалунь диваажин бий. Тэнгэрийн орны диваажингууд маш олон байдаг, би та нарт тэдгээрийн талаар ярьж өгч болно. Энд сууж байгаа олон хүн, энгийн хүнийхээр бол өндөр боловсролтой юм шиг байна, тиймээс би та нартай орчлон ертөнц хэмээх ойлголтын талаар товчхон ярилцъя.

Хүмүүсийн мэддэг нь энэ л нэг орон зай юм, мөн Буддын шашны ойлгодогтой адил тийм энгийн зүйл ч бас биш. Будда Шагжамүни энэ ертөнцөд байхдаа орчлон ертөнцийн үндсэн зарчмуудаас маш олон үнэнийг баталж, гэгээрсэн. Тэр үеийн хүмүүс тэдгээрийг баримтжуулаагүй, судруудад ч эмхлэгдэж бичигдээгүй. Тиймээс тэдгээр нь дэлхийн хүмүүст үлдэж хоцроогүй. Шагжамүни энэ хорвоог орхисноос хойш таван зуун жилийн дараа л хүмүүс судрыг эмхэтгэсэн. Таван зуун жилийн дараа хүмүүс Шагжамүнигийн хэлсэн үгийг яг таг мэдэхэд тун хэцүү байсан, тэдгээр нь өнөөдөр бидэнд байгаа судрууд юм. Үнэндээ тэдгээр нь Будда Шагжамүнигийн анх хэлсэн үгнээс огт өөр болсон боловч буддын шашны

зарим зарчмуудыг агуулдаг, улмаар бясалгахад боломжтой болгосон. [Тэдгээрт агуулагдаж байгаа зүйлс] нь өнгөрсөн хугацаанд хүмүүст мэдэхийг зөвшөөрсөн өчүүхэн зүйлс бөгөөд энэ орон зайн амь бодиуд зөвхөн тийм хэмжээний зүйлсийг л мэдэж болох байсан.

Орчлон ертөнц нь буддын шашны сударт дүрслэгдсэн шиг тийм жижиг биш, өнгөрсөн үеийн бумбын бясалгагчдын ярьсан шиг тийм энгийн зүйл ч бас биш. Тэр үед Шагжамүнигийн заасан зүйл бол Архат Фа байсан бөгөөд Архат Фа бол бүх хүрэх бүтээлийн орны хамгийн доод бүтээлийн орон юм. Мэдээж, тэр бас арай дээд зүйлийг заасан боловч маш бага нь уламжлагдан ирсэн. Будда Шагжамүни мөн тухайн үедээ нэгэн зүйлийг ярьсан: Рулай Будда нар Ганга мөрний элсний ширхэгтэй адил олон байдаг, Рулай Будда бүр өөр өөрсдийнхөө тэнгэрийн оронг удирддаг, түүний ярьсан энэ цар хүрээ нь хүний хувьд аль хэдийнээ асар том юм. Гэвч үнэн хэрэгтээ молекулууд нь бичил ширхгүүдээс бүрддэг бөгөөд хүн молекул болон гаригуудын хооронд амьдардаг гэдгийг та бүхэн мэднэ. Үнэн хэрэгтээ Сүүн зам галагтик бол орчлон ертөнцийн нэг ширхэг бөгөөд олон тооны Сүүн замуудаас бүрдэх орон зай нь хил хязгаар, бүрхүүлтэй байдаг. Үүнийг хүн төрөлхтөн орчлон ертөнц гэж нэрлэдэг. Гэвч бодит байдал дээр энэ бол зөвхөн нэг жижигхэн орчлон ертөнц. Энэ жижигхэн орчлон ертөнцийн цаана юу байгаа вэ? Орчин үеийн шинжлэх ухаан энэ тухай бодохыг ч зүрхэлдэггүй, хүн төрөлхтөнд энэ талаар ойлголт ч байхгүй. Орчлон ертөнц том тэсрэлтээс огт үүсээгүй.

Энэхүү жижиг орчлон ертөнцийн гадна маш хол, маш хол алслагдсан газруудад жижиг ертөнцтэй ижил төстэй тэнгэрийн биетүүд байдаг. Бурхад болон Будда нарын түвшин өөр өөр байдаг бөгөөд доод түвшний Будда дээд түвшнийг харж чаддаггүй. Бүр дээд түвшний Бурхад, Будда нарын нүдэнд энэ нь маш бага хүрээ юм. Хүмүүс үүнийг судлая гэсэн ч боломжгүй. Хүмүүс гэрлийн хурдыг мэддэг боловч гэрлийн хурд хамгийн хурдан нь биш юм. Гэрэл нь цаг хугацаа, орон зайгаар хязгаарлагддаг бөгөөд цаг хугацаа, орон зай нь өөрөө орчлон ертөнцийн бие бодиос/материас бүрддэг. Орон зайн бүх зүйл, тэр дундаа гэрэл нь матери/бие бодь бөгөөд бүх төрлийн бие бодь нь энергитэй байдаг. Бид бүгд энэ молекулын давхаргын орон зайд амьдардаг. Агаар, мод, ус, металл, хөрс, чулуу гээд бүх зүйл энэ молекулын давхарга дахь ширхгээс бүрддэг. Энэ орон зайн хүмүүс молекулын цацраг идэвхт энергийг мэдэрдэггүй, учир нь хүн өөрөө молекулуудаас бүрддэг. Үнэндээ молекулууд ч бас энергитэй байдаг. Хүн төрөлхтний орон зай дахь гэрлийн гадаргуу нь мөн энэ давхаргын ширхгүүдээс бүрддэг. Миний хэлж байгаа нь, өөр өөр орон зайд өөр өөр орон зайны гэрэл байдаг, өөр өөр орон зайд гэрлийг бүрдүүлдэг бие бодиуд нь ч бас өөр өөр байдаг. Мөн цаг хугацаа, орон зайн ялгаатай байдлаас шалтгаалан гэрлийн хурд нь үнэндээ бас өөр өөр байдаг. Ингээд цааш харцгаая: атомууд энергитэй, атомын цөмийн энерги нь бүр их хүчтэй, нейтрон нь бүр их хүчтэй, электрон, кварк, нейтринотой

дараагийн давхарга нь цацраг туяа, энергийн хувьд өмнөх давхаргаас бүр илүү хүчтэй байдаг. Бие бодийн ширхэг жижгэрэх тусам энерги, цацраг нь илүү хүчтэй болдог. Эх сурвалжийн бие бодийн түвшинд энэ хүч нь хүний хувьд асар хүчтэй бөгөөд үүнийг үгээр илэрхийлэхийн аргагүй юм. Мэдээж, хүн эх сурвалжийн бие бодийг хэзээ ч ойлгож чадахгүй.

Энэ орчлон ертөнц хүмүүсийн ойлгодог шиг гүехэн биш гэдгийг хэлэхийн тулд би эдгээр зүйлсийн талаар ярилаа. Орчлон ертөнцөд өөр өөр хэмжээтэй хичнээн орчлон ертөнц байдаг вэ? Энэ бол тоолохын аргагүй. Гэхдээ үүнийг орчлон ертөнцийн жижиг системийн хүрээнд тайлбарлавал дараах байдлаар хэлж болно: ойролцоогоор гурван мянга орчим жижиг орчлон ертөнц нь арай том хэмжээтэй хоёр дахь давхаргын орчлон ертөнцийг бүрдүүлдэг, мөн ойролцоогоор тийм ижил тооны хоёр дахь давхаргын орчлон ертөнцүүд нийлж гурав дахь давхаргын орчлон ертөнцийг бүрдүүлдэг. Ийм байдлаар цааш нь хөөвөл энэ нь хүний хувьд эцэс төгсгөлгүй юм, тэгэхээр энэ тэнгэр (тиань) хэр том бэ? Хүн төрөлхтөн эцэст нь тэнгэрийн биет ямар том болохыг хэзээ ч олж мэдэхгүй гэдгийг би та нарт хэлнэ. Рулай Будда хүртэл үүнийг илрүүлж чадахгүй. Энэ нь асар том юм, мөн хүн төрөлхтний одоогийн мэдлэг дээрээ тулгуурлан ойлгодог зүйл биш.

Миний саяны ярьсныг бодоод үз дээ, хүн төрөлхтний одоогийн эзэмшсэн шинжлэх ухааны тэр өчүүхэн мэдлэг чадвар нь юу юм? Энэ бол “хүүхдийн тоглоом” л гэсэн үг, түүнчлэн орчин үеийн эмпирик (туршилт судалгаан дээр үндэслэгдсэн) шинжлэх ухаан хүмүүсийг бүрэн төөрөгдүүлсэн. Эмпирик шинжлэх ухаан олон хуурамч төсөөллийг бий болгосон. Хүмүүс үүнийг одоогоор хараахан ойлгоогүй байж магадгүй юм. Би та бүхэнд нэг жишээ хэлье. Саяны миний ярьсан орчлон ертөнцийн талаар орчин үеийн эмпирик шинжлэх ухаан үүнийг "Их тэсрэлт"-ийн улмаас үүссэн гэж үздэг. Энэ нь чамд хуурамч төсөөллийг төрүүлж байгаа биш гэж үү? Хүмүүс бүгд л ингэж үздэг. Эмпирик шинжлэх ухаан нь хүнийг хувьслын замаар бүтээгдсэн гэж үздэг, хувьслын онолоор, хүн сармагчнаас үүссэн гэж заадаг. Огт тийм биш. Энэ нь чамайг буруу зам руу хөтөлж байгаа биш гэж үү? Хүмүүсийн бие бодийн/материйн талаарх ойлголт ч бас буруу, тэр ч байтугай түүний үндсэн ойлголт нь ч буруу. Түүнчлэн, хүн төрөлхтөн хуурамч төсөөлөл дунд иймэрхүү танин мэдэхүйгээр бүрэн битүүмжлэгдсэн байдаг. Тэднийг улам чанга битүүмжлэх тусам, хүмүүс өөрсдөдөө сул зай бараг үлдээгээгүй. Мөн энэ орчлон ертөнцийн үнэн [энэ төрлийн мэдлэг]-ээр бүрмөсөн далдлагдсан. Ийм орчин нөхцөлд – та бүгд бодоод үздээ - хэрэв хүн орчлон ертөнцийн үнэний тухай яривал, энэ шинжлэх ухаан үүнийг хүлээн зөвшөөрөх үү? Энэ шинжлэх ухаан аль хэдийн ийм орчныг бүрдүүлсэн тул энэ нь зайлшгүй эсэргүүцэх нөлөө үзүүлнэ. Тиймээс бүр дээд түвшний зүйлсийг ярихад, чамайг мухар сүсэгтэй гэж хэлнэ. Ийм л учиртай юм.

Ийнхүү маш олон хүн хэвшмэл ойлголттой болсон байдаг. Хэрэв өмнөх үеийн хүмүүс тодорхой хууль, номлолыг дэвшүүлэхэд, жишээ нь Эйнштейний харьцангуйн онол гэх мэт, хүмүүс тэдгээрийг шинжлэх ухааны оргил гэж үздэг. Ирээдүй хойч үеийнхэн нь бүгдээрээ үүн дотор хязгаарлагддаг, хэрэв хэн нэгэн үүнээс дээгүүр сэтгэх гэж зүрхлэх юм уу, эсвэл туршилт судалгаандаа түүнээс цааш явахыг зоривол тэр даруй "Чи Эйнштейнээс давуу байж чадах уу?" гэж хэлэх хүмүүс гарч ирнэ. Яагаад тэр вэ? Орчин үеийн эмпирик шинжлэх ухааны одоо байгаа материаллаг орчин нь хүмүүсийг хязгаарлаж байна. Жинхэнэ гарамгай эрдэмтэн өмнөх үеийнхний ойлголтыг давж гарахад, өмнөх үеийнхний үзэл бодол нь тэдний тэр хүрээнд л үнэн болоод зөв гэдгийг олж мэднэ, харин чи тэднийг давж гарвал тэдгээрийг үнэн биш гэдгийг олж мэднэ, харин эсрэгээрээ энэ нь хүмүүсийг хязгаарладаг. Жинхэнэ өөрийнхөөрөө сэтгэдэг, амжилтад хүрсэн хүн тэдгээрийг нэвтэрч гарахыг зүрхлэдэг. Өмнөх үеийнхний хязгаарлалтыг давж байж л чи жинхэнэ ололт амжилтад хүрнэ. (Алга ташилт)

*Сурагч: Бид таны нийтэлсэн судруудыг он цагийн дарааллаар эрэмбэлэхээр зохицуулж байна. Ингэж болох уу?*

Багш: Болно. Энэ "Судар" гэдэг нэр томъёо нь ямар ч онцгой утга агуулагагүй. Энэ нэр томъёоны угийн утга нь хүн байнга сурдаг, байнга уншдаг нийтлэлүүд л гэсэн үг юм. Байнгын лавлах бичвэрүүдийг "судар" гэж нэрлэдэг.

*Сурагч: Намайг бясалгал хийж байхад гэнэт нэг ирвэс гарч ирсэн. Тэр юун ирвэс байсан юм бол?*

Багш: Нэгэнт чи бясалгал хийхийг хүссэн болохоор энэ нь чамд саад болох гэж оролдсон. Үүнээс битгий ай, хэн ч юу ч чамд хор хөнөөл учруулахгүй. (Алга ташилт) Би энэ бүхнийг эхлүүлсэн учраас бясалгагчдад хариуцлагатай хандаж чадна. Та нар үүнд найдаж болно. Маш олон хүн сурч байгаа бөгөөд ямар ч асуудал гараагүй. Гэхдээ нэг зүйл бий: та нар өөрийгөө бясалгагч гэж үзэх ёстой. Хэрэв чамд өөрт чинь айх сэтгэл байвал, бас болохгүй, учир нь айдас бол орхих ёстой хүний зууралдсан сэтгэл.

*Сурагч: Ли багш аа, бид "Фалунь Гон" номноос эхний дасгалыг гурван удаа хий гэж уншсан тул дараа нь бид тус дасгалыг гурван удаа хийдэг болсон. Гэтэл яагаад дээш доош гарны хөдөлгөөн болон Фалунь тэнгэрийн эргүүлэг дасгалыг гурван удаа хийхийг хэлээгүй вэ?*

Багш: Энэ бясалгалыг маш уян хатан нөхцөлтэй гэж би хэлмээр байна. Хэрэв чамд цаг байвал их хийж болно, үгүй бол бага хийж болно. Хэрэв чи өнөөдөр завгүй байгаад зөвхөн нэг дасгал хийсэн ч болно. Хэрэв чамд цаг зав гарахгүй эсвэл ганцхан хөдөлгөөн хийх цаг байгаа бол, тэгвэл чи зөвхөн нэг

хөдөлгөөнийг хийсэн ч болно. Мөн чамд илүү их цаг гарвал илүү олон удаа хийсэн ч болно. Гэхдээ чи есөн удаа давтсаны дараа зогсох ёстой, үргэлжлүүлэх хэрэггүй, ингэвэл арай дээр. Миний энэ Фа бясалгал бусад бясалгалуудаас ялгаатай. Бусад бясалгалын аргуудын хувьд дасгал хийх үед дасгал хөдөлгөөн идэвхжиж, хийхгүй бол зогсонги болдог, зогсчихдог. Биднийх бол хорин дөрвөн цагийн турш хүнийг бясалгадаг, үүнийг "Фа хүнийг бясалгах" гэж нэрлэдэг. Тэгвэл бид ямар зорилгоор дасгал хийдэг вэ? Миний чамд суулгаж өгсөн механизмуудыг бэхжүүлдэг. Хөдөлгөөн нь механизмын дагуу явдаг гэж би яагаад хэлсэн бэ? Дасгал хийх явцад чиний гарт энерги нэмэгдэж, бясалгагч механизмыг идэвхжүүлж байдаг. Ингэж идэвхэжсэнээр механизмууд улам хүчтэй болдог. Ингэснээр энэхүү механизм нь чиний хөдөлгөөнийг автоматаар хөтөлдөг.

*Сурагч: Фа сурах хамгийн сайн арга юу вэ? Номыг зүгээр л унших уу, эсвэл уншиж байхдаа хуулах уу, эсвэл зүгээр л номыг хуулах уу?*

Багш: Эх газрын Хятадад олон хүн энэ номыг цээжилдэг, хуулж бичдэг хүмүүс бас олон байдаг. Цээжлэж чаддаггүй хүмүүс байнга уншдаг. Аль арга нь ч болно. Номыг цээжилсэн хүмүүс асуудалтай тулгарах бүртээ Фа-г шууд санадаг. Иймээс тэд амархан муу зүйл хийхгүй. Хуулан бичих нь хүний ойлголтыг гүнзгийрүүлэхэд тусалдаг. Байнга уншихын зорилго нь ойлголтыг гүнзгийрүүлэх, байнгын сайжралтыг бий болгох явдал юм.

*Сурагч: Багш аа, бид таныг "Багш" (лаоши) гэж дуудах нь зохисгүй юм шиг санагдаж байна. "Багш" (лаоши) гэдэг нь дэндүү түгээмэл нэр томъёо мэт санагдаж байна, Хятадын нөхцөл байдлаас шалтгаалан та биднийг "Багш" (лаоши) гэж дуудахыг хүссэн байх гэж бодож байна. Тиймээс энд бид "Сайн байна уу, Их Багш аа" (шифу) гэж тантай мэндлэе. Урьд нь бидний зарим нь Буддын шашны суурьтай хүмүүс байсан, Их Багш (шифу) бидний дээр байдаг учраас "Багш"(лаоши) гэж дуудах нь зохисгүй санагддаг.*

Багш: Баярлалаа. Үнэндээ, та нар намайг Багш (лаоши), Их Багш(шифу), Мастер эсвэл миний нэрээр, алинаар нь ч дуудсан болно, зүгээр. Бүгд болно.

Яагаад би та нарыг хүссэнээрээ намайг дуудаж болно гэж байгаа вэ? Учир нь өнөөгийн нийгэм тэдгээр зөв бус зүйлсээр ноцтой үймүүлэгдэж байна. Зарим нь өөрсдийгөө Будда, зарим нь амьд Будда, зарим нь Их Багш, зарим нь шашны тэргүүн гэж нэрлэцгээдэг. Гэхдээ тэд бүгд алдар нэр, ашгийн төлөө биш гэж үү? Та нар хүссэнээрээ намайг дуудаж болно гэж би хэлье. Намайг "Багш" (лаоши) гэж дуудахад буруудах зүйлгүй. Би эдгээр цол хэргэмүүдийн алийг нь ч хүсэхгүй, тийм юм хайдаггүй. Гэхдээ мэдээжийн хэрэг, хэрэв та нар миний сурагчийн хувьд намайг хүндэтгэж, багш тань чамайг үнэхээр аварч, чамд тусалж байгааг мэдэрч, тэр шалтгаанаар надад тодорхой байдлаар

хандахыг хүсэж байвал энэ нь чиний хэрэг. “Багш” (лаоши) гэж дуудсан ч болно.

*Сурагч: Өөр нэг зүйл байна, тэр нь сая багш "Битгий мөнгөний төлөө бай" гэж хэлсэн. Энэ нь надад жинхэнэ Будда гэдгийг мэдрүүлсэн. Мэдээж, Багш номондоо өөрийгөө Будда гэж хэлээгүй, гэхдээ бид буддизмыг шүтэж байхдаа үнэхээр удирдан чиглүүлж чаддаг ийм гэгээн Багштай хэзээ ч таарч байгаагүйг санадаг. Тэгээд би бусдад хандан “Та нараас мөнгө нэхэхгүй атлаа чамд бясалгалыг зааж, үйлийн үрийг чинь арилгадаг Багшийг хаанаас олох гэж? Чи ийм Багш харж байсан уу?” гэж хэлдэг. Би яагаад энэ тухай одоо яриад байна вэ? гэвэл Багш маань үнэхээр бидний бясалгалыг удирдан чиглүүлэхээр ирсэн зөвлөгч гэдгийг би мэдэрдэг болохоор өнгөрсөн хугацаанд сурсан зүйлээ огт тоодоггүй. Энд байгаа хүмүүсийн дунд Буддын шашны олон хүн, энгийн Буддын сүсэгтнүүд болон бусад зүйлийг судалдаг хүмүүс олон байгаа гэж би бодож байна. Харин өнөөдрөөс эхлэн гэгээн Багшаа бидний бясалгалыг удирдан чиглүүлдэг жинхэнэ Багш гэж үзэж, өөр зүйл хийх ёсгүй гэж бодож байна. Мэдээж, би бусдын өмнөөс ярьж зүрхлэхгүй, гэхдээ Багшийг өнөөдөр энд ирсэн болохоор би олон жилийн турши илэрхийлэхийг хүсэж байсан үгсээ эцэст нь хэллээ.*

*Би бүх амьдралынхаа туршид өндөр түвшинд бясалгахыг хүсдэг байсан боловч хэзээ ч олж чадаагүй. Би тарнийн буддизмд суралцаж байсан, мөн зарим чийгонд суралцаж байсан. Би бүр нэгэн их Багшийн шавь болж байсан. Гэвч дараа нь би өөрийгөө яг л урьдын хэвээрээ байгааг мэдэрсэн, надад өөр ямар ч мэдрэмж байгаагүй. Багшийн Фа-г сонссоны дараа [би ингэж хэлж чадна] Багшийн Фа бол Буддын Фа. Эхний өдөр видео лекц үзэхээр очиход багш "Чи үнэхээр бясалгаж л байвал..." гэж хэлэхэд би зурагт руу "Би үнэхээр бясалгамаар байна" гэж хэлсэн, гэхдээ би Багшийг АНУ-д ирээсэй гэж хүсэж байсан. Энд байсан бид бүгд багшийг ирнэ гэж найдаж байсан. Тиймээс Багш биднийг улам гэгээрүүлж, Сан Франциско хотод энд юунд анхаарлаа хандуулах ёстой талаар нэмэлт зөвлөгөө өгнө байх гэж найдаж байна. Энэ бол миний чин сэтгэлийн хүсэлт. (алга ташилт)*

*Буддын шашны сүсэгтнүүд олон байдаг, тэд өөрсдийн бясалгалын зүйлээ орхиход хэцүү байдаг. Тиймээс бид тэдэнд туслах үүрэгтэй. Харин багшаас шууд асуух гэсэн асуулт байна, тэр нь өмнө нь буддын шашинтай байсан, олон жил судар уншиж, бурханд мөргөж ирсэнн хүн байгаа.*

*Тэрээр судруудыг (бурхны шашны эртний судар) унших болгонд анхилуун үнэр үнэртдэг байсан бол Фалуны Гоны номыг уншихад сонин үнэр үнэртдэг гэсэн. Багш өнөөдөр энд байна, би юу ч мэдэрдэггүй, юу ч надад харагддаггүй болохоор энэ талаар тодруулж өгөхийг Багшаас хүсэж байна.*

Багш: За. Үнэндээ Дарма-гийн Төгсгөлийн үед жинхэнэ Будда нар дэлхий ертөнцийн аливаа үйл хэрэгт санаа тавихаа больсон. Гэвч охь чий олж авсан олон амьтад Буддын хөшөөн дээр авирч гарсан, хүмүүсээр шүтэн бишрүүлж, тахиулдаг. Тэд хүмүүст өчүүхэн төдий зүйл хийдэг, эсвэл тэдэнд бага зэрэг тусалдаг. Нэгэнт тэр хүн үнэхээр бясалгах хүсэлтэй бол тэдгээр зүйлс саад болдог. Жишээлбэл, зарим хүн ямар нэг бясалгал хийхэд анхилуун үнэр үнэртдэг гэж үздэг ч, үнэн хэрэгтээ энэ үнэрийг үен ялгаруулдаг. Хоёр орон зайны үнэр өөр байдаг: энэ талдаа анхилуун үнэртэй, нөгөө талдаа өмхий үнэртэй байдаг. Хүний ертөнцийн зарчим урвуу байдаг, бусад бүх зүйл ч мөн адил. Хүний хувьд анхилуун үнэртэй байдаг зүйл нь Буддад дотор муухайрмаар байдаг. Тэд чамайг Дафа сурахад саад учруулахыг хүсэж байгаа тул, зориудаар ийм үнэр гаргаж саад учруулсан.

Сан Франциско дахь манай сурагчид зөвхөн Сан Франциско руу чиглэх биш, харин АНУ бүхэлд нь харах ёстой гэж би бодож байна. Хэрхэн бясалгахын тухайд энэ хэлбэрийг баримтлах хэрэгтэй. Миний хийж байгаа зүйл бол ирээдүй хойч үедээ ийм аргаар аливаа зүйлийг хийх зам үлдээж байна. Эс бөгөөс би сүм хийдэд очиж лам болох байсан. Гэхдээ би лам болсон бол энэ бүхэн бүтэхгүй байх байсан. Шашин аль хэдийнээ олон хүмүүст Фа-г олж авахад нь тусалж чадахгүй болсон. Би хүмүүсийг бясалгуулахын тулд энэ хэлбэрийг сонгож авсан тул та нар энэ маягаар үргэлжлүүлээрэй. Хэн нэгэн миний бясалгалд орсон л бол бүх төрлийн дүрэм журамд захирагдана гэсэн үг биш. Ингэж болохгүй. Хэрэв хүн суралцахыг хүсэж байвал үүнийг ойлгох явц байдаг. Хэрэв хүн үүнийг сайн гэдгийг мэдэж авбал, номыг сайн уншаарай гэж хэлээрэй. Түүний ухамсар сайжирвал тэр автоматаар, ухамсартайгаар аливаа зүйлийг илүү сайн хийх болно. Энэ утгаараа буддын сүсэгтнүүдийн хувьд эдгээр зүйлс харьцангуй хялбар байдаг. Лам хувраг нар хамгийн өрөвдөлтэй нь, шашны энэ хэлбэр нь тэднийг бүрмөсөн хаачихдаг, тэд Фа-д нэвтэрч чадахгүй, харилцахыг ч зүрхлэхгүй.

*Сурагч: Багш аа, надад хоёр асуулт байна. Эхний асуулт бол: Хувь тавилангийн улмаас багш энд ирж бид бүхэнтэй уулзсан. Багш бидэнтэй хувь тавилангийн холбоотой гэж хэлсэн. Тэгвэл багш бидний түвшний талаар ямар бодолтой байдаг вэ? Бидний энэ хэсэг сурагчид Төгс гэгээрэлд хүрч чадах уу?*

Багш: Энд сууж байгаа бүх хүмүүс, тэр дундаа хүүхдүүд ч гэсэн багтана, та нар бясалгаж чадаж л байвал, миний чамд зохицуулж өгсөн зам эцэстээ Төгс төгөлдөр лүү хөтөлнө гэдгийг би хэлье. (Алга ташилт) Гэхдээ хэтэрхий эрт баярлах хэрэггүй. Бясалгахын тухайд, Багш чамайг үүдээр оруулж өгнө, бясалгах нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална. Би чамд зохицуулж өгнө, би чамайг хамгаалж болно, чамайг адислана, мөн түвшин бүрт гоныг хувиргаж ахиулна. Харин зүрх сэтгэлээ бясалгах нь хүнээс өөрөөс нь шалтгаална. Энэ зүрх сэтгэл аливаа бэрхшээлтэй тулгарах үед, сорилттой тулгарах үед, тэвчиж



чадах эсэх, даван туулж чадах эсэх нь чамаас бүрэн хамаарна. Мэдээж, чи үнэхээр давж чадахгүй бол чамд дохио сануулга өгөх болно, тэр үед чиний бодол хэт туйлширч ухамсарлахгүй байх вий гэхээс миний санаа зовж байна, яаж дохио сануулга өгсөн ч ухамсарлахгүй, тийм байвал маш хэцүү. Би та нарт хэлье, та нар сорилтыг давж чадахгүй үед, хатуу үг сонсоход, энэ нь үнэхээр миний Фашэнь чамайг сэрээхийн тулд, ямар нэг зүйл хэлэхийн тулд таагүй үгсийг ашигладаг гэдгийг би чамд хэлье. Сорилтыг давахад хэцүү, давсны дараа эргээд харвал тэр сорилт үнэхээр юу ч биш байсныг, тэр үед яагаад түүнд ингэтлээ зууралдсан нь гайхмаар санагдах болно. Хэрэв чи үүнийг үнэхээр даван туулж чадвал чиний шиньшин сайжирч, үйлийн үр чинь арилах нь баталгаатай. Чамд тохиолдсон бэрхшээл бусдаас болсон бол тэд чамд буянаа өгнө. Тиймээс зовлон амсах нь муу зүйл биш гэдгийг би та нарт хэлье. Зөвхөн хүн л зовлонг муу зүйл, зовлонтой амьдрал аз жаргалгүй гэж боддог. Бясалгадаг хүний хувьд зовлон нь үйлийн үрийг арилгаад зогсохгүй түвшинг дээшлүүлж, Гэгээрлийн хутагт хүргэх болно. Хэрэв чи зүгээр л хүмүүсийн дунд аз жаргалтай амьдармаар байна, жаахан ч зовохыг хүсэхгүй байна гэвэл, ая тухтай бясалгахыг хүсвэл чиний үйлийн үр арилахгүй, чиний шиньшин сайжрахгүй, чи Гэгээрлийн хутагт хүрч чадахгүй. Ийм л зарчимтай.

Хэдийгээр намайг ингэж ярьсан ч, Фа-гийн зарчмуудыг тодорхой зааж өгсөн ч, та нар туулах зовлонгоо тэвчиж чадахгүй байх магадлалтай. Би өмнө нь та нарт нэг үнэнийг хэлсэн. Будда яагаад ийм их буян адислалтай байдаг вэ? Түүнд жинхэнэ аз жаргал, урт удаан наслалт аль аль нь бий, учир нь тэр асар их зовлон зүдгүүр эдэлсэний хэрээр, тэр хэмжээний буян адислалуудыг олсон. Хэрэв би өнөөдөр энд сууж байгаа та бүхнээс ийм их зовлон зүдүүрийг туулахыг хүсвэл та нарын хэн нь ч төгс төгөлдөрт хүрч чадахгүй. Үнэндээ чи цааш үргэлжлүүлэн бясалгаж чадаж байвал, Багш нь чамд тусалж бүр их үйлийн үрийг чинь арилгаж өгнө. Миний түрүүн хэлсэн зүйл хэвээр: энэ Фа-г олж авахын тулд, та нар магадгүй олон амьдралынхаа туршид их зовлон зүдүүр туулсан. Олон хүн үнэхээр энэ Фа-г олж авахаар ирсэн тул тэдний зовлон зүдүүр эртнээс эхэлсэн. Өнөөдөр чамд юу дутагдаж байна вэ? Чамд дутагдаж байгаа цорын ганц зүйл бол энгийн хүний зууралдсан сэтгэлээсээ салах явдал юм. Миний ярьж буй зовлон бол голчлон хүний сэтгэлийг орхихтой холбоотой зовлон юм.

## Бээжинд болсон олон улсын туршлага солилцох чуулганы үед айлдсан Фа сургаал

Ли Хонжи

1996 оны 11 сарын 2 ~ Бээжин

Би та нарын сэтгэлийг мэднэ, би бас та нарыг санадаг. Гэхдээ би та нарт хэлье: чи өөрийгөө хичээнгүйлэн бясалгаж л байвал би үргэлж чиний хажууд байдаг. Олон суралцагч маш сайн бясалгаж байгаа—би ч бас үүнийг мэднэ. Мөн олон шавь гэгээрэлд хүрэхийн босгон дээр байгаа.

Сүүлийн үед би олон сурагчдад ийм нэг үг хэлж байгаа. Энэ Фа-г олж авах нь маш амаргүй байдаг гэж би хэлсэн. Магадгүй зарим хүн “Би энэ мэдээлэлийг сонссон, эсвэл найз маань надад хэлсэн, энэ номыг тохиолдлоор олж харсан, эсвэл сонин дээрх мэдээллийг хараад ирсэн, тэгээд л Дафа бясалгалын замд хөл тавьсан” гэж боддог. Үнэндээ чи үүнийг маш энгийн зүйл гэж битгий хар, өнгөн дээр энэ Фа-г олж авахад хялбар мэт санагдсаныг битгий хар. Яагаад гэвэл нэг бурхан гарч ирээд чамайг очоод Фа-г олж ав гэхгүй нь лавтай. Ихэнх тохиолдолд энэ нь энгийн хүний иймэрхүү хэлбэртэй байдаг, та нар үүнийг маш энгийн байдлаар олж мэддэг. Гэхдээ би та нарт хэлье, энэ Фа-г олж авахад чамд үнэхээр хэцүү байсан. Магадгүй амьдралынхаа эхний хэсэгт чиний туулсан зовлон бэрхшээлүүд энэ Фа-г олж авахын төлөө байсан. Энэ бол чиний мэдэж байгаа зүйл. Чиний мэдэхгүй зүйлс бас л байна; магадгүй чи энэ Фа-г олж авахын тулд өмнөх амьдралууддаа эсвэл түүнээс ч илүү урт удаан хугацаанд зовж, зовлон зүдүүрийг туулсан байж болох юм. Мөн энэ Фа-г олж авахын тулд бүр их зовлон зүдүүрийг амссан хүмүүс байдаг, энэ бол чиний мэдэхгүй зүйл юм. Ирээдүйд чи гэгээрлийн хутагт хүрэх үедээ, чи бүгдийг нь мэдэх болно, бас харах болно. Энэ нь маш амаргүй байсан. Та бүгд аль хэдийн энэ Фа-гийн талаар нэлээн тодорхой ойлголттой болсон. Та нар яагаад ингэж бясалгаж чадаж байна вэ? Учир нь та нар, энэ Фа бол жирийн нэг Фа биш гэдгийг мэдсэн болохоор тэр юм. Эрт дээр үед Буддизмд Будда Шагжамүни олон зүйлийг баталж гэгээрч, хүмүүст маш их зүйлийг үлдээсэн. Гэсэн хэдий ч Будда Шагжамүнигийн хүмүүст үлдээсэн зүйлс уламжлагдах явцдаа, цаг хугацааны явцад их алдагдсан. Түүнээс гадна сударт бичигдсэн зүйлийг зарим хүн өөрчилсөн, өөрчилж оруулсан. Буддын шашны судруудын янз бүрийн хувилбаруудад ижил нэг зүйлийг өөр өөрөөр тэмдэглэсэн байдаг, энэ нь бас Будда Шагжамүнигийн заасан зүйлсийг Дарма-гийн төгсгөлийн эринд ороход нь нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг юм. Мэдээж бас Дарма-гийн төгсгөлийн үе рүү явуулахад хүргэсэн бусад шалтгаанууд ч байсан.

Өнөөгийн нийгэм нэлээд ээдрээтэй болсон тул, хүмүүсийг бясалгахад улам бүр хэцүү болгож байна. Миний зааж байгаа энэ Фа маш агуу гэж би хэлнэ, манай сурагчид үүнийг аль хэдийн анзаарсан байх. Түүхийн туршид хэн ч орчлон ертөнцийн Фа-гийн жинхэнэ зарчмуудыг системтэйгээр хүнд зааж байгаагүй, түүнчлэн хүмүүст хэрхэн бясалгах, бясалгалаар хэрхэн дээшилж болохыг хэлж байгаагүй. Мэдээж Шагжамүни бол Будда учраас хэлсэн үг нь Буддын мөн чанартай байсан. Гэхдээ би та бүгдэд хэлье, Будда Шагжамүни үнэндээ орчлон ертөнцийн үндсэн Фа- хуулиудыг хүмүүст хэлж өгөөгүй. Тийм ч учраас Будда Шагжамүни амьдралынхаа сүүлийн жилүүдэд “Би ямар ч Фа заагаагүй” гэж хэлсэн. Тэгээд эцэст нь тэрээр шавь нартаа "Сахил санваарь-ийг Багшаа гэж үз" гэж хэлсэн. Тэр яагаад ингэж хэлсэн бэ? Энэ нь Будда Шагжамүни Дарма-гийн төгсгөлийн үеийн эцэст юу тохиолдохыг, түүний заасан Фа нь замбараагүйтхийг мэдэж байсан учраас юм. Тэрээр шавь нартаа “Миний заасан эдгээр сахил санваарийн дагуу та нар өөрсдийгөө бясалгаж чадвал бясалгагчийн шалгуурт хүрч, Төгс төгөлдөрт хүрэх боломжтой” гэж хэлсэн. Тиймээс түүний хүмүүст үлдээсэн жинхэнэ зүйл нь сахил санваарь юм.

Мэдээж Шагжамүни бол Будда учраас хэлсэн үг нь Буддын мөн чанарыг агуулсан байсан. Тэгэхээр түүний хэлсэн үгийг Фа биш гэж хэлж болохгүй. Гэсэн хэдий ч тэдгээр нь орчлон ертөнцийн үндсэн агуу Фа, хамгийн өндөр тэнгэрийн зарчим биш юм. Харин өнөөдөр миний та бүгдэд үлдээж байгаа зүйл бол энэ орчлон ертөнцийн энгийн хүний энэ түвшнээс эхлээд, хамгийн дээд Фа хүртэлх бүхнийг багтаасан Фа гэж хэлж болно. Гэсэн хэдий ч *"Жуань Фалунь"* энэ номноос энгийн хүмүүс үүнийг өнгөн дээрээс нь харж чадахгүй, учир нь бясалгахыг хүсдэггүй хүмүүс үүнийг нэг удаа уншаад л болоо гэж үздэг. Тэд үүнийг нэг удаа уншиж дуусаад “Энэ ном хүмүүст хэрхэн сайн хүн болохыг зааж өгсөн байна” гэж боддог. Нэг удаа уншсаны дараа ийм ойлголт төрдөг. Дөнгөж бясалгаж эхлэхэд та нарт ч бас ийм ойлголт төрж байсан байх. Гэхдээ чи үүнийг хоёр дахь удаагаа уншихад яг тийм биш юм байна гэдгийг олж мэднэ. Эхний удаа уншсаны дараа чиний оюун санаанд үүсэж буй асуултууд бүгд хоёр дахь уншлаганд хариулагдах болно. Мөн энэ нь энгийн хүний ном биш гэдгийг чи олж мэдсэн ч, энэ нь юу болох талаар ямар ч дүгнэлтэд хүрч чадахгүй. Гэхдээ та нар үүнийг гурав дахь удаагаа уншихад үнэхээр бясалгалыг заадаг ном болохыг олж харна. Хэрэв үүнийг дөрөв, тав дахь удаагаа уншиж чадвал, энэ ном чамайг насан туршид чинь дагалдан явах болно—чи үүнийг гараасаа ч салгахгүй.

Яагаад ийм байгаа вэ? Яагаад гэвэл би аль хэдийн хэлсэн, энгийн хүний зарчмаар удирдуулж, чи Буддын хүрээ рүү бясалгана гэвэл энэ нь ямар ч боломжгүй. Гэхдээ бидний номны дотоод агуулга нь маш гүн гүнзгий бөгөөд нэг өгүүлбэрийн талаар өөр өөр түвшинд, өөр өөр хүрээнд өөр өөр мэдрэмж, ойлголттой байх болно, энгийн хүний аливаа номноос ийм мэдрэмжийг огт авахгүй; яагаад гэвэл энэ нь маш олон нууцыг агуулдаг. Би та нарт ямар ч

бурханлаг хүчийг үзүүлж байгаагүй, хүн эдгээж байсан ч тэр бүгд тухайн үеийн *чийгоны* нөхцөл байдалд тааруулж хийсэн. Тийм биш байсан бол би өвчин эдгээх зүйл хийхгүй байх байсан. Чи бясалгалаар бие махбодоо өөрчилж, Буддын Фа-гийн бурханлаг чадварыг олж, түвшнээ үргэлжлүүлэн дээшлүүлж, Гэгээрлийн хутагт хүрснийхээ дараах бүх зүйлийг олж авахыг хүсвэл, энэ бүгдийг би энэ Фа-д оруулсан байгаа. Чи үүгээр хичээллэж байгаа цагт чиний бие өөрчлөгдөх болно; чи үүнийг уншиж байгаа цагт чиний оюун санаа дээшлэх болно; мөн чи өөрийгөө бясалгаж байгаа цагт өөр өөр хүрээнд өөр өөр хүрээний төлөв байдлыг олно. Хэрэв чи үүнийг дуустал нь уншаад л байвал энэ номын удирдлаган дор чи Гэгээрлийн хутагт хүрэх болно. Энэ бол яг ийм ном юм. Гэсэн хэдий ч энгийн хүмүүс үүний өргөн болоод гүн гүнзгий дотоод утга агуулгыг олж харах боломжгүй.

Мэдээж, үүнд бас нэг асуудал бий. Энд сууж буй Фа-г олж авсан та бүхэн, Дафа-гаар бясалгаж буй бүх хүмүүс бүгд мэдэж байгаа, та нар үүнийг бясалгалын явцад мэдэрсэн, өөр өөр хүрээнд, өөр өөр түвшинд түүний өөр өөр утгыг мэдэрсэн. Тийм учраас би энэ Фа бол жирийн Фа биш гэдгийг хормын өмнө хэлсэн; энэ бол орчлон ертөнцийн мөн чанар юм. Би хүнд орчлон ертөнцийн хамгийн үндсэн зүйлийг дамжуулсан. Мэдээж энэ хийж байгаа зүйл бол асар том юм; энэ бол Дафа (Агуу хууль), Дафа гэдгийг би олон удаа онцолж байсан. Зарим хүн намайг их юм зааж сургасан болохоор “Дафа” гэж нэрлэсэн гэж бодож магадгүй. Үнэндээ бол тийм биш. Миний яриад байгаа энэ Дафа-гийн ухагдахуун маш гүн гүнзгий юм.

Маш өндөр хүрээнд бясалгаж буй суралцагчид нэг байдлыг олж харна: тэд зөвхөн хүн Дафа-г сурдаггүй болохыг олж мэднэ. Маш өндөр хүрээний амь бодиуд ч үүнийг сурч байна. Энэ Фа бол үнэхээр асар агуу юм. Энд сууж байгаа та нар бүгд хувь тавилантай учраас энэ Фа-г олж авсан. Би хэлснээ давтан хэлмээр байна: хүн бүр энэ Фа-г сонсох боломжгүй. Та нар ийм том цэцэрлэгт хүрээлэнд дасгалаа хийдэг, хүмүүс ийш тийш холхилдон яваад л байдаг, зарим хүн яагаад ч хардаггүй, зарим нь ирсэн ч хүлээж авдаггүй, тиймээс тэр бас л юу ч олж авахгүй, үүнийг хүн болгон олж авдаг юм биш. Зарим хүн энэ номыг уншсаны дараа сайхан санагддаг бол зарим нь үүнийг уншсан ч хүлээж авдаггүй. Хүмүүс өөр өөр байдаг ч үүний цаана учир шалтгаан бий. Би түрүүн хэлсэнчлэн энэ бол энгийн хүний ном биш. Мөн би АНУ-д ингэж хэлж байсан: энэ Дафа яагаад хүмүүсийг бясалгалын маш өндөр түвшин рүү дагуулж чадаж байна вэ? Яагаад гэвэл энэ Фа-г маш доогуур түвшинд харахад өгүүлбэр болгон нь зарчим юм. Хэрвээ чи үүний жинхэнэ байдлыг харж чадвал үг бүр нь Буддын дүртэй болохыг олж мэдэх болно. Хэрэв чи маш өндөр түвшинд бясалгаж чадвал, Тэнгэрийн мэлмий чинь дээд түвшний зүйлсийг харж чаддаг бол, чи нэг үзэгдлийг олж мэднэ: үг бүрийн ард тоо томшгүй өөр өөр түвшний Будда нар давхарга давхаргаараа илэрдэг. Та бүгд бодоод үз дээ: түүний дотоод утга нь хэр гүн гүнзгий вэ? Яагаад адилхан нэг өгүүлбэр өөр өөр хүрээнд өөр өөр байдлаар өөрчлөгддөг

вэ, яагаад энэ Фа-гийн зарчмууд өөр өөр түвшинд бүхэлдээ өөрчлөгддөг вэ? Ийм л байдаг. Тиймээс та бүгд энэ номыг энгийн хүний ном гэж битгий үзээрэй. Үүнийг заавал эрхэмлэх ёстой.

Дээр үеийн хүмүүс Буддын тухай ярихдаа хязгааргүй хүндлэх сэтгэлээр ханддаг байсан, маш баяртайгаар ёслол төгөлдөр байдалд л Будда, Бодьсадва, Архатын тухай ярьдаг байсан. Гэтэл өнөөгийн хүмүүс Буддын нэрийг туйлын бодлогогүй, тоомсоргүй байдлаар амнаасаа унагадаг, маш энгийн мэтээр ярьдаг. Энэ нь хүн төрөлхтөн бурхан байдагт итгэддэггүй болтлоо хөгжсөнөөс үүдэлтэй юм. Яагаад гэвэл Будда бол хэн ч дураараа яриад байдаг зүйл биш, энэ нь Буддаг хүндэлж буй эсэхтэй холбоотой томоохон асуудал юм. Гэвч өнөө үед хүмүүс Буддын талаар дураараа хошигнож, бүр Буддаг хоол идэхдээ хүртэл гутаах болсон. Будда-г гутаасан олон хоолны нэрс байдаг. “Архатын цагаан хоол”, “Будда ханан дээгүүр харайх” гэх мэт хоолны нэрс гарч ирсэн нь Будда-г доромжилж, гутааж байна. Тэр ч байтугай эдгээр цагаан хоолтой зоогийн газруудын заримыг нь Буддын сүсэгтнүүд, эсвэл лам хуврагууд ажиллуулдаг ч тэдний хэн нь ч Буддаг доромжилж байгаагаа мэддэггүй бололтой. Лам, гэлэнмаа нар яагаад бясалгаж чадахаа больсон бэ? Тэд хэдийнээ яаж бясалгахаа мэдэхгүй болсон. Тэд "Архатын цагаан хоол" гэсэн нэр томъёог хэрэглэхэд юу нь буруу гэж?" гэж бодож магадгүй юм. Та бүгд бодоод үз дээ. Тэгвэл архатын хувьд энэ хорвоогийн ямар ч үнэр, амтанд зууралддаггүй, харин ч “Архатын цагаан хоол” нь өөрөө үнэр, амтаараа баялаг юм. Чи тухайн түвшнээс хараад үз дээ, энэ нь түүнийг доромжилж байгаатай адил биш гэж үү? “Будда ханан дээгүүр харайх нь” ч мөн адил. Будда хүний ертөнцийн амттай хоолыг үнэртээд ханан дээгүүр харайлган гүйж ирэх юм гэнэ?! Энэ нь Буддаг доромжилж байгаа хэрэг биш гэж үү? Будда хүний хоолонд зууралдана гэж үү? Би зөвхөн өнөөдрийн үзэгдлийн талаар ярьж байна. Үнэндээ маш олон зүйлийн тухайд Буддад маш ихээр хүндэтгэлгүй ханддаг болсон. Хэрээс хэтэрсэн! Хүмүүс Буддын тухай ярихад, тэдэнд зөв бодол огт байдаггүй, тэр байтугай шууд Буддаг доромжилж зүрхэлдэг. Зарим утга зохиол, урлагийн бүтээлүүдэд ч гэсэн Буддаг хорон муугаар дүрсэлсэн байдаг, тэд ийм хэмжээнд хүрсэн. Та бүгд бодоод үздээ, хүний нийгэм ямар болсон байна? Би та бүгдэд хэлье, энэ номыг, энэ Дафаг би зааж байна. Би аливаа буруу зүйлийг зөв болгож засаж залруулахыг хүсэж байна. Фа тоолшгүй олон түвшний, эсвэл янз бүрийн хүрээний Будда, Бумба, Бурхадын Фа зарчмуудыг агуулдаг. Тиймээс та нар энэ номыг заавал эрхэмлэх ёстой; энд тэнд шидэлж юмуу эсвэл хаа хамаагүй газар бүү тавь. Би Фа-г зааж байсан эхэн үед энэ асуудлыг онцолж байгаагүй, зарим хүмүүс Фа сонсож байхдаа үүн дээр суудаг байсан. Тэр үед чи мэдэхгүй байсан болохоор би чамайг буруутгаагүй. Харин одоо та нар бясалгалаар тодорхой хэмжээнд дээшилсэн, Фа гэж юу болохыг мэддэг болсон. Тиймээс би өнөөдөр энэ асуудлыг ярьж, хүн бүр энэ асуудалд анхаарлаа хандуулаарай гэж хэлж байна.

Энэ дашрамд би та бүгдэд бас нэг асуудлыг ярья. Манайд маш дажгүй бясалгаж байгаа олон хүн байдаг, тэд өөрсдөө ч дажгүй сайн бясалгасан гэдгээ мэддэг. Гэсэн хэдий ч заримдаа тэдний толгойд зарим нэг асуудал байнга гарч ирдэг, энгийн хүмүүсийн зууралддаг зүйлс, янз бүрийн сэтгэл хөдлөл зэрэг зүйлс бодолд нь эргэлдсээр байдаг. Зарим сурагчид маш их санаа нь зовдог: "Би чухам хэр бясалгаж байгаа юм бол оо?" Би та бүгдэд хэлье, хэрэв чи бясалгагч гэдгээ мэдэж байвал, чи бас бясалгалын шалгуурыг баримталж байгаа л бол, чиний бодолд үнэхээр ийм байдалтай байдаг бол санаа зовох хэрэггүй. Яагаад вэ? Учир нь бид энгийн хүний нийгэмд бясалгадаг, чиний энгийн хүний зүйлс ба нүглийг бүгдийг нь аваад хаячихвал, чи энд нэг ч хоног байж чадахгүй гэдгийг хэлье. Энгийн хүний бодолд туссан янз бүрийн бодлыг чи тэвчиж чадахгүй, яагаад гэвэл энгийн хүний хэлсэн үг, үйлдэл, бодол бүр нь цаанаа ямар нэгэн зорилготой байдаг, энэ зорилго нь ер нь хувиа хичээсэн байдаг, тийм болохоор чи тэсэхгүй. Хэрэв чамд эдгээр зүйлс байхгүй байсан бол, чи бусдыг харах бүрт, энгийн хүмүүстэй харьцах бүрдээ тэсэхгүй нь гарцаагүй. Хүний үг, үйлдэл бүрт маш хүчтэй зууралдал байдаг гэдгийг чи мэдрэх болно. Чи тэгвэл энгийн хүмүүсийн дунд бясалгаж чадахгүй болно, чи байж ч чадахгүй, ажлаа ч хийж чадахгүй болно. Тиймээс би та бүгдэд аажмаар хүний өнгөцхөн тэдгээр зүйлсийг арилгаж өгнө, Төгс төгөлдөрт хүрэн хүртэл чинь бүгдийг нь арилгаж өгнө.

Тэгвэл энгийн хүмүүсийн дунд амьдруулж чадах бүрэн арилаагүй байгаа энэ жаахан үлдсэн зүйлс чамайг энгийн хүмүүсийн дунд бясалгуулна, чи өөрийнхөө эдгээр зүйлсийг муу гэдгийг нь мэдэх үед чи аль хэдийн ахиц дэвшил гаргасан гэсэн үг юм, хэрэв чи үүнээс татгалзаж чадвал өөрийгөө бясалгаж байна гэсэн үг. Гэсэн хэдий ч чи зарим зүйлийг тэр дор нь бүгдийг нь хаяж чадахгүй, учир нь тэдгээр нь бясалгалын явцад орхигдоход маш удаан хугацаа шаардагддаг зүйлс юм. Тэдгээрийг та нар ялгаж салгах хэрэгтэй. Төгс төгөлдөрт хүрэх тэр өдөр тэдгээр нь бүрэн арилах болно.

Түүнээс гадна би та нарт хэлье: бясалгал бол үнэхээр зовлонтой. Та нар энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа болохоор хувийн ашиг сонирхол, сэтгэл хөдлөлийн харилцаанд автсан зууралдсан сэтгэлээсээ салах гэж оролдох үед үүнийг мэдрэх болно. Шинэ шавь нарын хувьд ийм байдалд хараахан ороогүй байдаг тул тэдэнд тийм том эсэргүүцэл мэдрэгдэхгүй. Яагаад гэвэл хүн нүгэлтэй байдаг, нүглээс үүдэлтэй эдгээр хүчин зүйлс нь хүнийг бясалгахад нь саад болдог. Илэрдэг байдал нь: ажил дээр тулгардаг бэрхшээл, ажилдаа сэтгэл хангалуун бус байх, бусадтай зөрчилдөх, бие махбодод таагүй мэдрэмж төрөх зэргээр илэрдэг. Эдгээр бэрхшээлүүд нь ихэвчлэн гэнэт болоод маш хурцаар ирдэг. Заримдаа та нар өөрийгөө бясалгаж байгаагаа мэддэг ч тухайн зууралдсан сэтгэлээсээ салахад хэцүү юм шиг байдаг. Би үүнийг мэднэ. Гэсэн хэдий ч эцэст нь та нар бясалгалын явцад үүнийг даван туулах хэрэгтэй болно. Хүссэн ч бай, хүсээгүй ч бай, ямар ч

байсан та нар ийм зүйлийг даван туулах ёстой, чи байнга сориулж, эцэст нь тэр сэтгэлээ орхино.

Өөр нэг зүйл бий. Би та нарт хэлье: Фа-г сонсож байгаа болон Фа-г олж авсан хүмүүс бүгд магадгүй хувь тавилантай хүмүүс байгаа. Өнөөдөр миний та нарт зааж байгаа Фа бол үнэхээр өндөр түвшнийх бөгөөд миний та нарт өгсөн зүйлс бол маш өндөр түвшнийх. Та нарын бясалгал бас маш хурдтай байна, ялангуяа сүүлд Фа-г олж авсан хүмүүс—тэд одоо гүйцэж түрүүлээд зогсохгүй тэргүүлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байна. Энэ удаад АНУ-д айлчлахад надад нэг мэдрэмж төрсөн, эх газрын Хятадаас, Тайванаас, гадаадад суралцаж буй олон оюутнууд, доктор, магистер, ахмад сэхээтнүүд, профессор, шинжлэх ухааны судлаач шавь нар, эдгээр хүмүүсийн түвшин маш хурдан ахиж байна. Мэдээж тэднийг боловсролтой болохоор нь сайн гэж байгаа юм биш, харин сайн төрөлхийн суурьтай учраас тэр юм. Хэдийгээр тэд Фа-г хожим олж авсан ч, Фа-г олж авсны дараах ерөнхий ойлгох явц нь удаашралгүй байгааг би олж мэдсэн. Өмнө нь олон хүн ойлгох явцыг туулсан, аажим аажмаар дээшилсэн. Гэвч эдгээр хүмүүсийн ихэнх нь энэ явцыг туулаагүй; тэд үүнийг олж авсныхаа дараа шууд бясалгаж эхэлсэн. Тэд үүнийг хурдан ойлгоод зогсохгүй шууд орсон. Энэ нь энгийн хүний дээд боловсрол эзэмшсэнээс үүдэлтэй гэсэн үг биш, үндсэндээ төрөлхийн суурийн асуудал юм. Мэдээжийн хэрэг, Фа-г олж авсан хүмүүст хувь тавилангийн хүчин зүйлс бас байдаг.

Миний заасан Фа та нарт системтэйгээр дамжуулагдсан, бараг бүрэн илэрсэн. Өгөх ёстой бүгдийг та бүхэнд бүрэн өгсөн, түүнчлэн дээд түвшний зүйлс аль хэдийн маш өндөрт яригдсан. Дараа нь би үүнийг ахин давтан ярих юм уу эсвэл ахин дахин ярих юм бол, үүнд хөндлөнгийн үймүүлэл нөлөөлнө, учир нь миний лекцийн үг бүр ижил байх боломжгүй юм. Тэгвэл давтсан зүйлс нь та нарт тогтоож өгсөн Фа-д саад болж магадгүй юм. Тиймээс, би Фа-г дахин системтэйгээр зааж болохгүй. Хэрэв онцгой нөхцөл байдал гарахгүй л бол, миний ирээдүйд ярих зүйлс хүн төрөлхтний нийгэмд тулгарах зарим асуудал, ирээдүйтэй холбоотой зарим зүйлс байх ба энэ бүгд хүнтэй холбоотой зүйлс байх болно. Энэ үеийн бясалгалтай холбоотой зүйлс бараг бүрэн илчлэгдсэн. *Жуань Фалуньд* аль хэдийн маш өндөр түвшинд бичигдсэн. Сүүлд би өөр зарим зүйлсийн талаар бас ярьсан, цаашид тэдгээрийг мөн бичгээр эмхэтгэх болно. Гэхдээ би та бүхэнд хэлье: та бүгдийн бясалгалыг жинхэнэ удирдаж чадах нь *Жуань Фалунь* юм. Хичнээн олон ном хэвлэгдсэн ч бүгд *Жуань Фалунь-ий* дэмжин туслах номнууд байх болно. Тиймээс та нар бясалгахдаа заавал *Жуань Фалунь* энэ номыг баримтлах ёстой.

Манай сурагчид “Будда” гэдэг нэр томъёоны талаар маш бага мэдлэгтэй, Буддын талаарх ойлголт маш дутмаг байдаг. Учир нь би энэ хэдэн жилийн турш Фа-г түгээхдээ Буддын янз бүрийн давхаргын нөхцөл байдал, Будда, Бумба, Бурхад болон ерөнхийдөө орчлон ертөнцийн нөхцөл байдлын талаар

ховорхон ярьдаг байсан. Би тэдний талаар яриагүй шалтгаан нь миний заасан Фа бол маш агуу, тиймээс ямар ч тодорхой зүйлийг оруулж болохгүй, мөн ийм зүйлсийг оруулах нь зохисгүй байсан юм. Тийм ч учраас маш олон сурагч энэ талаар бага ойлголттой, мөн Будда болон дээрээс дооших янз бүрийн түвшний амь бодийн талаар маш бага мэдлэгтэй байдаг. Тэд Будда, Бодьсадва, Буддын хүрээ, Буддын ертөнцийн талаар маш бага мэддэг. Үнэн хэрэгтээ, хэрэв би Буддын бодит амьдралын талаар дэлгэрэнгүй яривал чи тэдгээрийг хүний сэтгэлгээгээр ойлгоно, энэ нь Буддаг үл хүндэтгэсэн хэрэг болно. Цаашид бясалгалын явцад та нарын дундаас олон сурагч үүнийг өөрсдөө харах болно, та нар өөрсдөө тэр хэсгээ баяжуулах болно.

Энэ орчлон ертөнц маш нарийн төвөгтэй, түүнчлэн энэ нарийн төвөгтэй байдал нь хүнийг битгий хэл, Будда, Бурхад, Бумбыг хүртэл гайхшруулдаг. Мөн хүний орчлон ертөнцийн талаарх ойлголт нь түүний оршихуйн зөвхөн нэг түвшинд хязгаарлагддаг. Би өмнө нь хэлж байсан, хүн төрөлхтний таньж ойлгосон бие бодийн гадаргуй дээр харж чадах хамгийн том ширхгүүд нь гаригууд болон Сүүн зам галагтикууд юм; багаж хэрэгслээр танигдах боломжтой хамгийн жижиг ширхгүүдэд молекул, атом, атомын цөм, нейтрон, электрон, кварк, нейтрино ордог. Үүнээс цааш юу байгаа нь мэдэгдэшгүй. Гэвч хүний эх сурвалж бие бодиос маш хол байна, амийг бүрдүүлдэг эх сурвалж бие бодиос маш маш...хол байна. Тоолшгүй зуун сая дахин, тоолшгүй зуун сая дахин, тоолшгүй зуу зуун сая дахин томруулсан ч, бас л хол юм. Тэгэхээр бичил түвшний бие бодь гэж ийм байдаг. Гэсэн хэдий ч, бие бодь бичил байх тусам, түүний эзлэхүүн бүхэлдээ улам том байдаг. Чи зөвхөн дан ганц ширхгийг харж болохгүй. Түүний нэг ширхэг нь түүний бүх эзлэхүүний зөвхөн нэг л цэг, гэхдээ энэ нь нэг бүхэл биет юм. Тэгвэл бие бодийн ширхэг хэдий чинээ бичил байх тусам, түүний бүхэл бүтэн биетийн нөгөө тал улам том байдаг; бие бодийг бүрдүүлсэн ширхэг улам том байх тусам, тэгвэл түүний давхрагын тал тэр хэрээр том байх албагүй. Хүн төрөлхтөн зөвхөн молекулуудаас бүрдэх орон зайг ойлгодог ч, үүндээ сэтгэл хангалуун байдаг, эмпирик шинжлэх ухааны янз бүрийн тодорхойлолт, томъёонд өөрсдийгөө хязгаарлаад, тэдгээрийг нэвтэлж чаддаггүй. Жишээлбэл, агаар, ус, ган, төмөр, мод, түүнчлэн хүний бие махбодь – чиний амьдарч буй орон зайн бүх зүйлс молекулуудаас бүрддэг. Чи молекулын энэ хүрээний далайд, эсвэл молекулуудаас бүрдсэн гурван хэмжээст дүрслэлд амьдарч байгаа мэт юм. Сансрын хөлөг хэр өндөрт гарсан ч молекулуудаас бүрдэх орон зайнаас хэтэрч чадахгүй; компьютер хэчнээн дэвшилтэт байсан ч хүний тархитай зүйрлэшгүй. Мэдээжийн хэрэг, энэ нь хүний нийгэм ямар ч нэвтрэлт хийгээгүй гэсэн үг биш юм; хүн төрөлхтөн аль хэдийнээ молекул, атом, кварк, тэр ч байтугай нейтрино зэргийг мэддэг болсон. Гэхдээ шинжлэх ухаан нь зөвхөн ширхэг оршиж байгаа нэг цэгийг л харсан, харин өөр өөр ширхэгүүдийн оршиж буй бүхэл талыг хараагүй. Хэрэв тэд бүхэл талыг нь харж чадвал, хүмүүс орчлон ертөнцийн бусад орон зайн орших бодит



байдлыг үнэхээр харна. Атом бол хүн төрөлхтний харж чадсан нэг ширхэг биш юм, аливаа ширхгийн хувьд, хэрэв түүнийг томруулж харж чадвал, нэг жижиг од гаригтай адил томруулж харж чадвал, атомаас бүрдэх бие бодийн дээр орших тэдгээр атомоор бүрдсэн амь бодь, бие бодь, ус, ургамал, оршиж байгаа бүх материаллаг хэлбэрийг харж болох юм. Гэвч хүн төрөлхтөн энэ цэгийг нэвтэлж чадахгүй.

Үнэндээ хүн төрөлхтөн хоёр ширхэгүүдийн дунд амьдардаг: бүх зүйлийг бүрдүүлдэг молекулууд болон бидний нүдээр харж чадах хамгийн том ширхэг болох гаригс юм. Бид молекул ширхэгүүд болон гаригсын хооронд амьдардаг. Мэдээж өнөөдөр би энэ тухай яриагүй бол эрдэмтэд үүнийг ойлгохгүй байх байсан. Хүн төрөлхтөн бас, гаригууд ч мөн адил ширхэг болохыг бодох ч үгүй байх байсан. Мөн эдгээр тоо томшгүй олон од гаригууд нь бүр ч том ширхгүүдийг бүрдүүлдэг, тэр нь янз бүрийн Сүүн зам шиг галактикууд болдог, улмаар Сүүн зам галактикууд нь орчлон ертөнцийн бүр том хүрээг бүрдүүлдэг ба энэ нь хамгийн том ширхэг бас л биш юм. Мэдээжийн хэрэг, миний яриад байгаа ойлголт та нарын сэтгэлгээг гэнэт маш өндөр түвшинд хүргэсэн байж магадгүй юм. Хэрэв чиний бие гаригсын хэмжээний ширхгүүдээс бүрдсэн бие шиг том байвал, дэлхий рүү харахад энэ нь молекул шиг харагдахгүй гэж үү? Хүн төрөлхтний бие бодийн танин мэдэхүйгээс харвал, гаригууд бол үнэхээр ширхгүүдийн давхарга юм. Энд бол макро түвшний үүднээс ярьж байна.

Хүмүүс дандаа тэнгэрт гарах тухай ярьдаг, гэхдээ тэнгэр хаана байдаг вэ? "Дээшээ" гэж хаашаа вэ? Энэ орчлон ертөнцөд үндсэндээ "дээш", "доош", "зүүн", "баруун", "урд", "хойд" гэсэн ойлголт байдаггүй. Дээш гарах нь "дээшлэх" байж болох ч, доошлох нь бас "дээшлэх" биш гэж үү? Энэ орчлон ертөнц бөөрөнхий бөгөөд Дэлхий бараг төвд нь байрладаг. Зүүн тийшээ нь дээшээ, бас баруун тийшээ нь бас дээшээ; доошоо нь дээшээ, толгойн орой нь бас л дээшээ. Улмаар энэ нь тэнгэрийн нууцад хүргэдэг. Миний саяны ярьсанчлан ширхэг нь бичил байх тусам түүний давхаргын хүрээ нь улам том байдаг. Үнэн хэрэгтээ, амь илүү бичил түвшинд очих тусам, энэ нь аль хэдийн илүү том, илүү дээд орчин байдаг: энэ нь тэнгэрт гарсан гэсэн үг юм, учир нь ширхэг бичил байх тусам түүний түвшин улам өндөр болдог. Энэ бол маш өргөн уудам ойлголтын танин мэдэхүй юм. Миний сая ярьсан орчлон ертөнцийн танин мэдэх арга нь та нарт ярьж өгсөн багахан зүйл юм—нэг орон зайн л танин мэдэх арга. Энэнээс ч илүү нарийн төвөгтэй байдаг. Мэдээж, ирээдүйд гэгээрсэн хойноо та нар өөрсдөө тэдгээрийг илүү ихээр ойлгох болно.

Тэнгэрийн бодит зүйлсийг хүмүүст хэт их үлдээж болохгүй. Үнэндээ, хүний эмпирик шинжлэх ухаан нэлээд өндөр түвшинд хөгжвөл, эсвэл хүн төрөлхтний хүрээнээс хэтэрвэл, энэ нь хүн төрөлхтөнд бүр ч аюултай байх

болно. Яагаад гэвэл хүн шинжлэх ухаан, технологийн аргаар Буддын давхаргад хүрнэ гэвэл туйлаас болохгүй, үүнийг огтоос зөвшөөрөхгүй. Хүнд эсэн бусын сэтгэл болоод хүсэл байдаг, янз бүрийн зууралдсан сэтгэлтэй байдаг, өрсөлдөн тэмцэлдэх сэтгэл, атаархах сэтгэл, шунал тачаал зэргийг, эдгээр зүйлсийг тэнгэрт аваачвал гамшиг тарина, тэгвэл Будда, Бодьсадва нартай тэмцэлдэх болно. Ёстой нэг орчлон ертөнцийн том дайн дэгдэх болно. Хүнийг энгийн хүний сэтгэлтэйгээр түүний шинжлэх ухаан, технологийг Буддын хүрээнд хүргэхийг хэзээ ч зөвшөөрөхгүй, тиймээс хүн төрөлхтний шинжлэх ухаан, технологи нь урьдаас тогтоосон замын дагуу л хөгжиж байдаг. Хэрэв тэдгээр нь хөгжлийн хэт өндөр түвшинд хүрвэл, тэдгээр нь хүн төрөлхтөнтэй хамт устах аюултай тулгарах болно. Энэ бол миний харсан байдал.

Би цааш нь энэ орон зайн талаар ярьж. Миний саяхан авч ярьсан орон зайн хэлбэрүүд нь ерөнхий танин мэдэхүйн арга юм. Эрт цагт Будда Шагжамүни ч мөн адил тодорхой хүрээний орчлон ертөнцийг хэрхэн ойлгосон талаараа ярьж байсан. Тухайлбал тэрээр хүн төрөлхтөн, Гурамсан ертөнц болон Гурамсан ертөнцийн гаднах тодорхой хүрээний бодит байдлын талаар ярьж байсан, жишээлбэл Сүмбэр уулын талаар, бас Сүмбэр уулын орших хэлбэрийн тухай ярьж байсан. Сүмбэр уул нь дөрвөн том тивээр болон хоёр том давхаргын тэнгэрээр хүрээлэгдсэн байдаг гэж ярьсан. Үнэндээ Будда Шагжамүнигийн айлдвар Хятадад дамжуулагдахад, эсвэл хятад хэл рүү хөрвүүлэхэд, мөн Энэтхэгт уламжлагдаж байх явцад бүгдэд нь алдаа гардаг байсан. Будда Шагжамүнигийн ярьсан Сүмбэр уулын “хоёр том давхаргын тэнгэр” нь үндсэндээ хоёр том давхаргын тэнгэр огт биш, харин хоёр орчлон ертөнцийн ойлголт юм, тэдгээрийг жижиг ертөнц ба хоёр дахь давхаргын орчлон ертөнц гэж ойлговол зохино.

Хоёр дахь давхаргын орчлон ертөнцийг хэрхэн ойлгох вэ? Хүн төрөлхтний мэддэг орчлон ертөнц нь тоо томшгүй олон Сүүн замын галагтикаас бүрддэг бөгөөд энэ нь хүний ойлгож чадах энэхүү орон зайн бүтцийн өнцгөөс ярьж буй л хэрэг; энэ бол бидний ихэвчлэн ярьдаг орчлон ертөнц юм. Энэ орчлон ертөнцийн тухайд, манай хүн төрөлхтөн хэзээ ч үүний зах хязгаарыг харж чадахгүй. Түүнчлэн энэ орчлон ертөнц бол сансар огторгуйн бие дэх цорын ганц орчлон ертөнц биш, мөн асар уудам сансрын биетийн хамгийн том ширхэг нь ч бас биш юм. Үүн шиг том маш олон орчлон ертөнцүүд байдаг, тэдгээр нь бүр ч том орчлон ертөнцийн хүрээг бүрдүүлдэг. Тэдгээр нь гадаргуйн бүрхүүлтэй, гэхдээ энэ нь зөвхөн арай том давхаргын ширхгийг бүрдүүлдэг. Энэ орчлон ертөнц гайхалтай асар том бөгөөд энэ нь хүний хувьд төсөөлшгүй юм. Гэсэн хэдий ч бурхдын хувьд энэ нь нэг давхаргын ширхгүүдийн өчүүхэн хэсэг л юм. Гэхдээ бүр том Будда нарын хувьд, энэ нь маш өчүүхэн тул юу ч биш юм. Сэтгэн бодох арга барил, сэтгэлгээний арга, үзэл баримтлал нь янз бүрийн хүрээнд өөр өөр байдаг.

Би сая Будда Шагжамүнигийн гэгээрч баталсан Сүмбэр уулыг дурдлаа. Энэ уул нь хүн төрөлхтний оршиж буй Сүүн зам болон нарны аймгийн хойд хэсэгт оршдог. Гэхдээ орчлон ертөнцийн хувьд "хойд" гэдэг ухагдахуун байхгүй тул тайлбарлахад бэрх юм, дэлхий ч бас эргэж байдаг. Будда Шагжамүнигийн ярьсны дагуу, бид үүнийг "хойд" гэе, ингэвэл энэ ойлголтыг та бүгд ойлгоход хялбар байх болно. Үгүй бол, би өнөөдөр тодорхой нэг байршлыг хэлсэн ч, магадгүй энэ нь маргааш өөр нэг байршил руу оччихно. Тэгэхээр Будда Шагжамүнигийн хэлсний дагуу хойд зүгт байна гэж бодъё; бид үүнийг хойд зүгт байна гэж хэлье. Энэ Сүмбэр уул хэр өндөр вэ? Сүмбэр уул нь Сүүн зам галагтикаас цааш, миний сая ярьсан энэ орчлон ертөнцийн хүрээнээс, тоо томшгүй олон галактикаас бүрдсэн тэр хүрээнээс давдаг. Та бүгд бод доо, тоолж баршгүй олон тооны галактикууд хэр том байдаг вэ? Галактикуудын хооронд бас тодорхой зай байдаг. Сүмбэр уул нь энэ орчлон ертөнцөөс хальж, хоёр дахь давхаргын орчлон ертөнцийн төв хэсэгт хүрдэг; ийм л том уул юм. Чухамдаа Сүмбэр уул нь хоорондоо холбогдсон гурван уулнаас тогтсон байдаг, энэ гурван уулыг Будда Амитаба, Бодьсадва Гуанинь, Бодьсадва Махаштамапрапта нар харгалздаг. Будда Амитаба бол энэ хүрээний тэргүүн дээд Будда юм.

Будда Шагжамүнигийн гэгээрч баталсан зүйл нь түүний талаарх хүмүүсийн ойлгодгоос маш хол давсан юм. Будда Шагжамүни өмнөх амьдралынхаа болон диваажингийн тухай олон түүхийг өгүүлж байсан. Гэсэн хэдий ч тэрээр өөрийн жинхэнэ түүхийг бүхэлд нь хэлээгүй, ялангуяа нирваалсны дараа түүнд юу тохиолдсоныг хэн ч, юу ч мэдэхгүй.

Будда болгон өөрийн гэсэн диваажинтай гэдгийг та бүгд мэднэ. Будда Амитаба Сухавати гэдэг диваажинтай. Лиули диваажинг Оточ Манал Будда удирддаг. Мөн Бадамлянхуа диваажин, мөн Гайхамшгийн диваажин байдаг. 'Есүс' болон 'орчлон ертөнцийн анхдагч тэнгэрийн дээдсийн бурхан' бас өөр өөрсдийн диваажинтай байдаг. Хүн төрөлхтөн оршдог Сүүн зам галагтикийн хязгаар дотор 100 гаруй ийм диваажин байдаг. Бас олон Будда байдаг. Будда Шагжамүни Рулай түвшинд хүрсэн Будда нарыг Ганга мөрний элсний ширхэг шиг олон байдаг гэж хэлсэн. Рулай Будда бүр нэг диваажинг удирддаг, тэгвэл бодоод үз дээ, энэ орчлон ертөнц хэр том бэ? Будда Шагжамүнигийн бууж ирсэн сүүлчийн түвшин нь орчлон ертөнцийн зургаа дахь давхарга байсан. Энэ бол асар том тоо, тэнгэрийн зургаа дахь давхарга биш, харин энэ бол орчлон ертөнцийн зургаа дахь давхарга байсан. Түүнд Дафань диваажин гэж нэрлэгддэг диваажин байдаг. Дараа нь Будда Шагжамүни хүмүүсийг аврахаар хүний нийгэмд ирсэн. Гэгээрлийн хутагт хүрснийхээ дараа дөчин есөн жилийн турш өөрийн номоо дамжуулсан, диваажин руугаа буцаагүй. Учир нь Будда Шагжамүни өөрийн хүч чадалд тулгуурлан, мөн тийм өндөр түвшнээс ирсэн ч гэсэн, зөвхөн Дэд сүнснийг л аварч чадсан, түүнчлэн бясалгагчдад нэг амьдралдаа бясалгаад их өндөр түвшинд хүрэх боломж олгож чадаагүй юм.

Одоо та бүгд Будда нар өөрсдийн гэсэн диваажинтай гэдгийг мэдлээ. Харин Будда Шагжамүни өөрийн гэсэн диваажинтай гэж хэн сонссон бэ? Хэн ч тэгж яриагүй. Будда Шагжамүни Саха диваажинд байдаг гэж ярьдаг ч Саха диваажин хаана байдаг вэ? Энэ нь Гурамсан ертөнцөд байдаг, энэ Гурамсан ертөнцөд хүмүүс бас багтдаг. Тэгвэл яагаад Буддын орон хүний ертөнцийг багтаасан вэ? Энэ асуудлаар хэн ч бодож байгаагүй. Үнэндээ Будда Шагжамүни ихэвчлэн Дафань тэнгэрт байсан. Тэр Дафаний диваажингаас ирсэн тул тэр түвшний тэнгэрийг Дафань тэнгэр гэж нэрлэсэн. Дафань тэнгэр нь хэлбэр дүрсгүй ертөнцийн хамгийн дээд тэнгэрт байдаг, энэ нь мөн Гурамсан ертөнцөд оршдог. Тэр яагаад явалгүй тэнд үлдсэн бэ? Дафа дэлгэрч эхлэхээс өмнө тэрээр Буддын сүсэгтнүүдээ харж хамгаалж байсан. Сүүлийн хоёр мянга таван зуу гаруй жилийн турш тэр үнэндээ Дафа-г дэлгэрэхийг хүлээж байсан. Будда Шагжамүнигийн бууж ирсэн эцсийн түвшин бол Дафань диваажин байсан боловч тэр тэнд үлдэхгүй. Яагаад гэвэл энэ эрин үед Дафа-г дэлгэрүүлэх соёлын үндэс суурийг тавьж, энгийн хүмүүсийн дунд асар их бэрхшээлийг туулсан тул, Дафа-д ууссаны дараа тэр бүр илүү өндөр түвшинд очих болно. Энэ бол миний та бүхэнд хэлэхийг хүссэн Шагжамүни Буддагийн үнэн байдал юм.

Маш олон хүн надаас: “Багш аа, та хэн бэ?” гэж асуудаг. Миний түүхийн хувьд бол энэ нь үнэхээр уртаас урт түүхтэй. Би янз бүрийн сансар огторгуй, өөр өөр тэнгэрийн биетүүдийг дамжин өнгөрч доош бууж ирсэн, давхаргаас давхаргад төрөл олж, хүний ертөнцөд би өөрийн биеийг олон хувааж төрсөн; амьдралын аль ч үедээ би олноор төрдөг байсан. Энэ нь асар төвөгтэй, хаанаас нь яаж ярих ч аргагүй. Би та бүгдэд маш энгийнээр ингэж хэлж болно: миний харснаар би бүхэл сансар огторгуйн орчлон ертөнцүүдийн гадна байдаг, харин бүх Бурхад, Будда, болон бүх амьд оршнолууд дотор нь оршдог.

Орчлон ертөнцөд үүсэх, тогтворжих, доройтох асуудал байдаг, энэ бол орчлон ертөнцийн оршин тогтнох хууль. Энэ орчлон ертөнцийн насжилт нь асар өндөр юм. Энэ орчлон ертөнцийн үйл явцын эхэн үед үүссэн Будда, Бумба, Бурхад бүгд асар өндөр настай тул амьдрахаас ч залхсан мэт байдаг. Цаг хугацаа туйлын урт тул энэ нь бурхдад түүхийг нь мартуулж болно. Тэр ч байтугай тэд өмнө нь ямар байснаа ч мартчихдаг. Бурхан хэдий чинээ өндөр түвшинд байна, төдий чинээ түүний цаг хугацаа удааширч, түүний хүрээ болоод эзлэхүүн нь улам бүр том байдаг. Бүр илүү өндөр түвшинд үүсэх, тогтворжих, доройтох гэсэн ойлголт маш их сунжирсан байдаг тул тухайн түвшний аминий талаар чи бодоод ч хэрэггүй - энэ нь тийм л агуу том юм. Тэгвэл бүх цаг үе, орчлон ертөнцүүдийн гадна байдаг Эзэн Будда, тоо томшгүй олон амь бодиудыг орчлон ертөнцүүдийн оршихуйн жинхэнэ утга учир нь гэж үздэг. Орчлон ертөнцийн янз бүрийн түвшинд маш олон гай гамшиг гарч байсан тул, хамгийн дээд түвшнийг эс тооцвол, ямар ч амь бодь хамгийн анхны орчлон ертөнц ямар байсныг мэддэггүй. Шинэчлэгдсэний

дараа өнгөрсөн бүх зүйл байхгүй болдог. Гэвч, хэрэв орчлон ертөнцийн доторх амь бодиудыг авч үлдээнэ гэвэл, энэ асуудлыг шийдэхэд маш хэцүү.

Орчлон ертөнц анх үүсэх үед, маш олон Бурхад орчлон ертөнцийн галавын төгсгөлийн үед гарах асуудлуудыг харсан. Эдгээр бурхад санаа зовж, өөрсдийгөө аврахыг хүссэн. Гэвч, хэрэв тэдэнд тийм өндөр түвшний агуу буян байгаагүй байсан бол, энэ асуудлыг эргүүлж чадахгүйгээс гадна тэд буцаж ч чадахгүйд хүрэх байсан. Түвшин болгоны Бурхад бүгд үүнийг хийхийг хүссэн, тиймээс түүхийн туршид маш олон бурхад энд бууж ирсэн.

Гэвч, өмнө нь орчлон ертөнцөд нэг зарчим байдаг байсан, энэ нь аль ч түвшинд түүнээс дээш амь байгаа эсэхийг мэдэхийг зөвшөөрөөгүй; бүр өндөр түвшинд ч мөн адил түүнээс дээш түвшинд амь байдаг эсэхийг мэддэггүй байсан. Ямар ч түвшний бурхад зөвхөн өөрийгөө л хамгийн дээд нь гэж ойлгодог байсан, тийм ч учраас Баруунд Есүс өөрийн эцэг Еховаг Эзэн гэж хэлсэн. Ехова бол еврей үндэстнийг бүтээсэн Эзэн юм; тэр бол еврей үндэстнийг бүтээгч. Өөрөөр хэлбэл, тэр бол цагаан арьстан еврейчүүд болон тэдний янз бүрийн доод түвшний амь бодиудын хувьд хамгийн дээрх нь юм. Гэвч бусад системд бусад үндэс угсааг бий болгосон Эзэд бас байдаг, үүнээс гадна бүр өндөр, түүнээс ч бүр өндөр, түүнээс бүр ч өндөр түвшний бурхад болон амь бодиуд байдаг. Зөвхөн доод түвшний бурхад, болон дэлхийн хүмүүс л үүнийг мэддэггүй. Бурхад ч гэсэн зөвхөн өөрсдийнхөө байгаа түвшинд л Буддын зарчмуудыг мэддэг. Тэд хамгийн эцсийн үр дүнг хараад, бүх бурхад орчлон ертөнцийн үүсэх, тогтворжих, доройтох, сүйрэх явцын аймшигт үр дагаврыг шийдвэрлэх арга замыг бодож олохыг хүссэн. Тиймээс тэд ар араасаа дэлхийд бууж ирсэн, энэ мэтээр маш олон ийм бурхад ирсэн. Зарим бурхад ийм агуу их буяныг хурааж, авралыг гүйцэлдүүлэхийг хүссэн тул тухайн түвшнийхээ орчлон ертөнцийн үүсэхээс эхлээд эцэс хүртэлх бүх зовлон зүдгүүрийг эдэлсэн. Гэхдээ тэд бүгд ижил асуудалтай тулгарсан: тэдгээрийн аль нь ч хамгийн дээд нь биш, хэрэв асуудал бүр өндөр, түүнээс ч бүр өндөр түвшинд бас гарсан бол, тэдний үндсэн хүрээ гай гамшигт бас л нэрвэгдэх болно. Тэгвэл бууж ирсэн тоо томшгүй олон бурхад ч бас ямарч үр дүнд хүрч чадахгүй устгагдана; бууж ирсэн тоо томшгүй олон бурхад энэ зангилааг тайлж чадахгүй, тэгээд буцаж ч чадахгүй. Үнэндээ ийм зүйл л болсон юм. Авралыг үзүүлэхийн зэрэгцээ дээшээ Фа-г засах явцад, би ийм маягаар ирсэн тэдний олонхыг нь Фа-д ууссаныг нь дараа хүргэж өгч, буцаасан.

Өнөөдөр миний ярьсан энэ асуудал маш өндөр түвшинд гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Будда Шагжамүни ийм нэг үг хэлсэн байдаг: ирээдүйд Майдар бурхан ирнэ. Би энэ үед ирсэн, гэхдээ би Майдар бурханы түвшинд биш.

Би бас та бүгдэд маш өндөр түвшний өөр нэг тэнгэрийн нууцыг хэлмээр байна. Би өмнө нь энэ талаар ярьж байсан. Та нарын мэддэг Рулай, Бодьсадва

гэх мэт Тэнгэрийн Будда нарын хувьд үнэндээ тэд нэг бус байдаг. Тэднийг арван жил тутамд эсвэл түүнээс бага хугацаа болгонд сольдог. Одоогийн Амитаба бол хамгийн эртнийх нь биш; Бодьсадва Гуанин ч хамгийн эртнийх биш. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, хүн төрөлхтний Гурамсан ертөнц маш нарийн төвөгтэй байдаг, [тэдгээр бурхад] Гурамсан ертөнцтэй хэтэрхий ойрхон байдаг учраас доодох муу зүйлс тэдэнд шууд нөлөөлж болдог. Мөн Будда, Бодьсадва нар хүмүүсийг авардаг тул хүмүүс Будда, Бодьсадва нарыг бүр ч их үймүүлж чаддаг. Мөн тэд хэтэрхий удаан хугацаагаар хүмүүсийг аврах гэж явбал доош унана. Тийм ч учраас тэд бидний энэ орон зайн арван жил тутамд солигдох шаардлагатай байдаг, гэвч зарим хорвоо ертөнцөд нэлээд удаан хугацаа өнгөрсөн байдаг. Арай том орон зайн доторх бодит орон зайн цаг хугацаа нь эсрэгээрээ маш хурдан байдаг. Энд арван жил өнгөрөх тутамд зарим орон зайд аль хэдийнээ арван мянган жил өнгөрсөн байдаг. Иймээс энэ байдалд Будда, Бодьсадва нар удаан байж болохгүй. Тэнгэрт нэгэн дүрэм байдаг: энэ нь тодорхой түвшинд ямар ч бурхан байсан тодорхой цаг хугацаанд солигдож байх ёстой. Зорилго нь тэднийг хамгаалах, доош унагахгүйн тулд юм.

Урьд нь хүний ертөнцийн зарим бичвэрүүдэд энэ талаар тэмдэглэгдсэн байдаг байсан, ийм тэмдэглэлүүд байдаг, гагцхүү хүмүүс ямар учиртайг нь мэддэггүй. Бодьсадва Гуанинь-ийн тухай та бүгд мэддэг биз дээ? Түүхэнд янз бүрийн тэмдэглэлүүд байдаг. Тухайлбал, Өмнөд тэнгисийн Бодьсадва Гуанинь-ий тухайд Миаожуан хааны охин бясалгалаар Бодьсадва Гуанинь болсон, Энэтхэгийн Хос морьт хүүхэд бясалгалаар Бодьсадва Гуанинь болсон гэх мэт. Тэд бүгд үнэн бодит юм; энэ нь зөвхөн тэд өөр өөр амь бодиуд л юм. “Гуанинь Бодьсадва”-гийн эх дүр бол сүр жавхлантай, гайхамшигтай, агуу нигүүлсэнгүй гэгээрэгчийн угийн дүр төрхтэй, хувиршгүй нигүүлслийн нэр юм. Бодьсадва бясалгалаар дээшлэх бүрдээ дэлхий дээрх залгамжлагчаа сонгож, тэр хүнд өөртэй нь адилхан нигүүлслийг бясалгахад нь тусалдаг; [залгамжлагч] ижил түвшинд хүрч, адилхан агуу буянтай, ижил хэмжээний бэрхшээлийг даван туулах чадвартай, ижил хүч чадалтай болдог. Тэр хүнийг Гэгээрлийн хутагт хүрэхэд Бодьсадва түүнийг аварч, өөрийгөө орлуулдаг. Будда, Бумба, Бурхадын хувьд ч мөн адил. Энэ бол урьд өмнө хамгийн чанд хамгаалагдсан тэнгэрийн нууц байсан ч өнөөдөр та бүхэнд илчиллээ.

Би яагаад та бүхэнд үүнийг хэлсэн бэ? Яагаад гэвэл би нэг асуудлыг ярихыг хүссэн учраас тэр. Шагжамүни Будда Майдар хэмээх нэрийг дурдсанаас хойш хоёр мянга гаруй жил өнгөрсөн байна, энэ хугацаанд хичнээн Майдар бурхан ирж, явсныг хэн ч мэдэхгүй! Тэдний нэг нь даавуун богцтой лам байсан, тиймээс Майдар бурхныг даавуун богцтой ламтай холбосон байдаг. Гэвч Майдар бурханы дүр төрх нь том гэдэстэй үргэлж инээж явдаг, даавуун богцтой лам шиг биш, энэ нь зөвхөн түүний хүмүүсийн дунд байх үеийн л дүр төрх байсан юм. Будда бол маш ариун бөгөөд сүр жавхлантай, тэдний ихэнх нь нэлээд залуу бөгөөд нүд булаам байдаг, учир нь тэдний түвшин өндөр байх

тусам илүү үзэсгэлэнтэй байдаг. Жинхэнэ Будда Амитаба хорин настай юм шиг харагддаг, Бодьсадва Гуанинь арван долоо, арван найман настай, Бодьсадва Махаштамапрапта арван тав, арван зургаа орчим настай харагддаг. Яагаад гэвэл хүний үзэл бодлоор дөч орчим насны хүнийг тогтвор суурьшилтай төлөвшсөн гэж үздэг, учраа ойлгодог болсон насанд хүрсэн гэж үздэг—тэдний дүр төрхийг ийм байдлаар бүтээдэг. Харин тэнгэрийн бурхны бодол нь түүний билиг ухаан, түвшний хүрээгээр тодорхойлогддог. Бурхны нигүүлсэл, билиг ухааныг насаар нь тодорхойлдоггүй. Энгийн хүмүүс үргэлж энгийн хүнийхээ ойлголтыг ашигладаг.

Тэгвэл, энэ цаг үеийн Майдар Бурхан хүртэл, өөрөөр хэлбэл [тэр дүрд байгаа хүн] намайг Фа-г дэлгэрүүлж эхлэх хүртэлх хамгийн сүүлийн Майдар Бурхан нь үнэндээ нэгэн эмэгтэй бясалгалаар Майдар бурхан болсон, гэхдээ Майдар бурхан эр хүний дүртэй байдаг. Үнэндээ эртний Энэтхэг хэлээр “Майдар” гэдэг үгийн дуудлага тухайн үед тийм ч оновчтой биш байсан бөгөөд хятад ханз хэл рүү орчуулагдахад бүр ч оновчгүй болсон. Үүнийг “Ми-Лай” эсвэл “Ми-Лэ” гэж дууддаг байсан, бас өөр дуудлагатай ч байсан. Дараа би үүнийг хэрхэн зөв дууддагийг та бүхэнд хэлж өгнө. Энэ мөчлөгийн Майдар Бурхан өөрийн үйл хэргээ дуусгах гэж байхад нь буюу яг миний гарч ирсэн үе юм, гэхдээ би тэдний түвшинд биш. Сансрын биетийн бүх бурхад намайг Буддын Фа-гаар, Буддын дүрээр бүхий л түвшний амь бодиудыг аврахаар ирснийг мэддэг, тэд ч Майдар бурхан ирсэн гэж үздэг, мөн Майдар Будда өвлөн авсан зүйлсээ надад бас дамжуулан өгсөн. Гэхдээ үндсэндээ намайг хаанаас ирснийг бурхадын хэн нь ч мэдэхгүй. Гагцхүү хүмүүсийг аврахаар дэлхийд бууж ирсэнийг минь л тэд мэддэг; түүнчлэн тэд бүгд намайг сүм хийдэд орохыг уриалсан, гэхдээ би сүм хийдэд ороогүй. Би яагаад сүм хийдэд ороогүй вэ? Учир нь би бүр том зүйл хийхийг хүссэн, бүр том зорилготой. Түүнээс гадна өнөө үед хүмүүс Буддад итгэхээ больсон, лам хуврагууд болон буддын сүсэгтнүүд дэндүү цөөхөн байна. Сүм хийдэд очдог итгэгчдийн тоо нийт хүн төрөлхтний тоотой харьцуулахад хэтэрхий бага байна. Дарма-гийн төгсгөлийн үед Буддад итгэдэггүй хүмүүс маш олон болсон. Сүм хийдэд хүмүүсийг олноор нь аварч чадахгүй, олон тооны хүн Фа-г олж авах боломжгүй болох байсан. Мөн хэрэв би сүм хийдэд үлдэх юм бол бусад шашны сүсэгтнүүдэд Фа-г олж авах магадлал бүр ч бага байх байсан. Би энэ байдлыг харсан тул сүм хийдэд орж лам хувраг болоогүй, үүний оронд энгийн хүний нийгэмд Дафа-г түгээхийг сонгосон.

Мэдээж үүнд нэг асуудал бий, энэ нь маш олон лам хувраг үүнийг яагаад ч ойлгохгүй. Миний заадаг зүйл бол Буддын зарчим, Буддын хууль гэдгийг хүмүүс мэддэг. Гэхдээ энэ нь Будда Шагжамүнигийн заасан Фа биш юм. Үнэндээ, хэрэв би биш байсан бол, өөр нэг хүн хүмүүсийг аврахаар ирсэн бол тэр ч бас Будда Шагжамүнигийн үгийг давтахгүй байх байсан; өөр хэн нэгэн ирсэн ч Будда Шагжамүнигийн заасан зүйлийг заахгүй. Тэд бүгд адилхан Буддын Фа-г заах ч, тэдгээр нь бүгд Буддын өөрсдийнх нь гэгээрч баталсан

Фа зарчмууд байх болно. Ийм л утга учиртай, ийм байдаг биш гэж үү? Өнөөгийн лам хувраг нарын орхиж чадахгүй байгаа хамгийн том төөрөгдөл бол Будда Шагжамүни л цор ганц Буддын Фа-г ярьсан, орчлон ертөнцийн цорын ганц Буддын Фа гэж итгэдэгт байгаа юм. Тэд энэ нь Буддын Фа-гийн өчүүхэн хэсэг гэдгийг, Будда Шагжамүнигийн ярьсан нь өөрийнх нь баталж гэгээрсэн хэсэг гэдгийг мэддэггүй. Түүгээр ч барахгүй Будда Шагжамүни өөрийн мэддэг Фа-гаа бүгдийг нь заагаагүй, зөвхөн хүмүүст мэдэхийг зөвшөөрсөн хэсгээ л дамжуулсан юм. Үнэндээ өмнөх зургаан Буддагийн заасан Фа-г Будда Шагжамүни ч бас давтаж заагаагүй. Харин миний энэ удаад зааж байгаа зүйл бол бүхэл орчлон ертөнцийн мөн чанар юм—Буддын Фа, Бурхадын Фа, Бумбын Фа гээд бүх Фа-гийн үндэс суурь юм.

Хэрэв Гурамсан ертөнц болон хүн төрөлхтөн Фа-цэвэрлэгээнд зохих үүргээ гүйцэтгэвэл ирээдүйн хүн төрөлхтөн хэмжээлшгүй их ерөөл адислалыг хүртэх болно. Намайг ирэх үед, маш өндөр хүрээнд миний хүссэн бүхэн бүтээгдсэн, мөн энгийн хүн болж төрөхөөр энэ дэлхий ертөнцөд ирсэн. Миний агуу буян бүх түвшнүүдийн гадна ноёрхдог. Та нар намайг энд (Гурамсан ертөнцөд) байна гэж хэлж болно, гэхдээ намайг Гурамсан ертөнцийн бүх амь бодиос хичнээн давхаргын ширхэгээр тусгаарлагдаж байгааг хэн ч мэдэхгүй. Надад орчлон ертөнцийн оршихуйг бүрдүүлдэг хамгийн анхдагч хүчин зүйлс байдаг, гэхдээ би үүний дотор байдаггүй. Би орчлон ертөнцийн бүх билиг ухааныг бүрдүүлэгч эх сурвалж боловч, би юу ч хүсдэггүй. Нөгөөтээгүүр бүх амь бодиуд орчлон ертөнцийн янз бүрийн түвшний бие бодиос бүрддэг. Та нар намайг энд байхгүй гэж ч хэлж болно, би хүний хүрээнд байдаггүй ч хүний ертөнцөд илэрдэг. Энэ бол товч бөгөөд тодорхой тайлбар юм. Ирээдүйд би энэ талаар нөхцөл байдлыг харгалзан үзэж байгаад хүмүүст хэлэх болно, гэхдээ хэт их зүйлийг илчилж болохгүй, яагаад гэвэл хүнд аль хэдийн маш их зүйлийг мэдүүлсэн. Гэсэн хэдий ч ирээдүйд олон жилийн дараа хүн төрөлхтөнд өнөөдөр болж буй бүх зүйл үлгэр домог мэт болох болно.

Та бүгд мэднэ, Хятадын засгийн газрын хамгийн их айдаг зүйл бол хүмүүс 19-р зууны сүүл үеийн “Босогчид”-ын нийгэмлэг шиг байгууллага байгуулахаас, эсвэл эсэргүүцэх вий, эрх мэдлээ булаалгах вий гэдгээс хамгийн ихээр айдаг. Бид туйлаас улс төрд орохгүй, улс төрд огт хөндлөнгөөс оролцохгүй, улс төртэй холбогдохгүй гэдгийг би олон удаа онцолж хэлж байсан. Хэрэв Ли Хонжи улс төрд оролцсон бол миний өнөөдөр тарааж байгаа зүйлс буруу номын бясалгал болно. Та нар миний хэлснийг санаж явах хэрэгтэй. Түүхэнд би, Ли Хонжи, энэ Фа-г яаж түгээсэн, та нарт энэ зүйлийг яаж хийхийг заасны дагуу, та нар үүнийг хойч үедээ мөрдүүлж сургах хэрэгтэй, үүнийг хазайлгаж огт болохгүй. Миний та нарт үлдээсэн бясалгалын хэлбэрийг хойч үеийнхэн дагах ёстой. Та бүхэн мэднэ, манай бясалгал сул удирдлагатай, мөнгөнд хүрдэггүй, цол албан тушаал гэж



байдаггүй. Бясалгагч хүн мөнгөнд хүрмэгц бүх зүйл төвөгтэй болдог. Нэр, ашиг бол хүний бясалгалын хамгийн том саад байдаг.

Мэдээж чи энгийн хүний нийгэмд байгаа болохоор амьдралын хэв маягаа авч явж болно. Чи явж мөнгө хийж болно, энгийн хүний албан тушаалтан болж болно, энгийн хүний бизнес хийж болно. Эдгээрийн аль нь ч чиний бясалгалд нөлөөлөхгүй. Энэ бол миний та нарт өгсөн бясалгалын хэлбэр юм. Бясалгалын энэ хэлбэрийн хувьд ямар ч албан тушаал гэж байхгүй, Буддын Фа-гаар мөнгө олж болохгүй, ямар ч дадлагажуулах газар мөнгө хуримтлуулж болохгүй. Энэ нь бидний бясалгалын хэлбэрт тогтсон. Ийм агуу Фа-г хүмүүст заасан нь зүгээр л гурав, таван жилийн том үйл явдал биш юм. Ирээдүйд Фа-г олж авах хүмүүс улам олон болно гэдгийг би мэднэ. Фа-г олж авах хүмүүс маш маш... олон болох болно – энэ тоо маш их байх болно. Түүнээс гадна, энэ Фа зөвхөн хүн төрөлхтөнд хамаарахгүй, зөвхөн Хятадад ч хамаарахгүй; бүх дэлхий даяар, бүр илүү олон амь бодиуд Фа-г олж авч байна. Энэ бол орчлон ертөнцийн Фа учраас хүн бүр үүнийг нандигнах нь зүйтэй.

Та нар өмнө нь үүнийг юу болохыг нь мэддэггүй байсан, ялангуяа би анх энэ Фа-г зааж эхлэхдээ чийгон бясалгалын хэлбэрээр заасан. Учир нь хүмүүст Фа-г ойлгох нэг явц хэрэгтэй байдаг, хэрэв би Фа-г ийм өндөр түвшинд гэнэт заавал бүтэшгүй байх байсан. Тэгвэл өнөөдрийн түүхэнд чийгон яагаад гарч ирснийг би та бүхэнд ярьж өгье. Энэ нь надад өнөөдөр энэ Агуу Фа-г заан түгээх замыг тавих явдал байсан юм. Чийгон багш нар учрыг нь мэддэггүй, хуурамч чийгон багш нар бүүрч үүнийг мэдэхгүй, тэд нийгэмд гай тарьсан хэвээр л байна. Харин тэдгээр зам тавих үүрэг гүйцэтгэсэн чийгон багш нар үндсэндээ үүргээ дуусгасан, тэдний зарим нь яг тэр мөчид [заахаа] зогсоох хэрэгтэй гэдгээ ойлгосон. Хэрэв тэд гарч ирж чийгон заагаагүй байсан бол, чийгон нийгэмд өргөн тараагүй байсан бол, тэгвэл би өнөөдөр гэнэт ийм өндөр түвшний Фа-г заавал, энэ нь хүмүүст ойлгогдоход маш хэцүү байх байсан. Энэ нь чийгон гарч ирсэн учир нь юм. Тиймээс би хэлдэг, одоо Дафа-д асуудал үүсгэж байгаа бүх хүмүүс сайнаар төгсөхгүй. Үнэндээ тэд аль хэдийн тамд бүртгэгдсэн; гагцхүү тэдний дэлхий дээрх амьдрал хараахан дуусаагүй байгаа юм.

Дафа-гийн дэлгэрэх явц нь олон бэрхшээлийг туулж ирсэн, маш амаргүй байсан, энэ бол ариун Фа, саад бэрхшээлтэй тулгарах нь зайлшгүй. Яагаад гэвэл зөв ариун зүйл гарч ирэхэд, бүх зөвт бус эсвэл тийм ч зөв биш зүйлс хөндөгддөг. Ямар ч саадгүй дамжсан зүйлс хорон муутай нийцдэг байх учиртай, тиймээс ямар ч төвөг гарахгүй. Зовлон бэрхшээлтэй тулгарахдаа зөвт бодол, зөвт үйлдэл байхгүй байсан бол, тэдэнд хүн төрөлхтөнд үлдээсэн үлгэр жишээ ба агуу буян байхгүй байх байсан. Бид бүгд ирээдүйд ямар ч зовлон бэрхшээлтэй тааралдсан байсан, та бүгд зөв ойлголттой байх ёстой.

Энэ орчлон ертөнцөд чөтгөр байхыг зөвшөөрдөг. Яагаад тэднийг байхыг зөвшөөрдөг вэ? Би та нарт нэг зарчим хэлье: харилцан үүсэх, харилцан харшлах нь орчлон ертөнцийн доод түвшинд, ялангуяа Гурамсан ертөнцийн зарчим юм. Яагаад харилцан үүсэх, харилцан харшлах зарчим байдаг вэ? Орчлон ертөнцийн тодорхой ойлголтын дунд түвшинд хоёр төрлийн бие бодь байдаг. Энэ хоёр бие бодь цааш хуваагдахад хоёр өөр төрлийн бие бодь болдог. Учир нь доошлох тусам гоё сайхан нь буурч дээшлэх тусам илүү үзэсгэлэнтэй болдог. Бие бодь доошоо явах тусам ялгаа нь ихэсдэг. Тэгвэл энэ хоёр төрлийн бие бодь орчлон ертөнцийн доош буух тусам, тэдгээрийн хоорондын ялгаа улам ихэсдэг, доошлох тусам ялгаа нь ихэсдэг. Тэгвэл дахиад доошлох тусам хоёр бие бодийн эсрэг тэсрэг шинж чанар илэрдэг. Тэгвэл дахиад бүр доошоо явахад тэдний эсрэг тэсрэг шинж чанар нь нилээд илэрхий болдог. Ийнхүү харилцан үүсэх, харилцан харшлах зарчим бий болдог. Дахиад цаашаа Тайжи-гийн арга, билгийн сургаал бий болдог. Дахиад цаашлаад, ялангуяа хүн төрөлхтний үе шатанд харилцан үүсэх, харилцан харшлах зарчим нэн илэрхий болдог. Буддын энэ хүрээнд ирэхэд Будда гэж яг юу вэ? Будда бол орчлон ертөнцийг хамгаалагч юм. Рулай Будда бол түүний ертөнцийн Фа хаан юм. Тэр ямар нэгэн арга барил ашиглаж удирддаггүй, харин тэр өөрийн нигүүлсэл, агуу буяныг хэрэглэдэг. Түүний бүхий л амь бодиуд түүний ертөнцийн шалгуурт нийцдэг, маш үзэсгэлэнтэй сайхан байдаг. Тэгвэл энэ хүрээнд, харилцан үүсэх, харилцан харшлах зарчмын хувьд, Будда (Фа хаан)-ын эсрэг тоглогч нь бол Чөтгөрийн хаан юм.

Чөтгөрийн хаадын тухайд та нар Тарнийн (тантрын) шашинг мэддэг биз дээ? Тарнийн шашныг энгийн хүний нийгэмд дэлгэрүүлж болохгүй, зөвхөн нууцаар бясалгаж болно гэж би олон удаа хэлж байсан. Яагаад тэр вэ? Учир нь Тантризм нь ариун гэгээрэгчийг ч бясалгаж болдог, Чөтгөрийн Хааныг ч бясалгаж болдог; Будда (Фа Хаан)-д ч бясалгаж болдог, Чөтгөрийн Хаанд ч бясалгаж болдог. Хэрэв эдгээр зүйлийг нийгэмд тараавал, та бүгд бодоод үз дээ, энэ нийгэмд ямар үр дагавар авчрах бол? Үүнд л асуудал оршиж байгаа юм. Тийм ч учраас би тарнийн шашныг нийгэмд дэлгэрүүлж болохгүй, зөвхөн сүм хийдэд л бясалгаж болно гэж үргэлж хэлдэг. Нийгэмд тараад байгаа аливаа бүгд хуурамч юм, хүмүүсийг хуурч байна. Харилцан үүсэх, харилцан харшлах зарчим энгийн хүний энэ түвшинд илрэхэд хүн байвал л сүнс байдаг. Тэд ямар ч байсан ийм байдлаар оршдог, эдгээр харилцан үйлчлэх зарчмууд нь зэрэгцэн оршдог. Гэхдээ, яг ийм эсрэг тэсрэг шинж чанар, харилцан үүсэх, харилцан харшлах зарчим байдаг учраас энэ нь энгийн хүний нийгэмд нэг байдлыг үүсгэдэг. Үүнд өнөөдөр миний түгээж буй Фа ч орно. Тодруулбал, үүнд итгэдэг хүмүүс ч байна, итгэдэггүй хүмүүс ч байна. Дэлхийн хүмүүсийн дунд сайн нь ч бий, муу нь ч бий; олон нийтийн төлөө зүтгэдэг хүмүүс ч байдаг, хувиа хичээсэн хүмүүс ч байдаг; уужим сэтгэлтэй хүмүүс ч байна, явцуу сэтгэлтэй хүмүүс байна. Эерэг ба сөрөг нь ийм л харилцан хамааралтай байдаг. Эдгээр бүх илрэл нь хүн төрөлхтний нийгмийн байдлыг илэрхийлдэг.

Энгийн хүний нийгмийн ямар ч зүйл адилхан ийм байдлаар илэрдэг, хэрэв чи ямар нэгэн сайн зүйлд хүрэхийг хүсэж байвал, үүнтэй тэнцэх хэмжээний саад бэрхшээл эсвэл ямар нэг үймүүллийг даван туулах ёстой байдаг, тэгвэл л чи тухайн зүйлийг амжилттай хийж чадна, энэ нь харилцан үүсэх, харилцан харшлах зарчмаас үүдэлтэй хязгаарлалт юм. Чухамхүү энэ зарчим байдаг учраас, мөн чөтгөрийн шинж чанарын үймүүлэл байдаг учраас чи ямар нэг зүйлийг олж авахад амаргүй байдаг. Чи ажлаа гүйцэтгэж дуусгахын тулд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байдаг. Чи үүнд хүчин чармайлт гаргаж, хөдөлмөрлөж, олон бэрхшээлийг даван туулж байж хүрэх болно. Тэгж байж л чи үүнийг нандигнана, тэгж байж л баяртай байх болно. Чи аливаа зүйлийг олж авахад хэцүү байх үед л үүнийг үнэ цэнэтэй гэдгийг мэдэрдэг, зөвхөн ялсны дараа л чи баяр баясгаланг авдаг. Хэрвээ харилцан үүсэх, харилцан харшлах зарчим байхгүй байсан бол, чөтгөрийн үймүүлэл байхгүй байсан бол, чи юу ч хийсэн дорхноо бүтнэ; хэрвээ чөтгөрийн мөн чанар оршдоггүй байсан бол чи олж авсан зүйлээ нандигнахгүй, үнэ цэнийг нь мэдрэхгүй, ялалтын дараа баяр баясгаланг мэдрэхгүй байх байсан. Бүгд бодоод үз дээ, тэгвэл амьдрал уйтгартай, утгагүй мэт санагдах болно. Юу хийсэн ч бүтээд байвал, юм хийхэд утгагүй болох болно. Хүмүүст амьдрахад утгагүй, амтгүй санагдана. Тиймээс, чи бэрхшээлийг хүсэшгүй зүйл гэж бодох боловч, энэ нь ийм нэг нөлөөг үзүүлдэг.

Зарим хүн надаас: “Багш аа, та яагаад бүх чөтгөрийг цэвэрлэж болохгүй гэж?” гэж асуудаг. Хэрэв би бүх чөтгөрийг цэвэрлэвэл та нар өнөөдөр цаашид бясалгах боломжгүй болно. Чамайг эцэст нь энэ Фа-д шийдэмгий байх эсэхийг хэн ч шалгахгүй; чөтгөрийн үймүүлэл байхгүй байсан бол, чиний зарим зууралдсан сэтгэл салахгүй байх байсан; чөтгөрийн үймүүлэл байхгүй байсан бол, чи үйлийн үрээ арилгаж чадахгүй байх байсан. Ийм л зарчимтай юм. Хүн, эд зүйл, амь бодь бүгд энэ хоёр шинж чанартай байдаг. Хүнд Буддын мөн чанар болон чөтгөрийн мөн чанарын аль аль нь байдаг. Буддын зарчмаар өөрийгөө бясалгаж байгаа цагт чи чөтгөрийн мөн чанараасаа ангижирч байна гэсэн үг. Хүн өөрийгөө сул тавьж, ямар ч ёс суртахууны хяналт байхгүй байх үед, чөтгөрийн мөн чанар нь ид оргилж байдаг. Хүмүүс бухимдаж, галзуу юм шиг хашгирч, уур уцаартай байх үед тэдний чөтгөрийн мөн чанар нь илт буцалдаг. Одоо бүх төрлийн тоо томшгүй чөтгөрүүд гарч ирж байна; тэд нийгмийн бүхий л талбарт хүмүүсийг чөтгөрийн мөн чанараа хөгжүүлэхэд нь жолоодож байна. Дүрслэх урлаг, тайзны урлаг, уран зохиолыг дур зоргоороо, зөв бодолгүйгээр туурвиж байгаа тэдгээр уран бүтээлчид галзуу солиотой мэт байдаг, тэд чөтгөрүүдээс ямар ялгаа байгаа юм? Эрэгтэй хүн урт, хачин үстэй, эр эм нь ч мэдэгдэхгүй, ийм хүнийг уран бүтээлч эсвэл хөгжимчин хүний дүр төрх гэдэг. Үнэндээ эдгээр нь бүгд чөтгөрийн мөн чанараар удирдуулсан сэтгэцийн гажуудал юм.

Ёс суртахууны хязгаарлалттай хүмүүс л Буддын мөн чанарыг харуулдаг. Тэгвэл Буддад бясалгана гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь чи чөтгөрийн мөн

чанараасаа ангижирч, Буддын мөн чанарт уусах гэсэн үг. Миний сая ярьсан зүйл бол маш өндөр түвшний, маш тодорхой зүйл юм. Би энэ хүртэл л ярья. (Удаан, урам зоригтой алга ташилт)

